

# Лиахона

**Ариун сүм: Гэр бүл  
болон зүрх сэтгэлийг  
өөрчилдөг, х. 24, 28**

**Номлол, найз нар, гэр бүл: Христийн  
Мэндэлсний Баярын гурван дурсамж,  
х. 40, 43, 44**

**Боох шаардлагагүй дөрвөн бэлэг, х. 54**

**Христийн Мэндэлсний Баярын утга  
учир, х.66**





© УОЛТЕР РЕЙН, ХУЛГААРЛАЖ БОЛӨХГҮЙ

Агуу баярын сайн мэдээ, Уолтер Рейн

*“Тэр газар хэдэн хоньчид сүргээ манаад шөнө хээр хоноглож байжээ.*

*Гэнэт Эзэний тэнгэр элч тэдний өмнө зогсож, . . .*

*Тэнгэр элч тэдэнд, Бүү айгтун, харагтун, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа.*

*“Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ” (Лук 2:8-11) гэжээ.*

2012 оны арванхоёрдугаар сарын Лиахона

## ЗАХИАСУУД

**4 Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Христийн Мэндэлсний Баярын Сүнснийг дахин нээсэн нь**  
Ерөнхийлөгч Томас С.Монсон

**7 Айлчлагч багшийн захиас бичиг: Айлчлагч багшлалт, авралын ажил**

### ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Кандис Редийн авсан Аризонын Меса ариун сүмийн гэрэл зураг Ар талд: Калифорний Өүклэнд Ариун сүмийн гэрэл зургийг Билли Линн Аллен, Австралийн Сидней Ариун сүмийн болон гэрэлтүүлгийн зургуудыг Колин Лайгертвуд.



## ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

**10 Гэрэл ба гэрчлэлийн уламжлал**  
Ахлагч Л.Том Перри  
*Есүс Христийн сайн мэдээний голт зүрх нь хувь хүмүүс болон гэр бүл юм. Сүм эдгээрийг дэмждэг билээ.*

**16 Бэрхшээлийг даван туулсан нь**  
Ахлагч Давид С.Вакстер  
*Бид бэрхшээлийг даван туулж, Их Эзэний тусламжтайгаар харанхуйгаас гарч чадна.*

**20 Бошиглогчид Христийн Мэндэлсний Баяраар**  
Лора Ф.Виллес  
*Хожмын үеийн бошиглогчдын түүхүүд Христийн Мэндэлсний Баярын уур амьсгалыг тодорхойлж байна.*

**24 Ариун өөрчлөлт**  
Аарон Л.Вест  
*Нэг гүвээ хувирч. Нэг гэр бүл өөрчлөгдсөн.*

**32 Зарлигуудыг сахьснаас ирдэг аюулгүй байдал ба амар амгалан**  
Бишоп Гари Э.Стивенсон  
*Есүс Христийн сайн мэдээнд биеллээ олдог нэг томъёолол аз жаргалд хүрэх замыг илчилдэг.*

## ХЭСГҮҮД

**8 Бид юунд итгэдэг вэ?: Есүс Христийн сайн мэдээ Бошиглогч Иосеф Смитээр дамжин сэргээгдсэн юм**

**31 Сүмд үйлчилсэн нь: Үйлчлэлээр дамжуулан Түүний хайрыг мэдэрсэн нь**  
Мишелл Вейсден

**36 Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой**

**74 Сүмийн мэдээ**

**79 Гэр бүлийн үдшийн санаанууд**

**80 Биднийг дахин уулзалт: Нарны цацраг бүлгийнхэн (Санбимчүүд), олон нийттэй харилцах ажил ба сайн мэдээний баяр баясгалан**  
Ахлагч Квинтин Л.Кук





40

#### 40 Тэд бидэнд хандан ярив: Та нарын дундах Христийн Мэндэлсний Баяр

Ахлагч Жеффри Р.Холланд

#### 43 Христийн Мэндэлсний Баярын чимэглэл ба Христтэй адил найзууд

Мэри Н.Кук

1984 оны Христийн Мэндэлсний Баяр миний амьдралд чухал эргэлтийн үе болсон юм.

#### 44 Христийн Мэндэлсний Баярын алчуур

Скотт М.Моёо

Ээж яагаад миний эгчид жил бүр алчуур өгдөг байсан юм бол?



Энэ дугаарт нуусан  
Лиахонаг олоорой.  
Санамж: Христийн  
Мэндэлсний Баярын  
чимэглэл

54



#### 28 Мөнхийн гэр бүл дээр анхаарал төвлөрүүлэхүй

Майнди Раи Фриедман

Хоёр өсвөр настны үлгэр  
жишээ тэдний эцэг эхэд  
хэрхэн тусалсан бэ?

#### 46 Асуулт, хариулт

“Найз нарыгаа Ариун  
сүмийн тухай асуухад  
өөрөө ч мэдэхгүй байж би  
юу гэж хариулах юм бэ?”

#### 48 Христэд хэрхэн бэлэг өгөх вэ?

Ерөнхийлөгч Хенри Б.Айринг

Бид Аврагчид баяр баясгалан авчрахын тулд гурван  
янзын бэлэг өгч чадна.

#### 49 Зурагт хуудас: Ирцгээ, Түүнийг Шүтэн Биширцгээ

#### 50 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Болзооны талаар юу мэдвэл зохих вэ?

Лари М.Гибсон

#### 52 Гэр бүлийнхээ ачаар

Хикари Лофтус

Эноо, Эрин, Адина нар гэр  
бүл нь тэдэнд хэчнээн чухал  
болох тухай ярьж байна.

#### 54 Боож болдоггүй бэлэгнүүд

Элиз Александрия Холмз

Боох шаардлагагүй бөгөөд  
мартагдашгүй дөрвөн бэлэг.

#### 56 Шат шатаар: 1 Коринт 15:20–22

#### 57 Номлолын талбараас: Өлссөн хүмүүсийг хооллосон нь

Даллин К.Вилкокс

#### 58 Диконууд бид хамтдаа өсч хөгжихүй

Энэ хоёр дикон өөр өөр ч гэсэн  
хамгийн багаар бодоход  
тэдэнд адил нийтлэг нэг  
зүйл бий.



60

#### 59 Онцгой гэрч: Би хэрхэн Есүс Христийн гэрч байж чадах вэ?

Ахлагч Д.Тодд Кристофферсон

#### 60 Есүст өгөх миний бэлэг

Рахел Линн Бауер

Би Есүст хайртайгаа  
хэрхэн харуулж болох вэ?  
Энэ асуултын хариуг би  
гэрээсээ олсон юм.

#### 62 Бидний хуудас

#### 63 Өөдрөг сайхан санаа

#### 64 Дэлхийн гэрэл

Кимберли Рейд

Есүсийн төрөлтийн үйл  
явдлуудыг харсан хүн бүр  
Есүс муу зүйлүүдийг бүр  
эхлэлээс зогсоож чадсан  
бол аз жаргалтай байхсан  
хэмээн бодож болох юм.

#### 66 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Есүс Христ бол Бурханы Хүү

#### 68 Христийн Мэндэлсний Баярын залбирал хариулагдсан нь

Пегги Шконкен

Пеггигийн гэр бүл Христийн  
Мэндэлсний Баяраар хоол-  
гүй байжээ.

#### 70 Бага насны хүүхдүүдэд зориулав

#### 81 Мормоны Номон дахь судрын баатрууд



## 2012 ОНЫ АРВАНХОЁРДУГААР САРЫН ДУГААР 13 NO. 6

ЛИАХОНА 10492 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хенри Б.Айринг,  
Диетер Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга:** Бойд К.Пакер,  
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,  
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,  
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,  
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

**Эрхлэгч:** Крейг А.Кардон

**Зөвлөхүүд:** Шэйн М.Боуэн, Брэдли Д.Фостер,  
Бага Кристоффел Гоулдэн, Энтони Д.Пэркинс

**Удирдах захирал:** Дэвид Т.Варнэр

**Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:**

Винсент А.Ваун

**Сүмийн сэтгүүлийн захирал:** Алан Р.Лоиборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх туслах редактор:** Ларене Портер Гаунт

**Хэвлэлийн туслах:** Мэлисса Зентено

**Редакцийн баг:** Сюзан Баррет, Раян Карр,  
Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон,  
Минди Эри Фридман, Хикари Лофтус, Лиа МкКланахан,  
Майкл Р.Моррис, Ричард М.Ромни, Паул ВанденБерг,  
Жулиа Вүүдбери

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:**

Ж.Скотт Кнудсен

**Зураглал чимэглэлийн удирдагч:** Тадд Р.Петрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жанетт Эндрюс,  
Фэй П.Андрус, С.Кимбол Ботт, Томас Чайлд, Керри  
Линн С.Херрин, Коллийн Хинкли, Эрик П.Жонсен,  
Скотт М.Моои, Брэд Тиаре

**Оюуны өмчийн зохицуулагч:** Жэйн Анн Петрс

**Хэвлэлийн захирал:** Жэйн Анн Петерс

**Хэвлэх баг:** Конни Бөүторп Бриж, Ховард Г.Браун,  
Жүүли Бурдетт, Браян У.Гиги, Катлийн Ховард,  
Дэвис Көрби, Жинни Ж.Нилсон, Таи Пилчер,  
Гэйл Тэйт Рафферти

**Хэвлэлийн захирал:** Крейг К.Седвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсен,  
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга  
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн  
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо  
барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт**  
**liahona.lds.org руу: шуудангаар Liahona, Rm. 2420,**  
**50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,**  
**USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch**  
**.org хаягаар ирүүлнэ үү.**

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол  
“луужин” буюу “залагч”) албани, англи, армен, бислам,  
болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез,  
ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва,  
малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос,  
польш, португали, румын, самоа, себуано, солонгос,  
тагало, тай, тахити, тонга, украин, унгар, урду, фижи,  
фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан),  
чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд  
нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх  
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиалан  
олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа  
Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake  
City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:  
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

**For Readers in the United States and Canada:**

December 2012 Vol. 13 No. 6. LIAHONA (USPS 311-480)  
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year  
(January, April, June, July, October, and December) by  
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North  
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price  
is \$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes.  
Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days'  
notice required for change of address. Include address label  
from a recent issue; old and new address must be included.  
Send USA and Canadian subscriptions to Salt Lake  
Distribution Center at address below. Subscription help  
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,  
American Express) may be taken by phone. (Canada Poste  
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake  
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,  
Salt Lake City, UT 84126-0368.

# Дэлгэрэнгүй мэдээллийг онлайнаас үзэж болно [Liahona.lds.org](http://Liahona.lds.org)



## НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

“Бошиглогчид Христийн Мэндэлс-  
ний Баяраар” (х.20) өгүүллийг  
уншсаны дараа та Ерөнхийлөгч  
Жорж Альберт Смитийн амьд-  
ралаас харуулсан “Нэгэн хү-  
рэм: Энэрлийн түүх” өгүүллийг  
[christmas.lds.org](http://christmas.lds.org)-т орж үзнэ үү.

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Кевин, Жаквилин хоёр (28-р хуудсыг  
үзнэ үү) бол Сан Сальвадорын Эл  
Сальвадор Ариун сүмийг онцгойлон  
адислагдахаас өмнө болсон соёлын  
үйл ажиллагаанд оролцсоноор  
адислагдсан Эл Сальвадорын хүүх-  
дүүд юм. Тэдний амьдралыг өөрчил-  
сөн оролцооны видеог үзэхийн тулд  
[lds.org/go/temple12](http://lds.org/go/temple12)-т орж үзнэ үү.

50-р хуудсан дээр, Залуу Эрэгтэй-  
чүүдийн ерөнхий ерөнхийлөгч бол-  
зооны тухай асуултуудад хариулж  
байна. Та *Залуучуудын бат бөх*  
*байдлын төлөө товхимолд* өгүүлсэн  
болзооны талаар илүү их зүйлийг  
[youth.lds.org](http://youth.lds.org)-аас үзэж болно.

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад  
материалуудыг олон хэлээр [www.languages.lds.org](http://www.languages.lds.org)-аас үзэж болно.

## ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг зааж байгаа.

**Аароны санваар, 58**

**Аз жаргал, 32**

**Айлчлагч багшлалт, 7**

**Амилуулалт, амилалт, 56, 64**

**Аравны нэг, 24**

**Ариун сүм, 24, 28, 46**

**Бошиглогчид (эш үзүүлэгчид), 8, 20**

**Бэрхшээл, 16**

**Гэр бүл, 10, 24, 28, 31, 38, 39, 44, 52, 54, 60**

**Дуулгавартай байдал, 32, 59**

**Есүс Христ, 37, 49, 56, 59, 64, 66, 73**

**Залбирал, 68**

**Золиослол, 37**

**Идэвхжүүлэлт, 28**

**Мормоны Ном, 8**

**Нинжин сэтгэл, 4, 36, 37, 44, 48, 60, 68, 70**

**Номлолын ажил, 40, 57, 80**

**Смит, Иосеф, 8, 73, 81**

**Сэргээлт, 8**

**Сүмийн түүх, 20**

**Талархал, 16, 54**

**Христийн Мэндэлсний Баяр, 4, 20, 38, 39, 40, 43, 44, 48, 49, 54, 57, 60, 66, 68**

**Хөрвөлт, 24, 32**

**Цагаатгал, 38, 39**

**Эв нэгдэл, 58**

**адислалууд, 16, 32**

**болзоо, 50**

**уламжлал, 10**

**Үйлчлэл, 4, 31, 36, 48, 54, 57**

**Үлгэр дууриал, 10**

**Үхэл, 39, 64**

Ерөнхийлөгч  
Томас С.Монсон

# Христийн Мэндэлсний Баярын Сүнснийг ДАХИН НЭЭСЭН НЬ

Олон жилийн тэртээ би залуу ахлагч байхдаа Солт Лейк хотын эмнэлэг дээр өвчтэй хүүхдүүдэд адислал өгөхөөр бусад санваартнуудын хамт дуудагдаж билээ. Бид эмнэлгийн хаалгаар ормогц гэрлэн чимэглэлээр чимсэн Христийн Мэндэлсний Баярын сүлд мод болон саглагар мөчрүүдийн нь дор нямбайлан боосон боодолтой юмс байхыг харав. Биднийг эмнэлгийн коридоруудаар явж өнгөрөхөд гар юм уу хөлөө боолгосон, зарим нь нүүрэндээ зовиуртай бяцхан хөвгүүд, охид эмчилгээний цаг нь болоогүй бололтой биднийг хараад инээмсэглэж, бидэнтэй мэндлэн зогсож байлаа.

Амаргүй өвчин туссан бололтой нэг бяцхан хөвгүүн “Таны нэр хэн бэ?” гэж надаас асуулаа.

Намайг түүнд нэрээ хэлэхэд тэр, “Та надад адислал өгөх үү?” гэж асуув.

Адислал өгөхөд жаал хүү өрөө рүүгээ эргэж явахдаа “Танд их баярлалаа” гэв.

Биднийг хэд алхтал “Монсон Ах аа, Танд Христийн Мэндэлсний Баярын мэнд хүргэе” хэмээн нөгөөх хөвгүүн чанга хэлэхийг би сонслоо. Хөвгүүний нүүрэнд ялдамхан мишээсэн инээмсэглэл тодорлоо.

Тэр хөвгүүн үнэхээр Христийн Мэндэлсний Баярын сүнсээр амьсгалж байлаа. Христийн Мэндэлсний Баярын сүнс бол зөвхөн энэ баярыг тэмдэглэж байгаа үед төдийгүй жилийн турш бид бүгдийн зүрх сэтгэл, амьдрал ахуйд байх ёстой зүйл гэдэгт би итгэдэг.

Христийн Мэндэлсний Баярын сүнс бидэнд байгаа цагт, бид жилийн энэ үед Түүний төрөлтийг тэмдэглэхдээ: “Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ” (Лук 2:11) гэсэн судрын үгсийг санадаг билээ.

Өнөө үед Христийн Мэндэлсний Баяраар бэлэг өгч тэмдэглэх нь чухал. Жилийн энэхүү онцгой үед Их Эзэн Өөртөө болон өрөөл бусдад *намайг* ямар бэлэг өгөөсэй гэж хүсэх бол? гэсэн асуултыг бид өөрөөсөө асуух нь ашигтай байж болох юм гэж би боддог.

Бидний Тэнгэрлэг Эцэг Өөртөө болон Хүүдээ дуулгавартай байдлын бэлэг барихыг бид бүгдээс хүсэн хүлээдэг гэж би боддог. Тэрээр мөн нөөц боломж, авьяас чадвараа ашиглан бусдад тусалдаг, амин хувиа хичээдэггүй, шунахай сувдаг биш, хэрүүл тэмцэл хийдэггүй байхыг биднээс хүсэх болно гэж би боддог. Түүний хайртай Хүү энэ тухай Мормоны Номонд:

“Учир нь үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ, зөрчилдөөний сүнстэй тэр нь надаас бус, харин... хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг.

“Болгоогтун, хүмүүний зүрх сэтгэлийг нэг нь нөгөөгийнхөө эсрэг уураар өдөөн хатгах нь миний сургаал бус; харин иймэрхүү зүйлүүд зайлуулагдах ёстой нь миний сургаал бөлгөө” (3 Нифай 11:29–30) хэмээн бидэнд сургасан билээ.

Цаг хугацааны бүрэн байдлын энэхүү гайхалтай эрин үед бие сэтгэл юугаа бусдад үйлчлэхэд зориулах хязгааргүй боломж бидэнд бий. Гэвч боломж дандаа бэлэн байдаггүй. Өнөөдөр баярлуулах ёстой зүрх сэтгэл, хэлэх ёстой зөлдөг үг, хийх ёстой ажил үйлс, аврах ёстой хүмүүс өдий төдий байна.

Христийн Мэндэлсний Баярын сүнсийг зүрх сэтгэлдээ шингэтэл ойлгосон нэг хүн ийн бичжээ:





*Би өөрөө Христийн Мэндэлсний  
Баярын Сүнс—*

*Би ядуусын гэр оронд зочлон, цон-  
хигор нүүртэй хүүхдүүдийг нүдээ  
бүлтийлгэн гайхахад хүргэж  
баярлуулдаг.*

*Би харамчийн гарыг тэнийлгэж, бод-  
гальд нь гэгээ оруулахаар болгодог.*

*Би настайчуудыг залуу насаа эргэн  
харж, залуу зандан үеийнх шигээ  
баяртай байхаар болгодог.*

*Би хүүхэд ахуй үеийн оргилуун сэтгэ-  
лийг хэвээр хадгалж, сайхан зүү-  
дэнд гэрэл тусган амьдруулдаг.*

*Би тусламж хэрэгтэй хүмүүст тус-  
лах ажлыг хөхүүлэн дэмжиж,  
дэлхийн нинжин сэтгэлд хүмүү-  
сийн зүрх сэтгэлийг бишрүүлэхийг  
хичээдэг.*

*Би үрэлгэн нэгнийг хайхрамжгүй,  
үрэлгэн байдлаа хормын төдийд  
ч атугай эргэцүүлэн бодож, зов-  
лон зүдгүүр тохиолдсон хайртай  
нэгэндээ юухан хээхнийг ч гэсэн*

*илгээж, уй гашуугийн нулимсыг  
нь арчихаар болгодог.*

*Би шоронгийн харанхуй өмгөр өрөөнд  
орж, сэтгэл нь шархалсан хүмүүст  
ирэх сайхан өдрүүдийн тухай са-  
нуулж сэтгэлийг нь засдаг.*

*Би өвчтэй хүнтэй, нам гүмхэн ца-  
гаан байшинд зөөлхөн орж, ярьж  
чадахгүй, зөвхөн уруул нь чичрэх  
төдий болтлоо доройтсон хүнд  
ерөөлийн үг хэлдэг.*

*Миний бие мянга мянган арга замаар  
ядарч туйлдсан дэлхийн хүмүүсийг  
өчүүхэн жижиг, ач холбогдолгүй  
зүйлсээ түр зуур ч гэсэн мартаж,  
Бурханы нүүр өөд харахаар болгодог.*

*Би өөрөө Христийн Мэндэлсний Бая-  
рын Сүнс.<sup>1</sup>*

Христийн Мэндэлсний Баяр бол Хрис-  
тийн Сүнс гэдгийг бид бүгд дахин нээх  
болтугай. ■

#### ЭШЛЭЛ

1. Э.К. Бейра, "Christmas Spirit," Жеймс С.Хьювигт,  
ed., *Illustrations Unlimited* (1988), 81.

#### ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та Ерөнхийлөгч Мон-  
сонгийн захиасыг  
айлчлан очих гэр бүлтэй  
хуваалцахдаа Христийн  
Мэндэлсний Баярын үеэр  
Их Эзэн Өөрт нь болон  
өрөөл бусдад биднийг  
өгөөсэй гэж хүсдэг бэл-  
гүүдийн талаарх түүний  
асуултанд онцгой анхаа-  
рал хандуулна уу. "Хрис-  
тийн Мэндэлсний Баяр  
бол Христийн Сүнс гэдгийг  
хэрхэн дахин нээх" тухай  
(бага насны хүүхдүүдээр  
энэ тухай зураг зуруул)  
санаа бодлоо тэмдэглэхэд  
нь гэр бүлийн гишүүдийг  
дэмж.

### Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш

Жери Р.Жакобс

Намайг том болох үед жил бүр болдог хамгийн сайхан үйл явдлуудын нэг нь Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш байв. Би гэрийнхэнтэйгээ хамт пицца хийж, Христийн Мэндэлсний Баярын магтуу дуулаад, энэ баярт зориулсан цуглаан хийдэг байлаа. Бид дууллууд болон Христийн Мэндэлсний магтууг өөрсдийн тааруухан хөгжмийн зэмсгээр дөрвөл болон эв дүй муутайхан дуулдаг байв. Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдшийг аав үргэлж сүнслэг бодол хуваалцаж өндөрлөхөд бид баярын нулимс дуслуулдаг байж билээ. Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдшээс илүү сайхан зүйл амьдралд байхгүй юм шиг л санагддаг байв.

Намайг арай том болоход ээж манай хөршийн бяцхан охин Келлийг харж ханддаг болов. Келли ээж нь ажилтай байх үеэр хичээлийнхээ дараа өдөр бүр манайд ирдэг байлаа. Келли намайг хаа л явна, дуу чимээ гарган гөлөг шиг салахгүй дагана. Патти эгч ирж охиноо аваад явахаар сая

нэг санаа амарч, манайх гэдэг айл нам гүм болдогсон.

Нэг удаа арванхоёрдугаар сард Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш ээж Патти, Келли хоёрыг манайд ирж баяр тэмдэглэхийг урихад би цочин сандарч билээ. Энэ чинь миний Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш шүү дээ. Ээж инээмсэглээд, “Тэглээ ч гэсэн юу ч өөрчлөгдөхгүй” гэв. Харин би юу болохыг сайн мэдэж байлаа. Тэр хоёр манай хамаг пиццаг идчихнэ дээ. Келли бидний дуулахыг сонсоод шоолно. Энэ удаагийн Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш ч олигтой болохгүй нь дээ гэж бодогдов.

Үдэш болоход Патти, Келли хоёр манайд ирж, бид ярилцан, инээлдэж, дууллаа. Ээжийн зөв байжээ. Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш маш сайхан болов. Тэр хоёр шөнө дунд бидэнд талархал илэрхийлээд манайхаас дурамжан явж билээ. Унтах үед зүрх сэтгэл минь хайр, талархлаар бялхан байлаа. Бусадтай хуваалцсан үед Христийн Мэндэлсний Баярын жинхэнэ үнэ цэнэтэй бэлэг багадаагүйг би тэгэхэд ойлгосон. Ийм бэлэг нь бидний өгч байгаа зүйлийг улам сайхан болгож, хэмжээг нь нэмэгдүүлдэг юм.

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

### Христийн Мэндэлсний Баярын таван бэлэг

Их Эзэн Өөрт нь болон өрөөл бусдад биднийг Өгөөсэй хэмээн хүсдэг бэлгүүдийн тухай бид бодох хэрэгтэй гэж Ерөнхийлөгч Монсон хэлсэн билээ.

Зураг дээр бусдад үйлчилж байгаа таван хүүхдийг дугуйл. Тэдний үйлдэл хэрхэн Есүст өгөх бэлэг болох вэ?





Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.



Итгэл, Гэр бүл,  
Халамж

## Айлчлагч багшлалт —авралын ажил

Айлчлагч багшлалт нь бие биедээ анхаарал халамж тавьж, заах, бие биенээ хүчирхэгжүүлэх боломжийг эмэгтэйчүүдэд олгодог үнэхээр бусдыг аврахын төлөөх ажил мөн. Эгч нар айлчлагч багшлалтаар дамжуулан Аврагчийн нэрийн өмнөөс үйлчилж, мөнх амьдралын адислалуудад бэлтгэдэг.

“Их Эзэн Өөрийн нэгэн илчлэлтэнд, бид ‘[бусдад] сануулж, тайлбарлаж, ухуулж, зааж мөн Христэд ирэхэд нь урьдаг байх ёстой’ (С ба Г 20:59) хэмээн зарлиг болгосон юм” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985) хэлжээ. Тэрээр цааш нь, “Таны гэрчлэл бол захиасыг дамжуулах чухал арга зам мөн” гэжээ.<sup>1</sup>

Айлчлагч багш нар сайн мэдээний тухай бидний мэдлэгийг нэмэгдүүлэн, бидний гэрчлэлийг бэхжүүлж, баптисм хийлгэж, гишүүнээр батлагдахад нь эгч нарыг бэлтгэдэг. Бид шинэ гишүүдэд сайн мэдээнд бүрэн идэвхтэй болоход нь тусалдаг. Бидний айлчлалт болон хайр нь замаасаа гажсан хүмүүсийг буцааж авчрахад туслан, сайн мэдээнд идэвхгүй болсон хүмүүсийн гэрчлэлийг бэхжүүлэхэд тусалдаг билээ.<sup>2</sup> Бид бас ариун сүмд явахаар дамжуулан Христэд ирэхэд нь эгч нарыг урамшуулан дэмждэг.

Ерөнхийлөгч Кимбалл айлчлагч багш нарт хандан, “Та нар хүмүүсийг аврах ажил хийх болно. Өнөөдөр Сүмд олон сайхан идэвхтэй гишүүд байгаа нь чухамдаа та нар тэдний гэр оронд айлчлан очиж, тэдэнд



ертөнцийг үзэх шинэ ойлголт, шинэ үзэл баримтлалыг төлөвшүүлсний үр дүн мөн” хэмээн хэлжээ. Та нар тэдний мэддэггүй буюу ойлгодоггүй байсан зүйлийг тэдэнд илчилж, мэдлэгийнх нь хүрээг тэлсэн юм. . . .

“Та нар зөвхөн эгч нарыг төдийгүй бас тэдний нөхөр, тэдний гэр бүлийг авардаг.”<sup>3</sup>

### Судруудаас

Сургаал ба Гэрээ 20:59; 84:106; 138:56

### Би юу хийж чадах вэ?

**1.** Нийгмийн Халамжийн Бүлэг мөнх амьдралын адислалуудад намайг хэрхэн бэлтгэдэг вэ?

**2.** Би анхаарал халамж тавьдаг хүмүүсийнхээ итгэлийг нэмэгдүүлэхийн тулд юу хийж болох вэ?

### Бидний түүхээс

Бошиглогч Иосеф Смит Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулах үед, эмэгтэйчүүд зөвхөн ядууст тусалдаг төдийгүй хүмүүсийг авардаг хэмээн хэлжээ. Тэр бас Сүмийн эмэгтэйчүүд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөнд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг гэж заажээ.<sup>4</sup> Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар бид Бошиглогч Иосеф Смитийн заасан зарчмуудыг удирдамж болгон, эмэгтэйчүүд болон тэдний гэр бүлийг Бурханы охь манлай болсон адислалуудад бэлтгэхийн төлөө хамтран ажиллаж чадна.

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–77), “Бие биедээ нигүүлсэнгүй сэтгэлээр хандаж, бат бөх итгэлтэй нь, итгэл нь сул хүмүүсийг хүч чадалтай болгоё, харж чаддаг нь харж чаддаггүйгээ удирдаж, замаа өөрсдөө харж чаддаг болгоцгооё” хэмээн хэлжээ.<sup>5</sup>

### Эшлэл

1. Спенсер В.Кимбалл, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 116.
2. Эдиза Р.Снөү, *Daughters in My Kingdom*, 83.
3. Спенсер В.Кимбалл, *Daughters in My Kingdom*, 117.
4. Иосеф Смит, *Daughters in My Kingdom*, 171–72-ыг үзнэ үү.
5. Бригам Янг, *Daughters in My Kingdom*, 107-г үзнэ үү.

ЕСҮС  
ХРИСТИЙН  
САЙН  
МЭДЭЭ

# БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТЭЭР

ДАМЖИН СЭРГЭЭГДСЭН ЮМ


Аврагч цовдуулж, Түүний Төлөөлөгчид нас эцэслэсний дараа хүмүүс сайн мэдээний зарим сургаал болон ёслолуудыг өөрчилсөн юм. Хэдийгээр олон сайн хүмүүс Есүс Христэд итгэж, Түүний сайн мэдээг ойлгож, заахыг хичээж байсан ч, сайн мэдээний үнэнүүд бүрнээрээ байх боломжгүй болжээ. Үүний уршгаар, амьд үлдсэн Христэд итгэгчдийн дунд урвалт янз бүрийн шатанд явагдсан ажээ. Тэдэнд олон үнэн байсан ч, Христийн сургаал, ёслолууд болон санваар бүрнээрээ хэнд нь ч байсангүй.

Ийнхүү үнэн алгуураар алга болно гэдгийг бидний Тэнгэрлэг Эцэг мэдэж байсан учраас Есүс Христийн бүрэн сайн мэдээг Библи-тэй зүйрлэхүйц эртний нэгэн сударт хадгалан үлдээсэн юм. 1800-гаад оны эхэн үеэр Моронай хэмээх тэнгэр элч, мөнөөх ариун судар олон зууны туршид булаастай байгаа газрыг Иосеф Смитэд зааж өгчээ. Алтан ялтсууд дээр бичигдсэн энэхүү цэдэг эртний Америк тивийн зарим оршин суугчидтай харилцсан Бурханы үйл хэргийн тухай бошиглогчдын бичээсүүдийг агууладаг. Бошиглогч Иосеф Смит Бурханы бэлэг хийгээд хүчээр эдгээр ялтсууд дээрх бичээсүүдийг орчуулсан билээ. Энэхүү цэдэг бол Мормоны Ном: Есүс Христийн бас нэгэн гэрээ юм.

Иосеф Смит Бурханы сургаалуудын тухай мэдлэгээр Мормоны Номыг орчуулсан бөгөөд Сүнс түүний багш, Мормоны Ном орчуулах математиал нь байлаа. Иосеф Смитэд асуулт гарсан үед тэр Бурханд хандан залбирахад Бурхан асуултын хариут нь түүнд илчилдэг байв. Боловсролгүй залуу Иосеф Смитэд нэн чухал үнэнүүдийг заасан энэхүү үйл явц нь Сэргээлтийн Бошиглогч болсон түүний дуудлагад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. ■

Дэлгэрэнгүй мэдээллийг *Сайн мэдээний зарчмууд* (2009), 87–93, 95–100; *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 124–28, 135–39, 170–74; Гари Ж.Көүлман, "Jesus Christ Is at the Center of the Restoration of the Gospel," *Ensign*, 1992 оны 11-р сар, 43-аас үзнэ үү.

*Бид Иосеф Смитийг Бурханы бошиглогч гэдэгт итгэхийн хамт Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү Есүс Христийг шүтэн биширдэг.*



ЗУН ТАЛААС: ТЭР ХҮНИЙГ МАГТЪЯ, ХОН ИКНООЛОН, ИОСЕФ СМТИЙН АНЖЫ ҮЭГДЭЛ, ГРЕГ ӨЙЛСОН, ХУЛБАРЛАХ БОЛОХТУЙ, ИОСЕФ СМТИ МОМНЫ НОМЫГ ОНЧУУЛЖ БАЙГАА НЬ, ДЕТЛАКСОН © 1996, ИХ ЭЗЭНИЙ БОШИГЛОГЧ, ДАВИД ЛИНДСЛИ, ХУЛБАРЛАХ БОЛОХТУЙ, МЕРЖИДЕК САНВАРЫГ СЭНГЭСЭН НЬ, ЛУЗ ЛЕМОНИ СВИНДЛ, ХУЛБАРЛАЖ БОЛОХТУЙ, ЕСҮС ХРИСТИЙН СУМ 1830 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАДСАН НЬ, ЖОЗЕФ БРИКИ, ХУЛБАРЛАЖ БОЛОХТУЙ, ХУТДҮҮДЭЭ АНГАА, ДАВИД ЛИНДСЛИ © 1983.



## Бошиглогч Иосеф Смит өгүүлсэн нь:


1. “Үнэндээ би гэрэл харсан бөгөөд тэр гэрлийн дунд хоёр Хүнийг харсан, бас тэд үнэн бодитойгоор надтай ярилцсан билээ; энэ нь үнэн хэдий ч, намайг үзэгдэл харсан хэмээн хэлсний төлөө мөрдөн хавчиж, мөн үзэн ядаж байсан юм; . . . би үүнийг мэдэх бөгөөд Бурхан ч үүнийг мэднэ гэдгийг мэднэ, би үүнийг үгүйсгэж чадахгүй, мөн үүнийг хийж зүрхлэх нь үгүй.”<sup>1</sup>



2. “Би Мормоны Номыг Бурханы хүчээр зурган бичгээс орчуулсан. Энэхүү мэдлэг дэлхийгээс алга болсон бөгөөд боловсролгүй залуу би энэхүү гайхамшгийг эзэмшиж, дэлхийн мэргэн ухаан хийгээд арваннаймдугаар зууны үеийн харанхуй бүдүүлэг байдалтай шинэ илчлэлтээр ганцаар тулалдахад хүрсэн юм.”<sup>2</sup>



3. “Би ах нарт хэлсэнчлэн Мормоны Ном бол энэ дэлхий дээрх бусад бүх номноос хамгийн зөв нь, мөн манай шашны тулгуур чулуу, түүнчлэн бусад ямар ч номноос илүүтэйгээр, түүний зааврыг мөрдсөнөөр л хүмүүн Бурханд илүү ойртох болой.”<sup>3</sup>



4. “Дэлхийн эхлэлээс хойш бүх ариун бошиглогчдын амаар яригдсан бүх зүйлсийн бүрэн байдлын эрин үе дэх сүүлчийн хаант улсын түлхүүрүүдийг. . . миний бие Мелкизедек санваарын лацдан холбогч хүчээр атгаж байгаа билээ.”<sup>4</sup> (С ба Гэрээ 27:11–12-ыг үзнэ үү.)



5. “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь шууд илчлэлтээр, . . . Бурханы таалал болон адислалуудаар, Бурханы үнэн Сүм болж үндэслэгдсэн бөгөөд Сионы зорилгыг урагш ахиулахын тулд, миний бие Түүний мутарт зэмсэг болсон билээ.”<sup>5</sup>



6. “Бидний Аврагч Амилалтынхаа дараа энэ тивд [Америк] Өөрөө хүрч ирэн Сайн мэдээг бүрнээр нь, баялаг агуулга хийгээд бүх хүчтэй нь, адислал болгон сэргээснийг [Мормоны Ном] бидэнд өгүүлдэг.”<sup>6</sup>

### ЭШЛЭЛ

1. Иосеф Смит—Түүх 1:21–25
2. Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 414.
3. *Teachings: Joseph Smith*, 64.
4. *Teachings: Joseph Smith*, 511.
5. *Teachings: Joseph Smith*, 195.
6. *Teachings: Joseph Smith*, 64.

*Жилийн энэ үеийг танай гэр бүл үүрд мөнхийн өнөр бүлийн хувьд хамтдаа цуглан, сүнслэг байдлын арвин баялаг туршлага хуримлуулдаг уламжлалт үе болгон хүлээдэг бай.*







# ГЭРЭЛ БА ГЭРЧЛЭЛИЙН УЛАМЖЛАЛ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол үнэхээр дэлхий дахины Сүм мөн. Гэвч агуу үндэстэн, Америкийн Нэгдсэн Улс бий болоогүй бол Сүм хэзээ ч өнөөдрийнх шигээ болж чадахгүй байсныг хүлээн зөвшөөрөх нь чухал. Эрх чөлөө ба шүтэн бишрэх эрхийг эрэлхийлдэг хүмүүсийн анхаарлыг татах шинэ нутгийг Их Эзэн бэлтгэсэн юм. Хувь хүмүүст ухамсрынхаа дагуу шүтэн бишрэх эрх чөлөөг нь хангаж өгөх төр засгийг байгуулах явдлыг үүргээ гэж үзсэн хүчтэй удирдагчдаар энэ нутаг адислагдсан билээ.

Нэгдсэн Улсыг үндэслэгч Эцгүүд, шүтлэг бишрэл бол хүчтэй төр засгийг төвхнүүлэх үндэс суурь мөн гэдэгт итгэж байжээ. Гэвч дэлхий дэх олон хүмүүс шүтлэг бишрэл бол улс төрийн бодлого, хууль тогтоомж, засаглалын системд чухал ач холбогдолтойг мартдаг. Жишээ нь, Нэгдсэн Улсыг үндэслэгчид шүтлэг бишрэл чухал үүрэгтэйд итгэж байсны адилаар энэ нь өнөөдөр ч гэсэн чухал үүрэгтэй байгааг олон америкчууд ойлгодоггүй. Үндэслэгч эцгүүд шүтлэг бишрэл ба ёс суртахууныг оюун ухааны дасгал гэж үзээгүй, харин сайн засаглалын болон хүн төрөлхтний аз жаргалын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн тунхагласан юм.

Нэгдсэн Улсын анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон Салах ёслол дээр хэлсэн үгэндээ энэ байр суурийг тайлбарласан юм. Тэрбээр ийн хэлжээ:

“Улс төрийн бодлогыг хөгжил цэцэглэлтэд хүргэдэг бүхий л үзэл баримтлал, хэвшин тогтсон чиг хандлагуудаас шашин, ёс суртахуун хоёр нь зайлшгүй чухал тулгуур багананууд юм. . . Ёс суртахуун шашингүйгээр оршин тогтнож чадна гэсэн үзэл бодолд хууртагдахаас болгоомжлогтун. . . Учир шалтгаан, туршлага аль аль нь шүтлэг бишрэлийн зарчмыг үгүйсгэвэл үндэсний ёс суртахуун давамгайлах болно гэж хүсэн хүлээхийг бидэнд хориглодог.

Ариун журам буюу ёс суртахуун нь олон түмний төр засгийн зайлшгүй чухал эхлэх цэг гэдэг нь туйлын үнэн юм.”<sup>1</sup>

Нэгдсэн Улс бол Мормоны Номонд зөгнөн хэлэгдсэн амлагдсан нутаг бөгөөд Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтэнд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд сүнслэг хүмүүст бурханлаг удирдамж өгөгдсөн газар юм. Америкийн Нэгдсэн Улс бий болсон нь бошиглогчид болон илчлэгдсэн мэдлэг байхгүйгээс дэлхий харанхуй байсан Их Урвалтад төгсгөлийн цэг тавьсан юм. Анхны Үзэгдлийн тэрхүү сайхан өглөө Нэгдсэн Улс үндэслэн байгуулагдсанаас хойш хэдхэн арван



*Гэр бүлийнхээ сүнсний аюулгүй байдлын ийм хувилбар төлөвлөгөө гаргахад мэдэх ёстой зүйлийг би хаанаас олж болох вэ? Би Сүмийг мөнхийн гэр бүлээ төлөвшүүлэх түшиц газар гэж үздэг.*

жилийн дараа тохиосон нь тохиолдлын хэрэг байгаагүй юм.

Анхны Үзэгдэл үнэний олон илчлэлтэд үүд хаалгыг нээсэн билээ. Бурхан тэргүүтний мөн чанарын тухай мэдлэг сэргээгдсэн юм. Шинээр орчуулагдсан энэхүү судар нь Есүс Христийн хоёрдахь гэрчлэл бөгөөд гэрээ юм. Санваарын сэргээлт нь дэлхий дээр дахин байгуулагдсан Есүс Христийн Сүмд санваарын ёслолуудыг Бурханы нэрээр Түүний хүч хийгээд эрх мэдлээр гүйцэтгэх онцгой боломжоор хүн төрөлхтнийг дахин адисалсан билээ. Бид бол сэргээгдсэн Сүмийн гишүүд байхаар адислагдсан хүмүүс.

### **Сүнсний аюулгүй байдлын төлөвлөгөө**

Сэргээгдсэн Сүмийн үй олон адислалын нэг нь амьд бошиглогчид юм. Ерөнхийлөгч Харольд Б.Лий (1899–1973) эн тэргүүнд анхаарах зүйлсийн талаар тод томруун ойлголтыг бидэнд өгсөн юм. “Туслах бүлгүүдэд бидний хийдэг ажлын ихээхэн хэсэг нь хувь хүмүүсийг төлөвшүүлэх ажлын үндэс суурийг тавих явдал байдаг. Бид ингэхдээ сүнсийг төлөвшүүлэх ёстойгоо мартах ёсгүй” хэмээн тэрээр сургажээ.<sup>2</sup>

Ерөнхийлөгч Лий эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, гэр бүлүүдийн авралд Сүмийн гүйцэтгэх үүргийг бууруулаагүй юм. Харин ч тэрээр, Есүс Христийн сайн мэдээний амин судас нь хувь хүмүүс, гэр бүл, гэр орон бөгөөд Сүмийн үйл ажиллагаа нь эдгээрийг дэмжихэд чиглэдэг гэдгийг тэрээр яруу тодоор заасан юм.<sup>3</sup> Тиймээс Сүм бол бидний хувьд мөнхийн гэр бүлүүдийг төлөвшүүлэх гол түшиц газар мөн.

Би бол Вингийнхний гэр бүлийн удмын хүн. Вингийн гэр бүлийн гишүүд өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн Нью-Ингланд дахь хуучин байшингаа одоо хүртэл эзэмшсээр байна. Энэ байшинг Эртний Цайз Байшин гэдэг. Энэ байшин Стефен Винг гэр бүлийнхээ хамт 1635 онд Америкт ирсний дараа тэдний гэр орон болжээ.

Байшингийн төв хэсгийг хамгаалалтанд зориулж барьсан гэдэг. Байшингийн хана 0.6 метр зузаан, царс модны голыг цавчиж, газар ухан суулгаж, Нью-Ингланд цайзын маягаар тусгаар хоёр ханатай барьсан ажээ. Хоёр хананы хоорондох зайг нум сум, бууны сумнаас хамгаалахын тулд элсэн чулуугаар дүүргэсэн байжээ. Цайз нь гол төв болдог байв. Вингийнхний ам бүл өсч олшрохын хэрээр анхны цайзын байшингийн хоёр талд өргөтгөл барьсан ажээ. Гэвч цайз нь хамгаалалт, толгой хоргодох найдвартай оромж хэвээр үлдсэн юм.

Бид бүгд дэлхийн нөлөөнөөс хамгаалах сүнсний аюулгүй байдлын найдвартай газруудыг бий болгох ёстой. Ийм газруудад бид гэр бүлийн гишүүдээ хамгаалан, сайн мэдээний үндсэн гол үнэт зүйлсэд аль хэдийн заналхийлж эхэлсэн дэлхийн сорилт бэрхшээлүүдийг хэрхэн даван туулахыг тэдэнд заадаг байх ёстой. Би өөдрөг үзлийг эрхэмлэдэг хүн. Иймээс дэлхийд нааштай өөрчлөлт гарна гэдэгт үргэлж итгэлтэй байдаг. Гэвч би бас аливаад бодитой ханддаг хүн. Тиймээс нааштай өөрчлөлт гарахгүй тохиолдолд баримтлах хувилбар төлөвлөгөө надад бий. Миний сүнсний аюулгүй байдлын төлөвлөгөөнд сайн ба муу зүйл



аль алиныг нь янз бүрийн арга замаар хэрэгжүүлэхээр тусгасан юм. Гэр бүлийнхээ сүнсний аюулгүй байдлын ийм хувилбар төлөвлөгөө гаргахад мэдэх ёстой зүйлийг би хаанаас олж болох вэ? Би Сүмийг мөнхийн гэр бүлээ төлөвшүүлэх түшиц газар гэж үздэг.

Ерөнхийлөгч Лий Сүмийг манай мөнхийн гэр бүлүүдийг төлөвшүүлэх түшиц газар гэж хэлснийг би хоёр үндсэн шалтгаанаар өндөр үнэлдэг. Нэгдүгээрт, энэ нь Сүм гэж юу болохыг ойлгоход надад тусалсан юм. Хоёрдугаарт, үүнтэй эн чацуу чухал зүйл бол Сүм биш болохыг би ойлгосон явдал юм.

Бошиглогч Жозеф Смит удирдагчийн үүргээ Сүмийн түшиц газар юм гэж тайлбарласан.<sup>4</sup> Мөнхийн зарчмууд нь Бурханы хаант улсын тухай сургаалуудад байдаг бөгөөд Түүний мөнхийн аз жаргалын төлөвлөгөөнд тусгалаа олсон юм. Энэхүү түшиц газар нь Сүмийн гишүүд бидний хувьд мөнхийн гэр бүлээ төлөвшүүлэхийн төлөө шударга ёсны зарчмуудыг бие биедээ зааж, бие биенээсээ суралцах болон авралын ёслолуудыг хүлээн авахын тулд цугладаг, аюулгүй газар юм.

Сүм эцэг эхчүүдийн ажлыг хийдэггүй, харин эцэг эхчүүдийн ажлыг удирддаг гэдгийг анхаарагтун. Сүм мөнхийн загварыг санал болгодог. Мөнхийн гэр бүлийг төлөвшүүлэгч бид хэрэв энэхүү мөнхийн загварын дагуу гэр бүлээ төвхнүүлбэл, хамгийн хайртай хүмүүсийнхээ төлөөх бидний хүч чармайлт тэдний аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.

Бидэнд тулгардаг сорилт бол сүнслэг байдлын хувьд хүчтэй, эсвээс бие бялдрын хувьд Эртний Цайз Байшингаас илүү хүчирхэг гэр бүлийг төлөвшүүлэхэд Сүмийг түшиц газар болгон ашиглах явдал юм. Бид үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

### Уламжлалын ач холбогдол

Гэр бүлийн уламжлал нь царс модны голыг цавчиж, газар ухан суулгаж барьсан Эртний Цайз Байшинтай адил юм гэдэгт

би итгэдэг. Гэр бүлийн уламжлалууд, баяр, төрсөн өдөр тэмдэглэдэг уламжлал, ням гарагийн болон хоолны цагийн уламжлалд хүндэтгэлтэй хандахын сацуу амьдралын явцад шинээр бий болсон нэн чухал уламжлалуудыг хөгжүүл. Эдгээр уламжлалд хүндэтгэлтэй хандаж, тэмдэглэл хөтлөн, тогтмол баримтлахыг анхаар. Залуу хүмүүс бүлгүүдэд нэгддэгийн шалтгаан нь хүн үргэлж бусад руу буюу хамт олон руу тэмүүлдэг уламжлалт сэтгэлгээтэй холбоотой болохыг судалгаа харуулж байна. Гэр бүл ч мөн л ийм юм. Жилийн энэ үеийг танай гэр бүл үүрд мөнхийн өнөр бүлийн хувьд хамтдаа цуглан, сүнслэг байдлын арвин баялаг туршлага хуримтлуулдаг уламжлалт үе болгон хүлээдэг бай.

Энэ бол энгийн хийгээд амар хялбар шийдэл юм. Ром хот ганцхан өдөр баригдаагүй шиг, гэр бүлийн уламжлалууд гэнэт бий болдоггүй. Урт удаан хугацаанд үргэлжилдэг, үндсэн уламжлалуудын сацуу тэдгээрээс салбарлан олон уламжлал гэр бүлд хэвшин тогтдог. Гэр бүлд тогтсон уламжлал нь гэр бүлийн гишүүн бүр үүрэг хариуцлага хүлээж, энэхүү үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд хүч чармайлтаа нэгтгэсэн үед л гагцхүү зохих ёсоор ажилладаг. Энэ нь гэр бүлийн гишүүд цагийг хамт өнгөрүүлж, хэрхэн хамтран ажиллахад суралцах хэрэгтэй гэсэн үг юм. Гэр бүлд ийм уламжлал тогтоход гэр бүлийн гишүүд цагийг үр ашиггүй өнгөрүүлэх явдал байхгүй болно.

Жишээ нь, ажил эрхлэлтийн тухайд гэхэд, уг ажил өдөр бүр өөрөөс тань хэчнээн цаг шаардах вэ? гэдгийг бодож үзэх ёстой. Хэрэв уг ажил өдөр 14 цаг ажиллаж, хүүхдүүдээ унтсан хойно гэртээ ирэхийг танаас шаардвал яах вэ? Ийм ажилд орохгүй байхыг би танд зөвлөж байна. Хэрэв ийм ажилд орохоор сонговол та гэр бүлтэй хамт байх арга замыг бүтээлчээр сүвэгчлэх хэрэгтэй болно. Сүмийг түшиц газраа болгох нь үүрд мөнхийн зорилгоо энэ тэргүүнд тавихыг танд сануулах болно.

Би жижиглэнгийн худалдааны бизнесийг



*Гэр бүлд тогтсон уламжлал нь гэр бүлийн гишүүн бүр үүрэг хариуцлага хүлээж, энэхүү үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд хүч чармайлтаа нэгтгэсэн үед л гагцхүү зохих ёсоор ажилладаг. Энэ нь гэр бүлийн гишүүд цагийг хамт өнгөрүүлж, хэрхэн хамтран ажиллахад суралцах хэрэгтэй гэсэн үг юм.*

*Бид Есүс Христийн бурханлагч чанарыг тунхаглаж, гэрчлэхдээ зоригтой байх ёстой. Бид Түүнийг бүх хүн төрөлхтний түүхийн хамгийн чухал Хүн байсан гэдэгт итгэдгээ бусдад мэдүүлэхийг хүсдэг билээ.*

ажил мэргэжлээ болгон сонгож авсан. Манай дэлгүүрүүд долоо хоногт зургаан өдөр өглөөний 10:00-аас оройн 10:00 хүртэл ажилладаг байлаа. Миний ердийн ажлын өдөр хамгийн багаар 10 цаг, заримдаа 12-15 цаг үргэлжилдэг байлаа. Гэвч хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлэх цаг гаргахыг үргэлж анхаарч, Сүмийг түшиц газраа болгодог байсан нь үүрд мөнхийн зорилгуудаа эн тэргүүнд тавихыг надад байнга сануулдаг байлаа.

Жишээ нь, би хүүхдүүдээ дэлгүүрт бүрэн бус цагаар ажиллуулдаг байлаа. Манай ууган охин дэлгүүрүүдэд ирж, худалдааны тайлан мэдээ, баримтуудыг шалгаж, шинэчилдэг байсан манай тайлангууд үргэлж үнэн зөв байхад, жил тутам харьцуулсан тайлан мэдээ гаргахад надад тусалдаг байв. Би хүүгээ зун

худалдааны бүртгэл тайлан хөтлүүлж, цалин өгдөг байв. Би отгон охиноо бүрэн бус цагийн кассчнаар ажиллуулахын тулд кассын машиныг хэрхэн ажиллуулахыг түүнд зааж өгсөн. Энэ бүхэн нь нэг нэгнийгээ өдөржин харж байх, долоо хоногийн нэлээд хэдэн өдөр үдийн хоолыг хамт идэх, үнэ цэнэтэй цагийг байнга хамт өнгөрүүлэх боломжийг бидэнд олгодог байв. Бидний хамт байдаг хамгийн сайхан цаг бол өдөр тутмын ажлаасаа амардаг цаг байлаа.


### **Бидний мэргэжлийн амьдралын түшиц газар**

Сүм бидний мэргэжлийн амьдралд түшиц газраар хангаж чадна гэдэгт би бас итгэдэг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид Аврагчийг болон Түүний Сүмийг төлөөлдөг билээ. Бид өөр сүмийн хэн нэгэнтэй адил хэмжээнд сайн байх нь хангалтгүй юм. Ерөнхийлөгч Жорж Альберт Смит (1870–1951) дараах үгийг хэлж, ийн сургамж өгчээ:

“Сүүлийн нэг жилийн дотор энэ нутагт [Солт Лейк хот] амьдардаг, Сүмийн гишүүн биш хэд хэдэн хүнтэй танилцаж, сайн мэдээний талаар тэдэнтэй ярилцах завшаан надад тохиосон билээ. Тэдний дунд энд хорин жил амьдарсан нэг хүн, амьдрал нь эдгээртэй болсон нэг хүн, нэг сайн иргэн, нэг гарамгай бизнесмен, бусад хүмүүст эелдэг уриалгахан ханддаг нэг хүн байлаа. Тэр хүн биднийг бусад сүмийн гишүүд шиг л сайн хүмүүс гэж боддог бөгөөд бидний хооронд ямар нэг ялгаа байдаггүй . . . хэмээн надад ярьж билээ.

Ах, эгч нар аа, энэ бол миний хувьд магтаал үг биш гэдгийг би та нарт хэлэхийг хүсч байна. Хэрэв Есүс Христийн сайн мэдээ намайг илүү сайн хүн болгоогүй бол би одоо ийм байхгүй байсан нь лавтай. Хэрэв энэ Сүм дэх манай хөршүүд Бурханы зарлигуудыг сахьснаас амьдралд нь ирсэн ашиг тусыг хараагүй бол Израилд шинэтгэл хийх хэрэгтэй байгаа нь тэр.”<sup>5</sup>

Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг





эзэмшихүйц зохистой Сүмийн гишүүн ямар ч мэргэжилтэй байлаа гэсэн бусдаас үргэлж ялгарч харагддаг байх ёстой. Бусдаас өөр байхыг хичээ. Сүмийн жишгүүдээр амьдарснаараа бусдыг гомдоохвий гэж хэзээ ч бүү санаа зов. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг эзэмшихээр зохистой амьдрах нь та нарыг үргэлж адислах бөгөөд таныг ямар ч нөхцөл байдалд, хэзээ ч гомдоход хүргэхгүй гэдгийг би та нарт амлаж байна.

### Аврагчийн Гэрлийн тухай тунгаан бодохуй

Би өдөр бүр сонин харж, уншихдаа бид өөрөө өөрсдөдөө бий болгодог хүндрэлүүдийг хараад дотор бачимдах шиг болдог. Цаг хугацаа, нөхцөл байдал өөрчлөгдөж, ээдрээ төвөгтэй болохын хэрээр, удирдах үүрэг хариуцлагын хүндийг мөрөн дээрээ амжилттай авч явах хувь хүмүүс улам цөөхөн болж байна. Дэлхий хүрдэн өөрчлөгдөж байгааг хүлээн зөвшөөрөх шаардлагатайг би өнөөгийн болон ирээдүйн удирдагч та бүхэнд сануулж байна. Өнөөдөр бидэнд тулгарч байгаа ярвигтай сорилтуудыг шийдвэрлэх чадвартай, хангалттай зоригтой удирдагчид бидэнд тулгамдсан хэрэгцээ болоод байна.

Иудейн болон Христийн шашны сургаалууд дээр суурилсан уламжлалт ёс суртахууны үндэс суурь Нэгдсэн Улс болон бусад улс үндэстнүүдэд ганхан доройтож байна. Энэхүү уламжлал нь шударга ёс, нигүүлсэнгүй сэтгэл, хүний нэр төрийг эрхэмлэн дээдлэх явдал дээр тулгуурладаг. Энэ нь хууль, дүрэм журмууд дээр биш, харин зөвт, сайн иргэн хүнд байдаг Христийн Гэрэл дээр үндэслэгддэг.

Эдгээр итгэл болон үнэт зүйлстэй санаа нэгддэг хүмүүсийн тоо буурч байгаа бол та бид үзэл бодолдоо үнэн итгэлтэй хэвээр байгаа билээ. Бид Түүнийг төлөөлнө хэмээн Аврагчтай гэрээ хийсэн хүмүүс. Бид Есүс Христийг төлөөлж, Христийн Гэрлийг амьдралдаа тусгаснаар олон ах, эгч нартаа Иудейн болон Христийн шашны

сургаалууд дээр суурилсан өв уламжлалаа санахад нь тусалж чадна.

Бид Есүс Христийн бурханлаг чанарыг тунхаглаж, гэрчлэхдээ зоригтой байх ёстой. Түүнийг бүх хүн төрөлхтний түүхэнд хамгийн чухал Хүн байсан гэдэгт итгэдгээ бусдад мэдүүлэхийг бид хүсдэг билээ. Түүний амьдрал болон сургаалууд нь ариун судрууд хэмээн бидний нэрлэдэг Библи болоод бусад номуудын амин судас нь юм. Хуучин Гэрээ Христийн мөнх бус үйлчлэлийн өмнөх үйл явдлуудыг дүрсэлдэг. Шинэ Гэрээ Түүний мөнх үйлчлэлийг дүрслэн харуулдаг бол Мормоны Ном Түүний мөнх бус үйлчлэлийн хоёр дахь гэрч болон бидэнд өгөгдсөн юм. Тэрбээр Бурханы бүх хүүхэд Түүний тухай, Түүний сургаалуудын тухай мэдэхийн тулд Өөрийн сайн мэдээг бүх хүн төрөлхтөнд тунхаглахаар дэлхийд ирсэн юм. Дараа нь Тэрбээр бидний Аврагч хийгээд Гэтэлгэгч болохын тулд амиа өргөсөн билээ. Аврал зөвхөн Есүс Христээр дамжсан үед боломжтой. Чухам иймээс бид Түүнийг бүх хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн гол хүн гэдэгт итгэдэг. Бидний мөнхийн хувь тавилан үргэлж Түүний мутарт байдаг. Түүнд итгэж, Түүнийг өөрсдийн Аврагч, Их Эзэн хэмээн хүлээн зөвшөөрөх нь агуу сайхан зүйл.

Сүмийн хийсэн, хийж байгаа болон хийж чадах бүх зүйл танай гэр бүлийн төлөө юм гэдгийг санагтун. Түүнчлэн энэ бол өөр аль нэг сүм биш, энэ бол Есүс Христийн сэргээгдсэн Сүм гэдгийг санагтун. ■

*Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр 2012 оны 1-р сарын 24-нд онцгой цугларалт дээр хэлсэн үгнээс. Англи хэлээрх бүрэн эхийг [web.byui.edu/devotionalsandspeeches](http://web.byui.edu/devotionalsandspeeches)-ээс үзнэ үү.*

### ЭШЛЭЛ

1. *Washington's Farewell Address*, хянан тохиолдуулсан Томас Аркл Кларк (1908), 14.
2. *Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* (2000), 148.
3. *Teachings: Harold B. Lee*, 148–49-ийг үзнэ үү.
4. *Сүмийн Ерөнхийлөгчдийн сургаалаас: Иоцеф Смит* (2007), 211.
5. *Teachings of Presidents of the Church: George Albert Smith* (2011), 7–8.



*Сүмийн хийсэн, хийж байгаа болон хийж чадах бүх зүйл танай гэр бүлийн төлөө юм гэдгийг санагтун. Түүнчлэн энэ бол өөр аль нэг сүм биш, энэ бол Есүс Христийн сэргээгдсэн Сүм гэдгийг санагтун.*



Ахлагч Давид С.Вакстер

Далын

# БЭРХШЭЭЛИЙГ ДАВАН ТУУЛСАН НЬ

*Бид Их Эзэний  
тусламж-  
тайгаар саад  
бэрхшээлийг  
даван туулж,  
харанхуйгаас  
элбэг дэлбэг  
гэрэл рүү гарч  
очих цаг ирэх  
болно.*

**П**арли П.Праттын зохиосон агуу дуул-  
луудын нэг нь урвалтын харанхуй  
хөшиг сэргээгдсэн үнэний гэрлээр  
хэрхэн нээгдсэн тухай ийн өгүүлдэг билээ:

*Өглөө болж, сүүдэр ариллаа;  
Хараач, Сионы туг өргөгдлөө! . . .  
Үүр цайж, гэрэлт өдөр боллоо  
Дэлхийд гайхамшиг ирлээ.*

*Бурханлаг үнэний өмнө  
Эндүүрлийн үүл ариллаа; . . .  
Алсаас ирсэн алдар суу  
Улс үндэстнүүдийг удахгүй гийгүүлнэ.<sup>1</sup>*

Төлөөлөгч Паул, “Бид бүх талаараа зов-  
дог боловч няцардаггүй. Сандардаг боловч  
цөхөрдөггүй. Хавчигддаг боловч хаягддаг-  
гүй, цохигддог боловч мөхдөггүй” (2 Коринт  
4:8–9) хэмээн гэрчилснээ тайлбарлахдаа  
гэрлийн адилтгалыг ашиглажээ.

Тэрбээр сүнсний харанхуйн ирмэг дээрээс  
хэрхэн зугтааснаа тайлбарлахдаа: “Харанхуй-  
гаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол

Есүс Христийн нүүрэн дэх Бурханы алдрын  
мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд  
гэрэлтсэн Нэгэн мөн” (2 Коринт 4:6) гэжээ.

Бидний ихэнх нь амьдралынхаа ямар  
нэгэн үед сорилт бэрхшээлтэй тулгардаг.  
Шуурга шуурч, салхи салхилан, бороо орж,  
үер буудаг. Сорилт бэрхшээл эцэс төгсгөл-  
гүй юм шиг санагдаж болно. Тодорхой бус  
ирээдүй, эргэлзээ, хүнд сорилт, гай зовлон  
бидэнд тохиолдож болно.

Бидэнд аянга цахилгаантай шуурга ч,  
аймшигт хуй салхи ч, гай зовлон ч үе үе  
тохиолдож, бидний итгэлийг мохоон, өөр-  
төө итгэх итгэлийг нурааж мэднэ. Бидэнд  
чухал юм бүхэн гэнэт үүлэн чөлөөний нар  
шиг гялсхийгээд хурууны завсраар уначих  
шиг санагдаж мэднэ. Амьдралд гарах эрс  
өөрчлөлт бидний хэвийн амьдралыг болон  
хэвшин тогтсон дадал зуршлыг эвдэж болно.

Санаандгүйгээр ажилгүй болоход энэ нь  
урт удаан хугацаанд үргэлжилж болно, бид-  
ний сонголтыг чөдөрлөн, санхүүгийн хям-  
рал биднийг мөнгөний гачигдалд оруулж





мэднэ. Олон жил зав чөлөөгүй, үр бүтээлтэй ажилласны дараа тэтгэвэрт гарах нь таагүй сэтгэгдэл, ганцаардлын мэдрэмж төрүүлж мэднэ. Бид гэнэт өвчлөх буюу тахир дутуу болбол өөрсдийгөө “гар мухар,” өрөвдөлтэй, арчаагүй амьтан боллоо хэмээн бодож болно. Ийм нөхцөл байдалд айдас биднийг хялбархан эзэмдэж, итгэлтэй хэвээр үлдэхэд хүндрэл тохиолдож мэднэ.

Би энэ бүтдийг өөрөө мэдсэн юм. Байвал зохих хэмжээнээс хоёр дахин том тархины хавдрыг авахуулах мэс заслаас эдгэрсний дараа би энэхүү мэс заслын үр дагавар болох ухаан балартан, сэтгэл санаа уймарсан хямралын үеийг даван туулсан. Би урьд өмнө нь байсан тэр хүн биш болсноо мэдсэн. Эм тан тус болсонгүй, өвчин хоёр удаа дахьсан нь санаа сэтгэлээр бүр ч унагах нь тэр. Өөрийгөө өрөвдөлтэй амьтан болж гэдгээ мэдэрч эхэллээ.

### Аз жаргалтай байна гэж бод

Тэгвэл гайхамшигт зүйлс тохиох болно. Сайн найз нар, Сүмийн итгэл хүлээсэн удирдагчид миний зовлонг ойлгож, дэмжин туслахад би урам зориг орж, тэдний зөвлөгөөг дагасан юм. Нэгэн шөнө орой болсон хойно би уйтгар гунигийн мэдрэмжээ отгон хүүтэйгээ

хуваалцахад тэрээр, “Аав аа, аз жаргал гэдэг чинь санаа сэтгэл сайхан байх явдал гэж би үргэлж боддог шүү” гэж билээ. Үнэхээр түүний зөв.

Ингээд би өөртөө ирсэн бүх адислалын төлөө байнга талархал илэрхийлэх боллоо. “Энэ төрлийн [хүнд сорилт нь] мацаг барилт, залбирлаар л гардгийг” (Матай 17:21) би өөртөө нээсэн юм.

Би хүч чадал, сэтгэл сэргээсэн хүч болоод Аврагчийн хайрыг мэдрэв. Гай зовлон, өвчин эмгэг, аюул осол намайг Христийн хайраас салгаж чадахгүй гэдгийг би Паулын үгсийн ачаар мэдсэндээ баярлаж билээ (Ром 8:35-ыг үзнэ үү).

Бид өөрсдөдөө тулгарч болох аливаа хүнд сорилт бэрхшээлийг эс хайхран, үнэнд итгэл найдвараа тавих юм бол хүч чадал, урам зоригийг олж болно. Бидний ачаа дарамт гэнэт алга болдоггүй юм аа гэхэд хөнгөрнө. Бид илүү хүчирхэг, зөв зүйлийг хийх илүү шийдвэр төгс, илүү сайн эрэгтэй, эмэгтэйчүүд болж, ёроолгүй харанхуй ангалын нөгөө талд гарч чадна.

Бид гай зовлонгийн цэвэршүүлэгч галд хатуужсанаараа ирээдүйн хүнд сорилтуудтай тулгарсан үед тэдгээрийг даван туулах хүчтэй зан төлөвийг өөртөө төлөвшүүлэх болно. Үүний үр дүнд бид бусдыг

*Бүр бидний итгэл зарим үед гичийн үрээс томгүй байсан ч, бид урагш давших ёстой. Учир нь Тэнгэрийн удирдамж биднийг хөтлөх болно. Хэрэв бид тэнгэрийн тусламжийг эрэлхийлбэл, үүнийг бүр санаанд оромгүй арга замаар хүлээн авах болно.*

дэмжиж, тэдэнд анхаарал тавихад туршлагаа ашиглаж чадна. Бидний хувийн тэвчээр хатуужлын үлгэр жишээ нь манай гэр бүлүүдэд сүнслэг нөлөө үзүүлж, бусдад итгэл найвар төрүүлж чадна. Бид ирээдүйн төлөө илүү бэлтгэлтэй болно.

Саад бэрхшээл амархан арилахгүй байж болно, харин бид үүнийг ямар ч үед даван туулахаар *сонгож болно*. Алма болон түүний хүмүүсийг аймшигтайгаар мөшгөн хавчиж байсан үед Их Эзэн тэдэнд өгсөн амлалтаа бидэнд ч бас өгсөн юм:

“Тэргүүнээ өргөцгөө мөн тайтгарагтун, учир нь надад хийсэн та нарын гэрээний тухай би мэднэ; мөн өөрийн хүмүүстэй гэрээ хийж мөн тэднийг боолчлолоос чөлөөлөх болно би.

“Мөн би та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол би түүнчлэн хөнгөвчилнө” (Мозая 24:13–14).

Түүнээс гадна, Их Эзэн, “Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар руу ирнэ” (Иохан 14:18) хэмээн мэдэгдсэн билээ.

### **Тэнгэрлэг тусламжийг эрэлхийл**

Тэнгэрлэг тусламж ил харагдахгүй байж болно. Бидэнд тохиолдож болох зарим ачаа дарамт хөнгөрөхгүй, амьдралаас алга болохыг бид тэр даруй харахгүй эсвэл мэдэхгүй байж болох юм.

Их Эзэн ийн айлдсан юм: “Тэвч болгоогтун, миний мэлмий та нарын дээр байна гэдгийг үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ. Би та нарын дунд байна мөн та нар намайг харж чадах нь үгүй болой” (С ба Г 38:7).

Мэдээж хэрэг бид өөрсдөдөө болон өрөөл бусдад үлэмж тэвчээртэй ханддаг байх хэрэгтэй. Энэ нь олонх тохиолдолд асуудал бэрхшээлийг шийдэхэд цаг хугацаа шаарддаг билээ. Бүр бидний итгэл

зарим үед гичийн үрээс томгүй байсан ч, бид урагш давших ёстой. Учир нь Тэнгэрийн удирдамж биднийг хөтлөх болно. Хэрэв бид тэнгэрийн тусламжийг эрэлхийлбэл, үүнийг бүр санаанд оромгүй арга замаар хүлээн авах болно.

Бид өөрийгөө шоовдорлогдсон хүмүүс гэж бодон гашуудахын оронд өөртөө байгаа юм бүхний төлөө талархалтай байх чадвартай болно. Гал түймэр, үер ус, далайн хар салхи зэрэг байгалийн гамшигт дэлхийн хамаг эд хөрөнгөө алдсан хүмүүс мөн ийнхүү талархлаа илэрхийлэхийг бид олонтоо сонсдог нь сонирхолтой юм. Байгалийн гамшиг бүрийн дараа тэд, “Бүр хамгийн багаар бодоход бидэнд амин чухал хэрэгтэй зүйлс байж л байна шүү дээ” гэдэг.

Паулын дараах гэрчлэл бидэнд урам зориг өгдөг билээ:

“Би ямар ч нөхцөл байдалд байсан сэтгэл хангалуун байж сурсан юм.

“Би тарчигхан байхыг ч мэднэ, элбэг дэлбэг байхыг ч мэднэ. Ямар ч нөхцөл байдалд өлсгөлөн болон цатгалан байх, дутагдах, элбэг байхын аль алины нь нууцад би суралцсан.

“Надад хүч өгөгч Түүтээр би бүгдийг хийж чадна” (Филиппой4:11–13).

“Амьдралд тохиолддог аливаа шударга бус явдлыг Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан даван туулж болно” хэмээн Миний Сайн мэдээг номло удирдамжинд бичсэн байдаг.<sup>2</sup>

Бид ямар ч нөхцөл байдалд Их Эзэний тусламжтайгаар саад бэрхшээлийг даван туулж, харанхуйгаас элбэг дэлбэг гэрэл рүү гарч очих цаг ирэх болно. ■

### **Эшлэл**

1. “The Morning Breaks (Өглөө боллоо),” *Hymns*, no. 1.
2. *Миний Сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 52.



# Хэзээ ч ганцаараа биш

Андреа Дейн Квилла-Солета

**Б**и өнгөрсөн гурван жилийн турш соригдлоо. Ямар ч асуудал бэрхшээл тохиолдсон, Бурханы тусламжгүйгээр үүнийг шийдэж чадахгүй гэдгийг би ойлгосон билээ.

Би дөнгөж 16 хүрснийхээ дараахан намарс (экзем) өвчтэй болсноо мэдсэн. Өглөө бүр толинд харахад бүх биеэр улаан тууралт гарсныг харахад маш эвгүй байдаг байлаа. Би үүнийг соригдох боломж гэж үзэн, өглөө бүр зориуд толинд хардаг байв. Би өөрөөсөө ичихийн оронд Залуу Эмэгтэйчүүдийн багш нарынхаа заадаг зүйлсийг хийхийг хичээж, өвчнөө бодох биш, харин адислалуудаа өдөр бүр тоолдог байлаа. Одоо ч гэсэн, миний арьс толбогүй тунгалаг биш ч гэсэн хөгжмийн авьяасынхаа төлөө гэр бүл, найз нөхдөдөө баярлан талархаж явдаг. Би хоёр гар, хоёр хөл, харах нүд, сонсох чихтэйдээ баярлан талархдаг. Жинхэнэ гоо үзэсгэлэн хүний гадна талд биш, дотор нь байдгийг би мэднэ.

Намарс өвчин миний сэтгэл санаанд аажмаар нөлөөлж эхэлсэн юм. Би өмнө нь байсан шигээ нөхөрсөг байхаа бас үргэлж инээмсэглэж явдгаа болив. Надад зөвлөгөө өгдөг байсан олон эмч нар намайг Христийн Мэндэлсний Баярын өмнө “тууралтгүй” болно гэдэг байсан ч, би тийм болдоггүй байлаа. Арьсны өвчнөөсөө ичдэгээ даван туулах хүч чадлын төлөө би өдөр бүр залбирдаг байлаа.

Өвчнийхөө тухай огт бодохгүй бай, арьс чинь хүний л арьс шиг хэвийн байгаа гэж боддог бай гэж хүн болгон надад хэлдэг байлаа. Гэвч ингэж бодох нь үнэхээр амаргүй байлаа. Ээж минь намайг тайтгаруулж, урам хайрлахын тулд судрын түүхүүдийг ялдамхнаар дахин дахин ярьж өгдөгсөн.

Сургаал ба Гэрээ 24:8-д, “Зовлон зүдгүүрүүдэд тэвчээртэй байгтун, учир нь чамд эдгээр нь олон байх болно; гэвч тэдгээрийг тэсвэрлэ, учир нь, харагтун, би чамтай, бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байх болно.” хэмээн өгүүлсэн байдаг. Энэ судар надад насан туршдаа дагах зөвлөгөөг өгсөн юм. Би эдгээр үгсийг судартаа тэмдэглэж, тэмдэглэлийн дэвтэртээ бас өрөөндөө бичиж тавьдаг байв. Тулгарсан хүнд сорилтоо даван туулахын төлөө чадах бүхнээ хийхэд надад урам хайрласан эдгээр шүлгүүд одоо ч миний дуртай судрууд хэвээр байгаа билээ.

Энэхүү хүнд сорилтыг тэвчих нь надад хэцүү байсан ч үүнийхээ үр дүнд би ирээдүйн сорилт бэрхшээлүүдэд илүү сайн бэлтгэгдсэн юм. Ямар ч сорилт бэрхшээл тулгарлаа гэсэн түүнийг шийдвэрлэж чадахаар намайг Тэнгэрлэг Эцэг бэлтгэсэн юм. Ямар ч асуудал бэрхшээл тохиолдсон, Бурханы тусламжгүйгээр үүнийг шийдэж чадахгүй гэдгийг би ойлгосон билээ. ■



# Бошиглогчид Христийн Мэндэлсний Баяраар



**Х**ожмын үеийн 16 бошиглогчийн амьдрал Христийн Мэндэлсний Баярын сүнсний үлгэр загвар болж, 20 зууны тэртээ Бетлехемд малын хашаанд болсон, юутай ч зүйрлүүлшгүй тэр нэгэн үйл явдал: бидний Аврагч Есүс Христийн төрөлтийг бидэнд сануулдаг билээ. Бид ялангуяа Христийн Мэндэлсний Баяраар тэдний үлгэр жишээг дагавал үргэлж зөв зүйлийг хийх болно.

## Хайрын бэлэг

Тусламж хэрэгтэй хүмүүст хайр, үйлчлэлийн бэлэг өгдөг нь Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэдэг бошиглогчдын ялгарах онцлог юм. Эдийн засгийн Их Уналтын үе 1931 онд Ерөнхийлөгч Харольд Б.Лий Ютагийн Солт Лейк хотод нэг том гадасны ерөнхийлөгч байв. Ерөнхийлөгч Лий гадасны гишүүдийнхээ хэрэгцээг судалж, тэдний хэрэгцээг шийдвэрлэхийн тулд чадах бүхнээ хийхээр шийджээ. Судалгааны дүнд гадасных нь хагасаас илүү нь буюу бараг 5000 хүмүүс, түүний дотор 10-аас доош насны бараг 1000 шахам хүүхэд бусдын тусламжаас хараат байдалтай

амьдардгийг мэдсэн ажээ. Тэрээр нэг ч хүүхэд Христийн Мэндэлсний Баярын бэлэггүй үлдэхгүйн тулд гишүүдийг тоглоом цуглуулахаар явуулж, хуучин тоглоомуудыг засч янзлах, будах болон цэвэрлэх сургалт зохион байгуулав. Мөн гадасны бүх гэр бүл Христийн Мэндэлсний Баярын зоог бэлтгэсэн байхын тулд хүнсээр хандив өргөхийг тэрээр хүссэн ажээ.<sup>1</sup> Хожим нь Төлөөлөгч болсон Ахлагч Лийгээс, үйлчлэл, золиослол, ажил хөдөлмөрийн зарчим дээр үндэслэсэн Сүмийн халамжийн хөтөлбөрийг зохион байгуулахыг хүсчээ.

Ерөнхийлөгч Томас С.Монсоныг хөвгүүн байх үед Христийн Мэндэлсний Баярын үеэр нэг найз нь “Цацагт хяруулын мах ямар амттай байдаг вэ?” гэсэн сонин асуулт асуусан гэдэг. Цацагт хяруулын мах тахианы мах шиг амттай байдаг гэж тэр хариулсан ч, хөөрхий нөгөөх найз нь цацагт хяруулын болон тахианы мах алиныг нь ч идэж үзээгүйг мэджээ. Зөвхөн үүгээр ч зогсохгүй, найзынх нь гэрт Христийн Мэндэлсний Баярын зоог



бэлтгэх юу ч байхгүй байсан гэнэ. “Ингээд би яаж тэдэнд туслах вэ? гэж толгойгоо гашилгаж эхэллээ” хэмээн Ерөнхийлөгч Монсон хэлэв. “Надад цацагт хяруул ч, тахиа ч, мөнгө ч байсангүй. Тэгтэл би хоёр молтогчин туулайтайгаа санав. Би тэр дороо найзынхаа гараас хөтөлж, туулайн тор руу хүрч очоод хоёр туулайгаа хайрцагт хийж, найздаа өгөхдөө, ‘Май, энэ хоёр туулайг ав. Яг л тахианы мах шиг амттай байдаг’ гэжээ. . . . Туулайныхаа хоосон торны хаалгыг хаах үед миний нүднээс нулимс аяндаа урсаж байлаа. Гэвч би гунигтай байсангүй. Дүрслэн өгүүлэхийн аргагүй дулаан бүлээхэн мэдрэмж зүрх сэтгэлийг минь дүүргэж билээ. Энэ удаагийн Христийн Мэндэлсний Баяр сэтгэлд хоногшин үлдсэн юм.”<sup>2</sup>



### Гэр бүлээрээ баяртайгаар уулзсан нь

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонгийн хувьд хамгийн сайхан Христийн Мэндэлсний Баяр 1923 онд Англид хийсэн хоёр жил хагасын номлолоосоо АНУ-ын Айдахогийн Витни дахь гэр бүлийн ферм дээрээ Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш гэртээ эргэж ирэхэд болсон ажээ. Тийнхүү тэрээр эцэг эх, 10 ах, эгч, дүү нартайгаа Христийн Мэндэлсний Баяраар эргэн уулзсан нь урам хайрласан, сэтгэл догдлом, мартагдашгүй үйл явдал болжээ. Бусад хүүхдүүд нь унтсаны дараа Христийн Мэндэлсний Баярын бэлтгэл ажилд тусалцуулахаар түүнийг үлдээсэн нь эцэг эхээс түүнд үзүүлсэн онцгой анхаарал байлаа. Тэрээр аав, ээж хоёртойгоо хамт ажилаж байхдаа номлолынхоо туршлагаас чимээгүйхэн хуваалцсан ажээ. Тэрээр хүүхэд ахуй үеийнхээ энэхүү “онцгой үдэш” нулимсаа барьж чадаагүй гэдэг.<sup>3</sup>

Бошиглогчдын амьдрал Христийн Мэндэлсний Баяраар гэр бүлтэйгээ хамт байхад биднийг хөхүүлэн дэмждэг. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит залуухан эцэг байхдаа Христийн Мэндэлсний нэгэн Баяраар мөнгөгүй, бүр хүүхдүүдээ ч тоглоом авах задгай мөнгөгүй байсан тухайгаа дурссан байдаг. Христийн Мэндэлсний Баярын өмнөхөн тэр гэрээсээ гарч, дэлгүүрүүдийн цонхоор харагдах сайхан юмсаар нүд хужирлан, гудамж уруудан алхаж явахдаа, тэдгээр зүйлсээс алийг нь ч худалдаж авч чадахгүйгээ мэдэж байлаа. Тэр цөхрөнгөө барах дөхөөд байсан үедээ сэтгэлийн эмзэглэлээ хөнгөвчлөхийн тулд нэгэн нууцгайхан газар олж, “хүүхэд шиг мэгшин уйлжээ.” Гэвч тэр нулимсаа арчаад гэртээ ирж, хүүхдүүдтэйгээ өдөржингөө тоглохдоо “зөвхөн

тэднийхээ төлөө л баяр баясгалантай, талархалтай байжээ”.<sup>4</sup> Христийн Мэндэлсний Баяраар хүүхдүүдээ бэлэг сэлт өгч, хоол ундаар хангаж чадаагүй ч гэсэн тэрээр аль ч аавын өгч чадах хамгийн агуу бэлэг болох хайр болон үнэт цаг заваа тэдэнд зориулсан ажээ.

Бошиглогч Иосеф Смит 1838 оны Христийн Мэндэлсний Баярыг Миссури дэх Либерти шоронд өнгөрүүлжээ. Тэрбээр хэдэн хамтран зүтгэгчийнхээ хамт задгай галын утаа уугисан, бохир, хүйтэн, газар доорх жижигхэн гянданд хоригдож байв. Тааз нь хүн босоогоороо явах боломжгүй намхан ажээ. Гэвч Христийн Мэндэлсний Баярын гэрэл гэгээт агшин түүнд тохиосон юм. Бошиглогчийн эхнэр Христийн Мэндэлсний Баярын өмнөхөн Иосефыг эргэн ирж, хэд хоножээ. Өөр нэг бэлэг гэвэл тэрээр хүү Жозеф Смит III-ыг дагуулж ирсэн явдал юм. Гэр бүлийнхээ хайрыг мэдэрсэн Иосеф Гэгээнтнүүдэд урам хайрласан дараах үгсийг гяндангаас бичсэн юм: “Бид зовлон зүдгүүр үзсэнээрээ алдар хүндийг олно. Учир нь Бурхан бидэнтэй хамт байгааг бид мэдэж байна.”<sup>5</sup>

1937 онд Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хайрт гэргий Этел нь өөд болоход түүнгүйгээр амьдралдаа дасан зохицохыг хичээж байлаа. Этел өөрийнхөө оршуулга дээр дуулж өгөхийг уянгалаг сайхан хоолойтой, ганц бие эмэгтэй Жесси Эвансаас гуйсан ажээ. Энэхүү үйл явдлаар Жесси Эванс, Жозеф Фиелдинг Смит хоёр бүр дотно танилцаж, улмаар энэ нь хайр сэтгэл болон хувирсан гэдэг. Эванс гэрлэх тухай түүний саналыг Христийн Мэндэлсний Баярын өмнөхөн хүлээн зөвшөөрчээ. Ерөнхийлөгч Смит 1937 онд Христийн Мэндэлсний Баярын бэлэг хүлээн авсан тухайгаа, “Би [Жессийг] Христийн Мэндэлсний Баярын бэлэг болгон



хүлээн аваад үүнийхээ төлөө баяртай байна” хэмээн бичжээ.<sup>6</sup> Тэд дараагийн оны дөрөвдүгээр сард гэрлэжээ.

Ерөнхийлөгч Давид О.МкКейн гэр бүлд тогтсон уламжлалуудын нэг нь тэд ач, зээ нараа “жингэнэсэн хонхтой” хос морин хөллөсөн чаргаар жил бүр зугаалуудаг байв. Ийнхүү чаргаар зугаалах нь тэдний дуртай зүйлүүдийн нэг байлаа. Ерөнхийлөгч МкКей энэ уламжлалаа 80 гаран насалтлаа үргэлжлүүлсэн ажээ. Ерөнхийлөгч МкКей даарахгүйн тулд урт, зузаан зээхэн хүрэм, том бээлий өмсдөг байжээ. Бага насны ач, зээ нар нь морин чарганд суудаг байсан бол ахмад, эгчмэд нар нь моринд хөллөсөн чарганы араас дагаж, өөрсдийнхөө чаргаар гулдаг байв. Урт удаан хугацаанд сэтгэлд хоногшин үлдсэн, Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэдэг байсан эдгээр уламжлалыг заримдаа төгөлдөр хуурын ард баярын магтуу дуулах буюу “Гэр бүлийн хайр” дууг дуулснаар өндөрлөдөг байжээ.<sup>7</sup>

### Есүс Христийн тухай гэрчлэл

Хамгийн чухал нь, Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэдэг бошиглогчдын туршлага нь Есүс Христийн тухай гэрчлэлээ өсгөн нэмэгдүүлж, энэхүү баярыг тэмдэглэх үйл ажиллагааныхаа гол төвд Түүнийг хэрхэн тавихыг бидэнд заадаг явдал юм. 1876 онд Ютагийн Сейнт Жоржийн Ариун сүм дуусах дөхөж байв. Зоорийн давхар, гол өрөө, лацдан холболтын өрөөг 1877 оны 1-р сарын 1-нд онцгойлон адислахаар төлөвлөсөн байлаа.<sup>8</sup> Ариун сүмийг онцгойлон адислахаас ердөө долоохон хоногийн өмнө болсон Христийн

Мэндэлсний Баяраар Жорж Сейнтийн олон хүмүүс ариун сүмийг дуусгахад туслахын тулд хоол, нойроо хасан байж ажилласан ажээ.

Тус ариун сүмийн анхны ерөнхийлөгчөөр үйлчилсэн Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф, Христийн Мэндэлсний Баярын өдөр хүмүүс зав чөлөөгүй ажиллаж байсныг бас 40 эмэгтэй хивс нэхэж, өдөржингөө ариун сүм дээр байсныг тэмдэглэлдээ бичжээ. Тэд хивсийг эвсэж, хөшиг татжээ.<sup>9</sup>

Тэд энэ ажлыг хугацаанд нь дуусгаж арай амжаагүй ч, Христийн Мэндэлсний Баярт үнэ цэнэтэй хөдөлмөрөө зориулсан юм. Тэд энэ ажлаар Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэжээ. Ерөнхийлөгч Вудрафф Хожмын Үеийн Гэгээнтнүүд Наувугийн ариун сүмийг орхин явахаар албадуулснаас хойш 30 жилийн дараа нэгдүгээр сарын 1-нд 2000 хүн оролцсон цуглаан дээр ариун сүмийн зарим хэсгийг онцгойлон адислах залбирлыг хэлжээ.

Дэлхийн II Дайны үед Нэгдсэн Улсын олон хот түлш хэмнэхийн тулд шөнийн цагаар гэрлээ унтраадаг байжээ. Солт Лейк хотод Солт Лейкийн Ариун сүмийн гэрэлтүүлэгч прожекторуудыг унтраадаг байв. Энэ ариун сүм харанхуй хотод олон жил харанхуй байлаа. Европт гал зогсоохыг тунхагласны дараа Ерөнхийлөгч Хебер Ж.Грант ариун сүмийн гэрэлтүүлэгч прожекторуудыг буцааж залгахыг тушаажээ.

1945 оны Христийн Мэндэлсний Баяраар Ерөнхийлөгч Жорж Альберт Смит сүнслэг нөлөө бүхий утга учиртай Христийн Мэндэлсний Баярын ил захидал



гаргахаар төлөвлөсөн аж. Картны нүүрэн тал дээр, тэнгэр элч Моронайн дүрс бүхий гүн хөх суурин дээр гэрэлтэн харагдах Солт Лейкийн Ариун сүмийн зүүн талын гурван шовх ганжирын гэрэл зураг байжээ. Доод талд нь “Христийн Мэндэлсний Баяр—1945” гэсэн үгс, “Гэрлийг дахин залгав” гэсэн захиас байжээ.<sup>10</sup> Өдий олон жил үргэлжилсэн үхэл хагацал, устгал сүйрлийн дараа хүн болгонд баяр баяслыг өөр юу ч ийн өдөөж чадахгүй байсан биз ээ.

Харин Христийн Мэндэлсний Баярын энэхүү гоё ил захидал Есүс Христ болон Сайн мэдээний Сэргээлтийн тухай гэрчлэлээ хэлэх Ерөнхийлөгч Смитийн бас нэгэн арга зам болсон юм. Дайн дууссан нь харанхуй газруудад энх тайван ба гэрлийг авчирсан лугаа адил олон зууны туршид үргэлжилсэн Урвалтын дараах Сайн мэдээний Сэргээлт нь дэлхийн бүх хүмүүст үнэний гэрлийг “дахин” авчирсан билээ.

Хожмын үеийн бошиглогчдын хайр, үйлчлэл, итгэл, золиослолын үлгэр жишээ, Христийн Мэндэлсний Баярын үед жинхэнэ баяр баясгалан нь амьд Христээр дамжин ирдгийг бидэнд гэрчилдэг билээ. Ерөнхийлөгч Ховард В.Хантер, “Христийг амьдралдаа хүч чадал өгөгч, эрчимтэй хөдөлгөгч хүч болгосон хүнд л жинхэнэ Христийн Мэндэлсний Баяр ирдэг. Христийн Мэндэлсний Баярын жинхэнэ сүнс нь Эзэний амьдрал, үүрэг зорилгод оршино” хэмээн хэлжээ.<sup>11</sup> ■

#### ЭШЛЭЛ

1. Лаппи К.Портр, “Remembering Christmas Past,” *BYU Studies*, боть 40, no. 3 (2001): 94–96-г үзнэ үү.
2. Томас С.Монсон, “Christmas Gifts, Christmas Blessings,” *New Era*, 1986 оны 12-р сар, 7.
3. Портр, “Remembering Christmas Past,” 104–5-ыг үзнэ үү.
4. Жозеф Ф.Смит, “Christmas and New Year,” *Improvement Era*, 1919 оны 1-р сар, 267.
5. Жозеф Смит, in Porter, “Remembering Christmas Past,” 53
6. Жозеф Филдинг Смит, in Joseph Fielding Smith Jr., Жон Ж.Стюарт, *The Life of Joseph Fielding Smith* (1972), 255.
7. Давид Лоренс МакКей, *My Father, David O. McKay* (1989), 70–71-ийг үзнэ үү.
8. Ютагийн Сейнт Жоржийн дууссан Ариун сүмийн эцсийн онцгойлон адислалт дөрвөн сарын дараа 1877 оны дөрөвдүгээр сарын 6–8-нд болжээ.
9. *Wilford Woodruff's Journal*, эмхтгэсэн Скотт Г.Кенни, 9 ботийг үзнэ үү. (1983–85), 7:297.
10. Альберт Л.Зобелл Бага., “It Being Christmas,” *Improvement Era*, 1949 оны 12-р сар, 826–27-г үзнэ үү.
11. *The Teachings of Howard W. Hunter*, эмхтгэсэн Клайд Ж.Виллямс (1997), 269.



# АРИУН ӨӨРЧЛӨЛТ

*Сан Сальвадорын Эл Сальвадор Ариун сүмийг зөвхөн хотын төрх байдлыг өөрчлөхийн тулд бариагүй юм. Харин үүний нөлөө нь хүмүүс, гэр бүлүүд болон бүхэл үндэстнийг өөрчлөхөд оршино.*

## Өндөр довыг өөрчилсөн нь

**2008** оны 9-р сарын 20-нд ойролцоогоор 600 Хожмын Үеийн Гэгээнтэн Сан Сальвадорын Эл Сальвадор хот дахь бороонд нэвт норсон өндөр дов дээр цуглажээ. Тэд олон жилийн туршид тариалангийн талбай болгон ашиглаж байсан газар дээр зогсож байлаа. Тэд Төв Америкийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн удирдлага дор хамтдаа залбирч, гэрчлэлийн үгсээ хуваалцсан ажээ. Тэдний зарим нь энэхүү сонгосон газар дээр удахгүй ирэх өөрчлөлтийн үндсийг тавин,

газрын хөрсийг шинэхэн хүрээр гишгэлээ.

2011 оны наймдугаар сарын 21-нд сэтгэл нь догдосон мянга, мянган Хожмын Үеийн Гэгээнтэн мөнөөх өндөр дов дээр бие биедээ баяр хүргэн мэндчилж байлаа. Энэ дов тариалангийн талбай байхаа больж, Эл Сальвадор дахь хамгийн ариун газар болж хувирчээ. Гэгээнтнүүд ариун сүмийн эргэн тойронд цуглаж, ариун сүмийг Их Эзэнд зориулан онцгойлон адислах Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч, бошиглогч Хенри



*Сан Сальвадорын Эл Сальвадор Ариун сүмийн газар хөндөх ёслол энэ нутагт ариун өөрчлөлт гарах эх суурийг тавьсан юм.*



*Сан Саль-  
водарийн  
Эл Саль-  
водарийн  
Ариун сүмийг  
барихад  
зориулагд-  
сан газар нь  
хэрхэн өөрч-  
лөгдсөнтэй  
адил Амадо  
болон Эвелин  
Вигилийн  
амьдрал нь  
Есүс Хрис-  
тийн сайн  
мэдээгээр  
дамжуулан  
өөрчлөгдсөн  
юм.*

Б.Айрингийг ирэхийг тэсч ядан хүлээнэ. Сүмд элсээд олон жил болсон нэг гишүүн бараг шивнэх шахан, энэ газар орчноо-соо тасран, “газар дээр тэнгэрийн багахан хэсэг” боллоо хэмээн хэлэв.

### **Гэр бүлийн өөрчлөлт**

2010 оны дөрөвдүгээр сард Эвелин Вигил, нөхөр Амадо нь итгэлгүй болсонд санаа нь зовж эхэлжээ. Тэр үнэн Сүм байхгүй гэдэг дүгнэлтэнд хүрч, сүүлийн 11 жил ямар ч сүмд яваагүй гэнэ. Тэр хооронд Эвелин Бурханд итгэсэн хэвээр нэг сүмээс нөгөөд явж, Түүний үгийг сонсохыг эгээрэн хүсдэг байсан ч, сонссон зүйлдээ хэзээ ч сэтгэл ханамжтай байсангүй. Заримдаа тэр өглөө нүдэндээ нулимстай босдог байжээ. Ийм өдрүүдэд тэр Тэнгэрлэг Эцэгээсээ удирдамж хүсдэг байлаа. Тэр Түүний тухай мэдэхийг маш их хүсдэг ч, өөрийн очсон олон сүмийн алинд нь ч сэтгэл дундуур байсны учрыг Түүнээс асуужээ. Тэр бас гэр бүл нь нэгэн цагт нэг сүмд нэгдэхийн төлөө залбирдаг байж.

2011 оны наймдугаар сарын 23-нд Амадо Вигил, Эвелин Вигил хоёр төрөлх хотын өндөр дов дээрх өөрчлөлттэй адил өөрчлөлтийг зүрх сэтгэлдээ мэдсэн ажээ. Тэд цасан цагаан хувцас өмсөж, есөн настай охин Мишелл, гурван настай хүү Кристианыхаа хамт ариун сүмийн лацдан холболтын өрөөнд орж ирлээ. Тэд Сан Сальвадорын Эл Сальвадор Ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбуулсан анхны гэр бүл болжээ. Өөрсдийнхөө орж ирсэн ариун сүмийн адил тэд Их Эзэний үйлчлэлд шинээр орж ирсэн бөгөөд бие сэтгэл бүхнээ энэ ажилд зориулах хүсэлтэй байжээ.

### **Вигилийнхний түүх**

“Бидний түүх нь бид хоёр ахлагчийг олж уулзсан гэхээсээ илүүгээр тэд биднийг олсон тэр үеэс эхлэлтэй юм” гэж Амадо дурслаа. Бид хоёр Эвелиний эцэг эхийн гэрээс дэлгүүрт барьдаг цүнхүүдээ үүрэн гарч яваад хоёр ахлагч гудамж хөндлөн гарч бидний өөдөөс хүрч ирэхийг харсан юм. Тэдний нэг нь бидэнд тусалж болох уу хэмээн уриалгахнаар асууж билээ.

“Тэд бас бидэнтэй гэрээр очиж уулзаж болох уу гэж асуухад, миний сониуч зан хөдөлж, тэг л дээ гэж хариулж билээ. Би тэр үед Сүмийн тухай төдийлөн ихийг

мэддэггүй, зөвхөн бусад хүмүүсийн яриаг л сонссон байлаа.

Ахлагч нарыг манай гэрт очихыг зөвшөөрсний дараа, “Үүнд нэг их сүрхий юм болоод байх хэрэггүй шүү. Бид аль нэг сүмд элсэх шийдвэр гаргалаа гэж бодох хэрэггүй. Тэд юу гэж хэлэх нь вэ? гэдэг нь л миний сониуч занг хөдөлгөлөө” гэж би эхнэртээ хэлж билээ.

“Хоёр ахлагч манайхаар ирдэг болов. Хэрэв тэд буруу юм шиг надад санагдсан ямар нэг зүйлийг хэлэх л юм бол би тэдэнд манайхаас яв даа гэж найрсгаар хэлэхэд бэлэн байлаа. Гэвч тэд маш их эелдэг байсан учраас бусад сүмүүдийн талаар ямар нэг муу юм хэзээ ч ярихгүй юм байна гэсэн сэтгэгдэл надад төрсөн. Тэд хайр болон хичээл зүтгэлээр зааж байсан бөгөөд намайг олон асуулт асуухад туйлын тэвчээртэй байлаа. Тэд удалгүй

бидэнтэй ойр дотно боллоо.”


Амадо, Эвелин хоёр баптисм хүртэж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлуулахын тулд бага багаар бэлтгэж эхэлжээ. Мэргэн Ухааны Үг Эвелинд хамгийн том сорилт байсан ажээ. Эхнэр минь кофе ууж болохгүйгээ мэдээд гунигтай байлаа. Амадод ямар нэг муу зуршлаа орхих шаардлага байсангүй. Тэр зөвхөн үнэнийг л мэдэх хэрэгтэй байлаа. Тэр номлогчдын заасан зүйлд итгэснээр барахгүй, мөнхийн гэр бүл, нас барагсдын өмнөөс хийх баптисм, Сүм дэх нөхөрлөл ба Сүмийн зохион байгуулалт зэрэг бусад сүмүүдэд байдаггүй олон сургаал, практик үйл ажиллагаануудыг эхнэрийнхээ хамт хүлээн зөвшөөрсөн ч, баптисм хийлгэх эсэх тухайд эргэлзэж байжээ. Тэр Сүмд нэгдсэн хойноо буруу шийдвэр гаргаснаа мэдвэл яанаа хэмээн зовж байсан аж.

Ийм санаа зоволт удалгүй алга болов. Эвелин тусламжийн төлөө залбирч, кофе уудаг муу зуршлаа ялсан аж. “Энэ зуршил адислалууд хүлээн авахад надад саад болох ёсгүй” хэмээн тэр ярилаа. Амадо шийдэж чадалгүй хоёр сар орчим байсны эцэст баптисм хүртэхээр шийдсэн гэнэ. Тэрээр Эвелиний хэлснээр, “Бид сайн мэдээг баяртайгаар хүлээн авах хэрэгтэй” гэжээ.

### **Бэрхшээл сорилтууд ба адислалууд**

Амадо, Эвелин хоёр Мишеллийн хамт 2011 оны зургадугаар сард баптисм хүртэж, гишүүнээр батлагдав.

*Ариун сүм  
Сальвадорын  
хүмүүсийн  
амьдрал, зүрх  
сэтгэлийг  
өөрчилсөөр  
байх болно.*



“Бид баптисм хүртсэн цагаас эхлэн юм бүхэн өөрчлөгдөж байгааг би мэдэрсэн. Манай гэр бүлийнхэн Сүмд нэгдэж, бид сайн мэдээг оллоо. Тэр үеэс хойш бидэнд хүнд сорилт, өвчин зовлон тохиолдсон ч Тэнгэрлэг Эцэг минь бидэн дээр олон адислал юүлсэн” гэж Эвелин ярилаа.

“Миний ажигласан эхний өөрчлөлт бол манай гэр бүл сайн мэдээнд нэгдсэн явдал юм” гэж Амадо хэлэв. Энэ бол бид өмнө нь эв нэгдэлгүй байсан гэсэн хэрэг биш харин бид улам илүү эв нэгдэлтэй болсон гэсэн үг юм. Сайн мэдээний сургаалууд бидэнд үнэхээр тусалсан. Сүмийн удирдагчид гэр бүлийн ариун нандин чанарыг заадаг учраас бид гэр бүлээ улам ихээр хайрлан эрхэмлэдэг болсон.”

Вигилийнхний бишоп Сизар Ореллана тэдний амьдрал дахь өөрчлөлтийг бас харжээ. Баптисмынхаа дараа удалгүй Амадо бишоп Ореллана руу хүрч ирэн, “Бид аравны нэгээ төлмөөр байна. Гэвч яаж төлөхөө мэдэхгүй юм” гэжээ.

Бишоп Ореллана аравны нэг гэдэг бол тэдний нийт орлогын аравны нэг хэсэг гэж тайлбарлажээ. Амадогийн санааг зовоодог нэг зүйл байсан нь тэр үед Эвелин ажилтай, харин тэр өөрөө ажилгүй байсан явдал юм. “Бид мөнгөөр байнга дутагдаж байдаг ч, аравны нэгээ төлмөөр байна” гэж Амадо бишоптоо хэлжээ.

Бишоп, “Амадо ах аа, Их Эзэн бидэнд олон амлалт өгсөн юм” хэмээн бишоп Ореллана хариулав. Аравны нэгийг итгэлтэйгээр төлснөөс ирдэг олон адислалын тухай, түүний дотор бошиглогч Малахигаар дамжуулан Их Эзэний хэлсэн дараах үгсийг тэд судраас хамтдаа

уншсан ажээ: “Миний өргөөнд бүхий л аравны нэгээ авчир, . . . Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга” (Малахи 3:10).

Энэ судрыг хамт уншсаны дараа бишоп Ореллана шинэ хөрвөгчийг хараад, “Хэрэв та ус, цахилгааныхаа мөнгийг төлж чадахгүй бол юу болох вэ? Аравны нэг үүнтэй л адил юм. Хэрэв та түрээсээ төлөхгүй бол юу болох билээ, гэж бодоод аравны нэгээ төл. Гэр бүлээ тэжээх мөнгө хүрэлцэхгүй байлаа ч аравны нэгээ төл. Аравны нэг гэдэг ийм л юм. Их Эзэн таныг хаяхгүй” гэж ярьжээ.

Дараагийн ням гарагт Амадо бишоп Ореллана руу дахин хүрч ирэв. Энэ удаад тэр ямар ч асуулт асуусангүй. Тэрээр бишопт дугтуй гардуулж, “Бишоп оо, энэ бидний аравны нэг” гэжээ.

Бишоп Ореллана энэ талаар, “Тэд тэр үеэс хойш аравны нэгээ итгэлтэй төлөгчид байгаа” гэж ярилаа. Эднийх санхүүгийн хүндрэл тохиолдсон үедээ бишопын агуулахаас хүнсний зүйл авдаг байсан гэнэ. Түүнээс гадна Их Эзэн тэднийг өөрсдийнхөө төлөө санаа тавих чадвараар адисалсан ажээ. Эвелин урамшуулалт цалинтай, Амадо сайн ажилтай болжээ. Эвелин хожим нь ажилгүй болсон ч, итгэл бишрэлийнхээ төлөө сүнсэлэг болон материалааг адислал хүлээн авахын тулд тэд аравны нэгээ төлсөөр байлаа. Нэг удаа бишоп Ореллана Амадогийн гэр бүл санхүүгийн хувьд ямархуу байгааг түүнээс асуухад “Бид дажгүй байгаа шүү. Заримдаа бидэнд идэх юм хүрэлцдэггүй



ч, хоёр идэхгүй, хоосон хонохгүй болж л байна. Юунаас ч илүү чухал зүйл бол Их Эзэнд итгэх бидний итгэл юм” гэж Амадо хариулжээ.

Нэг удаа аравны нэгээ төлсний дараа Эвелин, Амадо хоёр хүлээн авсан адислалуудынхаа тухай бишоп Орелланатай ярилцсан гэнэ. Тэд Малахи 3:10-ыг дурдаж, “Бид Их Эзэнийг шалгасан” гэжээ. Бишоп Орелланагийн амласнаар Их Эзэн тэднийг хэзээ ч орхиогүй юм.

### Шинэ хэтийн төлөв

Эвелин, Амадо хоёр гэр бүлээрээ ариун сүмийн лацдалтын өрөөнд хамт байсан тэр өдрийн тухай сайхнаар дурсан ярьдаг ажээ. Тэд хувийн хишгээ хүлээн авч, лацдан холболтын ёслолд бэлэн болсон тэр өдөр хүүхдүүд нь үймүүлэх байх гэж санаа нь зовж байжээ. Ялангуяа тун их хөдөлгөөнтэй гурван настай хүү Кристианыхаа төлөө санаа нь бүр их зовж байсан гэнэ. Гэтэл хоёр хүүхэд нь лацдалтын өрөөнд тайван гэгч нь хүндэтгэлтэйгээр орж ирсэн нь тэд энд биеэ хэрхэн авч явах ёстойг ойлгосныг харуулжээ. Тэгээд лацдан холболтын ёслолд бэлтгэх цаг болоход Кристиан ямар ч заавар авалгүйгээр тахилын ширээ рүү очиж, эцэг эхийнхээ дэргэд өвдөг сөгджээ.

Өнөр бүл нь лацдан холболтын өрөөний хоёр талын толинд хэрхэн харагдсаныг Эвелин санадаг ажээ. Амадо бас үүнийг зөвхөн ариун сүмд төдийгүй өдөр тутмын амьдралдаа харах болно хэмээн ярих. Тэрээр эдүгээ амьдралыг нь удирдаж байгаа мөнхийн хэтийн төлөвт мөн ийм хэтийн төлөв Мишелл, Кристиан хоёрыг Их Эзэний өргөөнд байх үед тэдэнд нээгдсэнд талархалтай байдаг ажээ. Вигилийнхний хэтийн төлөв нь 8-р сард гэрээний дагуу төрсөн Андрей гэдэг шинэ охинтой болсны дараа улам өргөжин хөгжсөн юм.

### Өндөр дов дээрх дээрх гэрэл

Вигилийнхний гэр бүл Есүс Христийн цагаатгагч золиослол болон эх оронд нь байгаа Түүний өргөөний нөлөөгөөр үүрд мөнхөд өөрчлөгдсөөр байх болно. Тариалангийн талбай ариун газар болон өөрчлөгдсөн



*Вигилийнхэн бол 2011 оны наймдугаар сард онцгойлон адислагдсан Сан Сальвадорын Эл Сальвадор Ариун сүмд лацдан холбуулсан анхны гэр бүл юм.*

учраас тэдний гэр орон бүр ч илүү ариун газар болсон юм.

Тэд олон талаараа бүхэл улс үндэстнээ төлөөлж байна. Эл Сальвадор бол дэлхийн зүйлсээр өдөр бүр уруу татагдаж буй сая сая шударга, сайн хүмүүсийн эх орон юм. Сальвадорын Гэгээнтнүүд эх орондоо хайртай бөгөөд Их Эзэний ариун сүмийг нутагтаа хараад итгэл найдвар нь шинэчлэгджээ. Тэд Ерөнхийлөгч Айрингийн хэлсэн ариун сүмийн онцгойлон адислалтын дараах үгсээс итгэл найдварыг олсон юм:

“Таны үй олон адислал Эл Сальвадор улс дээр юүлэгдэхийн төлөө бид залбирч байна. Ард түмэн эрх чөлөө хийгээд боломжуудаар адислагдахын төлөө удирдлагынх нь зүрх сэтгэлд сүнслэгээр нөлөөлнө үү. Энэ нутагт энх тайван мандан бадрах болтугай.

“Таны ажил энэ нутагт цэцэглэн хөгжих болтугай. Улс орон даяарх ард олны зүрх сэтгэлд сайн мэдээний захиас нөлөөлөх болтугай. Тэд баптисмын усанд ирж, Танд үнэнч итгэлтэй байх болтугай. . . .

“... Бид энэхүү ариун барилга болон түүний орчны газрыг Таны тааллыг болон Таны мөнхийн ажлыг гүйцэлдүүлэхийн төлөө зүрх сэтгэлийн талархалтайгаар онцгойлон, ариулан адисалж байна. Энэхүү ариун өргөөний нөлөө өндөр дов дээрх гэрэл лүгээ адил улс орон даяар дэлгэрэхийн төлөө бид залбирч байна.”<sup>1</sup>

Энэхүү нөлөөний ихээхэн хэсэг нь Вигилийн гэр бүл шиг хүмүүсийн үйлчлэл, үлгэр жишээгээр дамжин хэрэгжих нь тодорхой юм. Эдүгээ Амадо Вигил нулимсаа гараараа арчиж, сэтгэлийн хөдөлгөөнөө барьж ядан, Христэд ирж, ариун сүмийн адислалуудыг хүртэх боломжийг өөрт нь болон гэр бүлд нь олгосон номлогчдыг хайрын үгсээр дурсан ярьж байна. “Бид хүүхдүүдээ номлолд үйлчилнэ гэдэгт итгэлтэй байна. Иймээс тэд манай гэр бүлийг адисалсан тэр залуу номлогчид шиг бусад гэр бүлүүдийг адислах болно” гэж тэр хэллээ. ■


### Эшлэл

1. “May Peace Reign in the Land”—Эл Сальвадорын Ариун сүмийн онцгойлон адислалтын залбирал,” *Church News*, 2011 оны 8-р сарын 27, [ldschurchnews.com](http://ldschurchnews.com).

# МӨНХИЙН ГЭР БҮЛ

ДЭЭР АНХААРАЛ  
ТӨВЛӨРҮҮЛЭХҮЙ

*Эл Сальвадорт ариун сүм  
баригдсан нь ах, дүү хоёрт  
эцэг эхээ Сүмд эргүүлэн  
авчрахад нь тусалжээ.*





## Майнди Рае Фриедман

Сүмийн сэтгүүлүүд

**К**евин С., Жаквилин С., хоёр бол Эл Сальвадорын ах, дүү хоёр бас дотны анд найзууд бөгөөд тэд юм бүхэнд хамт оролцдог ажээ. Тэр хоёр сайн мэдээг болон гэр бүлээ хамгийн ихээр хайрладаг. Тэд гэр бүлээ үүрд хамт байгаасай гэж хүсдэг.

Кевин, Жаквилин хоёрыг бага байхад сүм дээр хүмүүс ааваас нь, “Та нар ариун сүмд хэзээ лацдан холбуулах гэж байна?” гэж асуудаг байж. Тэгэхэд нь тэр, “Эл Сальвадорт ариун сүм баригдсан цагт” гэж хариулдаг байсан гэнэ.

### Эцэг эхчүүдийнхээ төлөө залбирсан нь

Гэвч Сан Сальвадорын Эл Сальвадор Ариун сүмийг барихаар 2007 онд зарлахад Кевин, Жаквилин хоёрын аав, ээж хоёр сүмд явахад больчихсон байлаа. Гэвч одоо 18 настай Кевин, 15 настай Жаквилин хоёр сүмд явсан хэвээрээ, аав ээж хоёр нь нэгэн өдөр сүмдээ эргэж ирэхийн төлөө залбирсаар байгаа ажээ.

“Аав, ээж хоёр минь дахин идэвхтэй болохын төлөө би Тэнгэрлэг Эцэгээс гүйж залбирахаа хэзээ ч болихгүй гэж” Жаквилин хэллээ. “Тэнгэрлэг Эцэг бидэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсдэгийг, Тэр бас биднийг мөнхийн гэр бүл байгаасай гэж хүсдэгийг би мэднэ.”

Тэд бас эцэг эхдээ сайн үлгэр дууриал үзүүлэхийг хичээдэг байв. “Би хэзээ ч итгэл найдвараа алдахгүй” гэж Кевин хэлэв. “Би үргэлж судар уншиж, залбирдаг байсан. Аав ээж хоёр минь намайг судар судалж байхыг, гэрийн багшаар болон Сүмийн үйл ажиллагаануудад оролцохоор явахыг хардаг байсан. Зарлигуудыг сахих болон өөртөө өсөлт дэвшил гаргахын төлөө намайг шаргуу ажилласан үед аав, ээж хоёр минь миний үлгэр жишээг хардаг байсан.

### Ариун сүмд Сүнсийг мэдэрсэн нь

Эцэг эхийнхээ төлөөх Кевин, Жаквилин хоёрын залбирал ариун сүм дуусах дөхсөн үед хариулагджээ. “Манай удирдагчид ариун сүмийн онцгойлон адислалт болон соёлын үйл ажиллагааг зарлахад бид хоёр аав ээж хоёрыг урьсан” хэмээн Кевин ярилаа. “Залуучууд бид эдгээр үйл ажиллагаануудад оролцох нь онцгой боломж гэдгийг бид аав ээж хоёрт ярьсан нь тэдэнд их нөлөөлж, сүнслэг байдлын хувьд өсч хөгжихөд нь тусалсан юм.

Тэднийхэн гэр бүлээрээ соёлын үйл ажиллагаанд оролцохоос гадна ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд оролцох боломжтой байлаа.

“Аав ээж хоёр минь сүмд явалгүй нэлээд удсан ч, Сүм болон сайн мэдээг ариун зүйл гэж үздэг хэвээр байсан

юм” гэж Кевин хэлэв. Биднийг ариун сүм рүү ороход аав, хоёр дүү бид гуравт, бид ариун сүмд орохдоо цагаан хувцас өмсдөг нь энд ариун нандин ёслолууд гүйцэтгэдэг юм хэмээн тайлбарлаж билээ.”

Их хөдөлгөөнтэй, хоёр настай эмэгтэй дүү нь ариун сүм дотор ороод өчүүхэн ч чимээгүй гаргахгүй томоотой болсонд Кевин гайхсан гэнэ. Мөн ээж нь ариун сүмийн олон өрөөнүүд болон уран зургуудыг харж явах үед нүдэнд нь нулимс цийлэгнэж байхыг тэр бас харжээ. Тэднийг лацдан холболтын өрөөнд ороход сайн дурын хөтөч, энэ бол гэр бүлүүд үүрд мөнхөд лацдан холбуулдаг өрөө гэж тайлбарлажээ.

Манай жаахан эмэгтэй дүү бидэнд бүтдэд нь гар хүрч, “Миний ээж, миний аав, миний Кевин, миний Жаквилин” хэмээн шулганаж билээ. “Энэ нь Тэнгэрлэг Эцэг түүгээр дамжуулан бид бүгд түүнийх хэмээн бидэнд хэлэх шиг санагдаж билээ.

“Тэгээд бяцхан дүү минь биднийг тэвэрч, үнсээд толь руу заасан” гэж Кевин ярилаа. “Бид өөрсдийгөө толинд харсан нь үнэхээр гайхамшигтай байлаа. Бид тэр өдөр ариун сүмээс гарч явахдаа энд дахин ирэх зорилго тавьсан.”

### Чухал өөрчлөлтүүд

Эднийхэн ариун сүмийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсоны дараа тэдний амьдралд зарим өөрчлөлт гарч эхэлжээ. “Бид ариун сүмд очсоноос хойш манай гэр бүл өөрчлөгдөж эхэлсэн шүү гэж Кевин хэллээ. “Тэр





## ХАМГИЙН ЧУХАЛ ЗОРИЛГО

Хэрвээ та ариун сүмд ороогүй бол ариун сүмд орсон ч, ариун сүмийн эрхийн бичиг авахад одоогоор тэнцэхгүй байгаа бол таны хамгийн чухал зорилго бол ариун сүмд орохоор зохистой байхын тулд цаашид үргэлж хөдөлмөрлөх явдал юм. . . . Бурханы ариун сүмүүдэд бидний хүлээн авдаг адислалууд нь Сүмийн гишүүдийн хамгийн чухал, дээд адислалууд юм.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “The Holy Temple—a Beacon to the World,” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 93.

үеэс хойш бид гэр бүлийн үдшээ тасралтгүй хийж байгаа. Аав ээж хоёр биднийг сүм рүү авч очдог болсон. Бид цуглааны байрны эхний эгнээнд гэр бүлээрээ суудаг болсон.”

2011 оны наймдугаар сард Кевин, Жак-вилиин хоёр аав, ээжийнхээ хамт гадасны төв дээр ариун сүмийн онцгойлон адислалтын шууд нэвтрүүлгийг үзэж суулаа. Энэ бол тэдний хувьд агуу адислал байв.

“2007 онд ариун сүм зарлагдахад аав, ээж хоёр идэвх султай болчихоод байсан. Ариун сүмийн онцгойлон адислалт дээр аав, ээж хоёртойгоо хамт сууж байх аз завшаан надад тохиохгүй л болов уу гэж би бодож байсан” гэж Кевин ярилаа. Аав, ээж

хоёрыгоо миний дэргэд сууж байх үед би Тэнгэрлэг Эцэг үнэхээр залбиралд минь хариулсныг би мэдэрсэн. Бид ариун сүмийн онцгойлон адислалт дээр гэр бүлээрээ байсан нь миний амьдралд ирсэн хамгийн агуу адислалуудын нэг юм.”

“Ариун сүмийн энэ туршлага надад хүч чадал өгсөн юм” гэж Жаквиллин ярилаа. “Ариун сүм, аав ээж хоёрт минь Сүмд дахин идэвхтэй болоход нь тусалсан учраас энэ нь хүмүүсийн амьдралыг өөрчилдөг гэдгийг харсан нь юунаас ч илүүгээр надад хүч чадлыг өгсөн юм. Одоо бид ариун сүмд лацдан холбуулах зорилго тавиад байгаа. Тэнгэрлэг Эцэг бидэнд хамгийн сайн сайхныг хүсдэгийг би мэднэ.” ■



## ГЭР БҮЛД ХАЙР БАЙГАА ҮЕД

Кевин, Жаквиллин хоёр маш дотны найзууд, бас ах дүү хоёр бөгөөд ах дүүсийн хоорондын үерхэл амьдралын хамгийн сайхан үе байж чадна гэдгийг мэджээ. Тэр хоёр бие биенээ хэрхэн дэмждэгийг энд товч өгүүлье.

“Ах минь надад гэр орны ажил, хичээл сурлаганд хоёуланд нь үргэлж тусалдаг. Би

түүний тус дэмжлэгийг үргэлж авдаг. Тэр надад хайртай, бас ямар ч үед надад туслах болно гэдгийг би мэднэ. Намайг гунигтай юм уу санаа сэтгэл тааруухан байгаа үед тэр надад үргэлж урам хайрладаг.”

“Намайг санаа сэтгэлээр унасан үед дүү минь үргэлж намайг дэмжиж, урам хайрладаг” гэж Кевин хэлдэг. Тэр миний тухай дандаа сайн зүйлсийг ярьдаг. Энэ нь надад

сайхан санагддаг. Би түүний үлгэр жишээнээс их зүйл сурсан. Зарим үед намайг итгэл алдарч эхлэхэд дүү минь, бүх зүйл миний бодсоноор сайн сайхан болно гэдэгт эргэлзэх хэрэггүй хэмээн надад зөвлөдөг.”

Энэ хоёр залууд үерхэл нь ихэд таалагддаг бөгөөд тэд бусад олон ах дүүс шиг хоорондоо ам муруйж, хэрэлдэж маргадаггүй. “Бид хоёрыг этгээд хүмүүс байна гэж та хэлж магадгүй. Гэвч би эмэгтэй дүүтэйгээ ийм харилцаатай байдгийнхаа төлөө Тэнгэрлэг Эцэгтээ талархдаг” гэж Кевин ярилаа.



# ҮЙЛЧЛЭЛЭЭР ДАМЖУУЛАН ТҮҮНИЙ ХАЙРЫГ МЭДЭРСЭН НЬ

Мишелл Вейсден



**Х**ристийн Мэндэлсний Баяраас хоёр долоо хоногийн өмнө би энэ баяртай холбоотой сэтгэл санааны дарамттай тулгарлаа. Чимэглэх сүлд мод, хүмүүст өгөх өч төчнөөн бэлэг худалдаж авах шаардлагатай болов.

Би тавын таван хүүхдийн эх болохоор хэдэн сарын турш өдөр тутмын ажилдаа дарагдаж, өөр юм бодох сөхөөгүй байлаа. Сүмд ирэхдээ хүртэл ээлжит албаа өнгөрүүлж байгаа юм шиг хайш яйш ханддаг болж, хүүхдүүдээ вандан сандал дээр чимээгүй суулгах гэж үйлээ үзнэ. Би амьдралдаа Сүнийг болон сүнслэг байдлаа өсгөн нэмэгдүүлэхийг хүсч байлаа.

Энэ үед эгч маань зэргэлдээх мужид шинэ байшин худалдаж аваад Христийн Мэндэлсний Баярын өмнө юм бүхнээ жин тан болгохоор хичээж байлаа. Энэ бол ямар ч айлд мундахгүй их ажил юм. Тэр тусмаа эгчид минь энэ нь бүр ч хэцүү байлаа. Найман сартай жирэмсэн, бага насны хоёр хүүхэдтэй эгч маань бас дөрвөн мөч нь дөрвүүл саажиж мэдээгүй болсон нөхрөө асарч тойлно.

Түүнд тохиолдсон сорилт бэрхшээлийг би ойлгодог болохоор амьдрал ахуй нь ямархуу байгааг мэдэх гэж түүнтэй утсаар ярилаа. Тэр өөдрөг үзэлтэй, шинэ тойргийн гишүүд нь тусалж, дэмжинэ гэдэгт итгэлтэй байлаа. Эгчдээ амжилт хүсээд утсаа өлгөхдөө би түүнд 650 километрийн цаанаас хэрхэн

туслахаа мэдэхгүй байлаа.

Эгчдээ туслахын тулд би тийшээ очих хэрэгтэй гэсэн бодол тэр орой миний санаанаас утгал гарсангүй. Тэгээд цагийн хуваариа хартал унтах цаг аль хэдийн өнгөрчихсөн байв.

Маргааш өглөө нь сэрэхэд нөгөөх бодол толгойд эргэлдсэн хэвээр байв. Энэ удаад нөгөөх бодол маш их хүчтэй байсан учир түүнээс татгалзах аргагүй байв. Тиймээс би нөхөр рүүгээ утасдаж, “Би эгчдээ туслахаар явах хэрэгтэй байна” гэлээ. Нөхөр маань өчүүхэн ч эргэлзээгүйгээр, “Би ч бас тэгж бодож байна” гэв.

Тэгээд би эгчтэйгээ утсаар ярьж, очих гэж байгаагаа хэлж, үдээс хойшхи нислэгийн билет захиалав. Авч явах юмаа чөмөндөө түргэн хийгээд, хүүхдүүдээ үнсэн, баяртай гэж хэлээд нисэх онгоцны буудал руу яаран хөдөллөө.

Би дараагийн гурван өдрийн турш хайрцгуудыг задалж, өрөөнүүдийг янзлан, Христийн Мэндэлсний Баярын сүлд модыг чимэглэхэд туслав. Ихэнх хайрцгуудыг задалсны дараа би эгч болон тэднийхэнтэй хамт сууж, сүлд модыг сонирхлоо. Таван настай миний зээ дүү, гэрийнхэн нь баярыг тэмдэглэхэд бэлэн болсныг хараад, “энэ удаагийн Христийн Мэндэлсний Баяр тун гоё болох нь ээ!” гэж дуу алдав.

Би гэртээ харихаар нисч явахдаа, түр хугацаанд ч болов энэ сайхан гэр бүлийн хэсэг байхдаа надад нэн чухал хэрэгтэй байсан

## МӨНХИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ ҮЙЛЧЛЭЛ

“Амь бие хайргүй үйлчлэл болон золиослолын хамгийн түгээмэл, хамгийн чухал жишээ гэр бүлүүдэд харагддаг. Эхчүүд үр хүүхдээ асран хүмүүжүүлэхэд өөрийгөө бүрэн зориулдаг бол, нөхөр нь эхнэр, хүүхдээ тэжээн тэтгэхэд өөрийгөө бүрэн зориулдаг. Манай гэр бүлүүд дэх мөнхийн ач холбогдолтой үйлчлэлд илэрдэг золиослолудыг тоолох аргагүй олон, дурдах шаардлагагүй бүх нийтээрээ мэддэг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Даллин Х.Өүкс, “Sacrifice,”  
Лиахона, 2012 оны 5-р сар, 22.

Сүнийг мэдэрснээ мэдэж байлаа. Би бусдад үйлчилсэн учраас Сүнийг мэдэрсэн юм.

Христийн Мэндэлсний Баяраар бусдад үйлчлэх тухай ярих нь амархан л даа. Харин тэрхүү үйлчлэл нь бидний ажлын хуваарь дотор багтсан, их үнэ өртөггүй, бидэнд ая тухтай байдлыг хангаж өгдөг байх нь чухал юм. Гэвч Христийн Мэндэлсний Баярын жинхэнэ Сүнийг үнэхээр мэдрэхийн тулд бид бусад хүмүүст туслах хэрэгтэй. Бид ийнхүү бусдад тусалснаар бид бүгдийг хайрладаг Аврагчийн хайрыг ойлгож чадна. ■



Бишоп Гари Э.Стивенсон

Тэргүүлэх бишоп

# Зарлигуудыг сахиснаас ирдэг аюулгүй байдал ба амар амгалан

*Мормоны Номон дахь загварууд болон үнэнүүд тодорхой бөгөөд сургамжтай, энгийн бөгөөд үнэ цэнэтэй юм. Бид шударга бөгөөд дуулгавартай байвал, олон адислал авч, баяртай байх болно.*


Дижитал мэдээллийн өнөө үед бүхний мэдэх аль нэг түүхийн бүлгүүдийг өдөр бүр давтан үзүүлэхгүй байх аргагүй юм. Үйл явдлын баатрууд нь ихэвчлэн ер бусын авьяас билгийнхээ ачаар жүжигчид, тамирчид, улс төрчид болон бизнесийн удирдагчид болж, алдар нэрд хүрсэн байдаг. Аль нэг мэргэжил, ажил төрлөөр хийсэн олон жилийн дадлага сургуулилт, бие сэтгэл бүхнээ зориулсан үйлчлэл хийгээд золиослолын ачаар хүрсэн дээд амжилт нь гутамшигийг дагуулсан ямар нэг буруу үйлийн улмаас салхинд хийсэх лүгээ адил замхран алга болдог.

Эцсийн бүлэгт юу болдог вэ? гэвэл нөгөөх баатрууд маань сэтгэлдээ гуниг тээн, нүдэндээ нулимстайгаар шүүгчээс эсвэл хувьцаа эзэмшигчээс эсвэл хууль тогтоох байгууллагад сонгогдсон нэгнээс өршөөл үзүүлээч гэж царайчлан гуйхад хүрдэг. Энэ нь санаанд оромгүй олон салаа үр дагаварт хүргэж, зөвхөн өөрт төдийгүй, бас ойр дотны болон харилцаатай байдаг бусад хүмүүст сэтгэлийн гүнзгий эмзэглэл, ичгүүр, гай зовлон авчирдаг.

Мормоны Номын эрт үеийн бошиглогч Алма хүүдээ зөвлөгөө өгч хэлсэн: “Ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10) гэсэн энгийн атлаа онцгой чухал үгс 21-р зуунд 2000 жилийн тэртээх шигээ ач холбогдолтой хэвээр байна.

Өнөөдөр чухамдаа дуулиант буюу шившигт явдал бүрийг хувийн болон ажил мэргэжлийн сүйрэл гэж үздэг бөгөөд үүнээс зайлсхийхийн тулд дагах ёстой зарлигууд сэргээгдсэн сайн мэдээнд байдаг.





# ХУУЛЬ

(2 Нифай 2:11–27-г  
үзнэ үү.)

Аз жаргал  
(баяр баясал)

Адислал

Дуулгавартай байдал  
(зөв шударга байдал)

Дуулгаваргүй байдал  
(ёс бус явдал)

Шийтгэл

Аз жаргалгүй байдал  
(зовлон зүдгүүр)

## Аз жаргалын загвар

Есүс Христийн сайн мэдээнд байдаг загвар нь аз жаргалд хүрэх замыг бидэнд зааж өгдөг. Энэ бол Мормоны Номонд байдаг тодорхой болоод эрхэм үнэт зүйлс юм. Үүнийг бошиглогч Лихай нас эцэслэхийнхээ өмнөхөн хөвгүүддээ өгсөн сургаалуудад бүр тодорхой дүрсэлсэн байдаг. Иаков хөвгүүддээ хандаж хэлэхдээ, “Учир юун хэмээвээс бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй” (2 Нифай 2:11) гэжээ. Тэрээр хэдэн шүлгийн дараа, “Тэд баясгалантай байж болохын тулд хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:25) хэмээн нэмж хэлжээ.

Иаковт өгсөн энэхүү номлол дахь Лихайн сургаалуудыг энгийнээр нэгтгэн дүгнэвэл: Дуулгавартай бөгөөд зөв шударга байдал адислалууд руу хөтөлдөг бол адислууд нь баяр баясгалан руу хөтөлдөг. Үүний эсрэгээр, дуулгаваргүй байдал, ёс бус явдал нь шийтгэл рүү, шийтгэл нь уй гашуу руу хөтөлдөг. Аврагч бол бүх хүн төрөлхтний агуу Зууч бөгөөд аз жаргал ба мөнх амьдралд хүрэхэд ивээн тэтгэгч юм. Чөтгөр бол худал бүхний эцэг бөгөөд боолчлол, үхлийг ивээн тэтгэгч мөн.

Бид мэдсээр байгаад боолчлол, үхлийг сонгохгүйг дайсан ойлгодог нь тодорхой юм. Чухам тийм учраас тэр өөрөө үүрд мөнх зовлонт байх төдийгүй бүх хүн төрөлхтнийг бас зовлонт байхыг хүсдэг (2 Нифай 2:27-г үзнэ үү). Тэрээр нүгэл ба дуулгаваргүй байдлын үр дагавруудыг мушгин гуйвуулснаар хүслээ биелүүлэхийг хичээдэг. Энэ бол тэрээр худал бүхний эцэг хэмээн нэрлэгддэгийн нэг шалтгаан мөн.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл (1895–1985) ийн хэлжээ: “Та бүгд . . . худал хуурмагийн эцэг Сатаныг мэднэ. Тэрээр үнэнийг хэрхэн худал болгодогийг та нар мэднэ. Тэрээр нүгэл хилэнцийг сайхан, хүсүүштэй, хөгжилтэй, тэр ч байтугай сайн зүйл болгон гоёж чимдэг.”<sup>1</sup>

Аз жаргалыг олох хамгийн сайн арга зам нь ёс бус явдал хийгээд нүглээс эхэлдэг гэж Сатан бидэнд итгүүлэхийг хичээх болно. Түүний уруу таталтууд тун зальжин, нуун халхалсан байдалтай бөгөөд зарим үед тэрээр “гэрлийн тэнгэр элч мэт” (2 Нифай 9:9) харагдаж ч чадна. Их Эзэн Сатаны уналт болоод зорилгыг ийн дүрсэлсэн байдаг:

“Иймийн тул Сатан миний эсрэг бослого гаргасан хийгээд бибээр Их Эзэн, Бурхан мөн тэрчлэн түүнд өгсөн хүмүүний сонгох эрхийг эрэлхийлэн мөн би түүнд өөрийн хүчийг өгөх ёстой гэсний учир түүнийг би Төрсөн Ганцынхаа хүчээр доош хаягдахаар болгосон бөлгөө;

“Мөн тэрээр Сатан, тийм ээ, бүр чөтгөр, бүх худал хуурмагийн эцэг хүмүүнийг мэхлэн, мөн харалган болгож, өөрийн хүсэл рүү хөтөлдөг билээ (Мосе 4:3–4).

Аз жаргал руу хөтөлдөг зам нь зарлигуудад дуулгавартай байхаар дамжсан зөв шударга байдлаас эхэлдэг билээ. Бидэнд өгсөн зарлигууд бол ёс суртахууны олон сүйрлээс биднийг хол байлгах бурханлаг удирдамж юм. Их Эзэн үүнийг бүр Сэргээлтийн эхэн үед тунхагласан юм: “Иймийн тул, Их Эзэн бибээр дэлхийн оршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан, тэнгэрээс түүнд ярьж, *мөн түүнд зарлигуудыг өгсөн ажгуу*” (С ба Г 1:17; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

## Зарлигуудыг сахь

Зарим хүмүүс зарлигууд бол аз жаргалд хүрэх замын эхэнд байдаг биш, харин замын дунд биелүүлдэг зүйл хэмээн буруу боддог. Хэдэн жилийн өмнө намайг Японы Нагояд номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байсан үед болсон дараах түүх үүнийг харуулж байна.

Манай эхнэр Леса бид хоёр нэгэн залуу эмэгтэйтэй танилцлаа. Тэр сүм дээр хүрч ирснийхээ дараахан номлогчдын заадаг англи хэлний хичээлд суудаг байв. Тэр эмэгтэй нөхөрсөг, нийтэч, эрч хүч, урам зоригтой, зан байдалдаа хяналт тавьж чаддаг учраас сайн ажилтай, удаан үерхэж байгаа найз залуутай, гэр бүлтэй байлаа. Тэр англи хэлний хичээлээр дамжуулан номлогчид, гишүүдтэй харилцаатай байсан нь Сүмийг сонирхоход нөлөөлж, улмаар номлогч нараас хичээлүүдийг авч эхэлжээ. Сэргээгдсэн сайн мэдээ үнэн болох тухай түүний гэрчлэл номлогчидтой уулзах бүрд өсөн нэмэгдэж байжээ. Тэрээр Мормоны Номыг уншиж, энэ номын тухай бас сонссон зүйлүүдийнхээ тухай тунгаан бодож, залбираад тэдгээр нь үнэн гэдгийг мэджээ.

Номлогчид түүнд зарлигуудыг зааж эхлэхэд тэрээр зарлигуудыг дуулгавартай дагах ёстойг ойлгожээ. Тэр найз залуугаасаа харилцаагаа таслан, ням гарагт ажиллах шаардлагатай ажлаасаа гарч, Мэргэн Ухааны Үгийг сахьж, ариун явдлын хуулийг амьдралдаа хэрэгжүүлж эхэлсэн гэнэ. Түүний итгэл үнэхээр хүчтэй байсан учраас тэр зарлигуудын тухай мэдсэн өдрөөсөө эхлэн тэдгээрийг сахьж эхэлсэн ажээ.

Тэрээр Сүмийг сонирхож, сэргээгдсэн сайн мэдээг судалж эхэлсэн тухайгаа эцэг эхдээ хэлэхэд тэд түүнтэй харилцаагаа таслах болно гэж хэлсэн гэнэ. Зарлигуудыг хүлээн зөвшөөрч, сахьж эхэлснээс хойш хэдхэн долоо



хоногийн дотор тэр ажилгүй, орон сууцгүй болж, гэр бүлийнхээ дэмжлэгийг алдсан ажээ. Тийнхүү, дуулгавартай байдлын үр дагавар нь түүний амьдралд дэндүү хүндээр нөлөөлсөн нь тодорхой байна.

Би түүний байдалд ихээхэн санаа зовж байлаа. Леса бид хоёр нэг шөнө оройхон, толгой өндийлгөх завгүй ажилласан ажлын өдрийн дараа хэсэгхэн хугацаанд хамт байх нам гүмхэн газрыг хайж, номлолын гэрээс гарч алхлаа. Биднийг хөл хөдөлгөөн ихтэй замын уулзвараар гарч явтал нөгөөх цоглог залуу сонирхогч дугуйгаараа өмнөөс дөхөн ирж явааг хараад бид гайхахын ихээр гайхаж билээ. Тэр бидэнтэй халуун дотноор мэндчилж, инээмсэглэн биднийг чанга тэврэв. Бид түүнийг ийм орой гадаа байгаад нь гайхаад юу хийж байгаа юм бэ гэж асуусан.

“Би шинэ ажилдаа явж байна. Машинтай хүмүүст цонхоор түргэн хоолоор үйлчилдэг зоогийн газарт шөнийн ээлжинд ажиллаж байна” гэж тэр хөгжилтэйгөөр хариулав.

Энэ ажил түүний өмнөх ажлаас цалин үлэмж бага атлаа хариуцдагатай, олон цаг ажиллахыг шаарддаг ажээ. Тэр эмэгтэй амьдралдаа тохиолдсон хүнд сорилт бэрхшээлүүдийг үл хайхран, хөгжилтэй харагдаж байлаа. Тэгээд тэр баптисм хүртэх өдөр нь товлогдсоныг хэллээ. Леса бид хоёр номлолын гэрт буцаж ирээд, зарлигуудад итгэлтэй, дуулгавартай байсан нь түүнийг жинхэнэ баяр баяслын зам дээр хэрхэн гаргасныг гайхан ярилцав.

Цөөхөн долоо хоногийн дараа тэр баптисм хүртэв. Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэр гэрийнхэнтэйгээ эвлэрч, илүү сайн ажилд орсон. Тэрээр баптисмаасаа хойш хэдхэн жилийн дараа буцаж ирсэн нэг номлогчтой Токиогийн ариун сүмд гэрлэж, лацдан холбуулсан билээ. Тэр түүнтэй ганц бие залуу насанд хүрэгчдийн үйл ажиллагаан дээр танилцсан ажээ. Тийнхүү тэд мөнхийн гэр бүл болж, саяхан хөөрхөн хүүтээр адислагджээ. Зарлигуудыг сахисны ачаар түүний амьдралд ямар өөрчлөлт гарсныг дараах



богинохон мөртлөө яруу сайхан дуу дүрслэн харуулж байна:

*Зарлигуудыг сахь; Зарлигуудыг сахь!  
Үүнд аюулгүй байдал буй; үүнд амар амгалан буй.*

*Тэр адислалуудыг илгээх болно;  
Тэр адислалуудыг илгээх болно.*

*Бошиглогчийн үгсийг сонс:*

*Зарлигуудыг сахь.  
Үүнд аюулгүй байдал ба амар амгалан буй.<sup>2</sup>*

Мормоны Номон дахь загварууд болон үнэнүүд тодорхой бөгөөд сургамжтай, энгийн бөгөөд үнэ цэнэтэй юм. Бид шударга бөгөөд дуулгавартай байвал, олон адислал авч, баяртай байх болно. ■

#### ЭШЛЭЛ

1. Спенсер В.Кимбалл, “The Blessings and Responsibilities of Womanhood,” *Ensign*, 1976 ны 3-р сар, 70.
2. “Keep the Commandments [Зарлигуудыг сахь],” *Children's Songbook*, 146–47.

**Биднийг хөл хөдөлгөөн ихтэй замын уулзвараар гарч явтал нөгөөх цоглог залуу сонирхогч дугуйгаараа өмнөөс дөхөн ирж явааг хараад бид гайхахын ихээр гайхаж билээ. Бид номлолын гэрт буцаж ирээд, зарлигуудад итгэлтэй, дуулгавартай байсан нь түүнийг жинхэнэ баяр баяслын зам дээр хэрхэн гаргасныг гайхан ярилцав.**

## БИД ИЙМ ОЛОН ХҮҮХДИЙГ ЯАЖ ХООЛЛОХ ЮМ БЭ?

**М**иний бие Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчийн хувьд манай жижигхэн салбарын зарим гэр бүлийн хэрэгцээ, тэдэнд тулгарч байгаа сорилт бэрхшээлүүдэд санаа их зовдог. Эдийн засгийн байдал хүнд байлаа. Нэлээд хэдэн гишүүн ажилгүй болов.

Гэр бүлээ тэжээх нь олон хүний хувьд толгой гашилагасан асуудал болж, урам хугаралт, цөхрөл газар авч, итгэл найдвар алдрах нь Сүмийн гадна талд ердийн зүйл болоод байв. Бүр хүүхэд залуучуудын дотор дэг журамгүй, ирээдүйдээ үл итгэсэн байдал бий болоод байв.

Итгэл найдвар, энэрэл хайр, тусламж дэмжлэг хамгийн их хэрэгтэй байгаа хүмүүст юуны өмнө туслах хэрэгцээг салбарын удирдагчид мэдэрч, Тэнгэрлэг Эцэг тэдэнд тохиолдсон сорилт бэрхшээлийг

мэдэж байгаа, тэднийг дээрээс харж тусалж дэмжих болно гэдгийг мэдэрэхэд нь манай нийгэм дэх хүмүүст туслахыг хичээж байлаа.

Христийн Мэндэлсний Баяр ойртсон үед бид оршин суугаа газрынхаа хамгийн ядуу хүүхдүүдийг зоогт урих санал гаргав. Салбарын гишүүд янз бүрийн аргаар мөнгө цуглуулж, түргэн хоолны газраас хоол, хүнс худалдан авч, цуглааны байруудаа зочид (хүүхдүүд) хүлээн авахад бэлтгэв. Энэ ажилд хүн бүр түүний дотор Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд, залуу эмэгтэйчүүд, залуу эрэгтэйчүүд оролцов.

Бид түргэн хоолоор үйлчлэх ажлыг зохион байгуулахдаа хамгийн ядуу гэр бүлүүдийг олохын тулд нийгмийн ажилтнуудтай холбоо барив. Нийгмийн ажилтнууд бидэнд 100 орчим хүүхдийн нэрсийн жагсаалт өгсөн нь бидний бодож

байснаас илүү олон байлаа. Ийм олон хүүхдэд зориулж хоол хүнс худалдан авах мөнгө цуглуулна гэдэг боломжгүй юм шиг санагдаж байсан ч бид зорилгоосоо ухарсангүй.

Хүүхдүүдийг хооллох өдөр болоход салбарын ерөнхийлөгч хэдэн диконтой хамт ирж, бидний цуглуулсан мөнгийг аваад зоогийн газар руу явахад, бидний цуглуулсан цөөхөн мөнгөөр ийм олон хүүхдийг яаж хооллох юм бол доо хэмээн бид гайхаж билээ. Тэд зоогийн газар явах үедээ, зөвхөн бага насны хүүхдүүдийг урьж, хоолыг таллан өгөх юм уу эсвэл энэ үйл ажиллагааг хойшлуулах хэрэгтэй гэж бодон залбирчээ.

Тэд зоогийн газарт хүрч ирэхэд салбарын ерөнхийлөгч мөнгөө гаргаж, лангуун дээр тавихад тэдний залбирал хариулагдсан ажээ.

Зоогийн газрын менежер тэднийг хараад инээмсэглэснээ, тэдэнд хэчнээн хоол хэрэгтэй байгаа юм, тэр бүгдийг зоогийн газар үнэгүй өгөхдөө баяртай байх болно хэмээн хэлсэн гэнэ! Тусламж хэрэгтэй өдий олон хүүхдийг ийнхүү өгөөмөр сэтгэл гарган, элбэг дэлбэг хоолоор дайлсныг мэдээд бид бүгд баярлан ура хашгирахад хүргэсэн тэрхүү баяр хөөрийг би үгээр илэрхийлж чадахгүй байлаа.

Тэрхүү өглөгч зоогийн газрын ачаар, хоол авахаар цуглуулсан мөнгөөр бид хамгийн ядуу айлуудад олон сагс дүүрэн хүнсний зүйл худалдан авч хүргүүлсэн билээ.

Бид авьяас чадвар, сайн санааны хүслээ бусдад үйлчлэхэд зориулбал бидний хүч чармайлт талаар өнгөрдөггүйг бид энэ туршлагаас мэдсэн юм. Бид чадах бүхнээ хийсний эцэст Их Эзэн боломжууд хийгээд шийдлээр хангахад бидний гэрчлэл илүү бат бөх болдог билээ. ■

Марта Фернандез-Реболлос, Испани

*Салбарын ерөнхийлөгч мөнгөө гаргаж, лангуун дээр тавих үед тэдний залбирал хариулагджээ.*





# ХӨӨРХӨН ХҮҮХЭЛДЭЙД МИНЬ ШИНЭ ЭЗЭН НЬ ХАЙРТАЙ БАЙХ БОЛНО ГЭДЭГТ БИ ИТГЭЛТЭЙ БАЙНА

**Х**үү минь гуравтай, охин минь дөрөвтэй байх үед тэр хоёр манай гэрийн ойролцоох сургуулийн өмнөх насны хүүхдийн бүлэгт явдаг байлаа. Тэр өвөл манай хоёр хүүхэд Христийн Мэндэлсний Баярын төсөл хэрэгжүүлэх бүлэгт оролцож, тусламж хэрэгтэй нэг айлд хүүхэд бүр нэг тоглоом хандивлах үүрэг хүлээсэн юм.

Өмнөх долоо хоногуудад бид талархал болон бусадтай хуваалцах нь биднийг хэрхэн аз жаргалтай болгодог тухай олон хичээлийг хүүхдүүдээ заасан байлаа. Тэд ямар тоглоом өгөхийг хүсч байгаа болон тоглоом сонгохдоо юуг анхаарвал зохихыг би хүүхдүүдээ хэллээ. Манай гэр бүлийн санхүүгийн боломж хязгаарлагдмал байсан учраас би чухам ямар тоглоомууд өгөх хүсэлтэй байгааг нь сонирхлоо.

Нэг хагас сайн өдрийн өглөө, хандивлах тоглоомоо сонгох цаг болсныг би хүүхдүүдээ сануулав. Би Хантерт сонгож авсан ачааны машиныг нь бооход туслаад Микелл ямар тоглоом өгөхөөр болсныг харахаар явлаа. Охиныхоо өрөөнд ороод харсан зүйл, нүднээс нулимс аяндаа урсахад хүргэв.

Микелл, Мелла нэртэй хайртай хүүхэддэйгээ хамгийн гоё хувцсаар нь хувцаслаад, хүүхэддэд дуу дуулж өгч байлаа. Тэгээд тэр жижигхэн хөнжлийг бэлгийн цүнхний ёроолд хийв. Микелл хүүхэддэйгээ харж инээмсэглээд, түүнийг тэвэрч үнссэнээ, цүнхэнд дуртай нь аргагүй хийлээ. Тэр намайг хараад, “Мелла бэлэн болсон шүү, ээж ээ” гэв. Хөөрхөн хүүхэддэд минь шинэ эзэн нь хайртай байх болно

*Нэг хагас сайн өдрийн өглөө, хандивлах тоглоомоо сонгох цаг болсныг би хүүхдүүдээ сануулав. Охиныхоо өрөөнд ороод харсан зүйл, нүднээс нулимс аяндаа урсахад хүргэв.*

гэдэгт би итгэлтэй байна.

Охин минь энэ хүүхэддэд хэчнээн хайртайг би мэдэх учраас түүнийгээ өөр хүүхэдэд өгч байгааг хараад би мэл гайхав. Хайртай хүүхэддэйгээ бусдад өгч хэрэггүй гэж би охиндоо хэлэх гэснээ больж, амаа хамхив.

“Өгөх гэж юу болохыг, тэгэхдээ бүр хамгийн сайн юмаа бусдад өгөх хэрэгтэйг охин минь ойлгож дээ” гэж би бодлоо.

Бусдад өгөх, хуваалцах сэтгэл надад ямар нэг хэмжээгээр байгаа ч, тэр нь их хэмжээний золиослол байж чадахгүйг би гэнэт ойлголоо. Надад энэрэл багахан байгааг бас өөрчлөгдөх хэрэгтэйгээ мэдэрлээ.

Тэнгэрлэг Эцэг хэрхэн цорын ганц төгс Хүүгээ өгч, Түүнийг миний төлөө зовлон эдэлж, амиа өргөхөөр болгосныг би бодлоо. Хайраар дүүрэн Тэнгэр дэх Эцэг минь Хайртай


Хүүгээ дэлхийд илгээхдээ Түүнийг бяцхан хөвгүүн лүгээ адил үнсэн, бид түүнийг хайрлаж, түүнийг дагах болно гэдэгт итгэлтэй байсан даа хэмээн би төсөөлөн бодлоо.

Аврагч юугаа ч харамлаагүй Өөртөө байсан бүхнийг өгсөн билээ.

Микелл тоглоом хандивлах бодлоо Христийн Мэндэлсний Баярын өмнө өөрчилсөн бол яах байсан бол гэж би бодлоо. Гэвч тэр тэгээгүй юм. Бас буруу сонголт хийснийхээ төлөө хожим нь харамсвал яана гэж би бодсон. Гэвч тэр тэгээгүй.

Охиныхоо Христийнхтэй адил үлгэр жишээг хараад, бусадтай хуваалцах боломж олдсон үед ихийг ч өгсөн, багыг ч өгсөн ялгаагүй, хамгийн сайн юмаа үргэлж баяртайгаар өгч байх юм шүү хэмээн би дотроо шийдэж билээ. ■

Бриттни Пайн, Юта, АНУ



# ЗҮРХ СЭТГЭЛЭЭСЭЭ ДУУЛАГТУН

**2000** оны арванхоёрдугаар сард манай гадасны найрал дуучид найрал дууны баярт бэлтгэж байлаа. Аргентины Посадас хотын алдартай нэлээд хэдэн найрал дуу баярт оролцоно гэдгээ мэдэгдсэн болохоор олон хүмүүс концертийг үзэх бололтой байв. Бид дуугаараа дамжуулан Аврагчийн төрөлтийн тухай гэрчлэлээ хуваалцах болно гэдэгт итгэлтэй байлаа.

Найрал дууны удирдагчийн хувьд миний санаа нэлээд зовж байлаа. Би найрал дууны баярын талаар санаа зовохын хамт тэр үед найман сартай жирэмсэн байсан юм. Концертоос долоо хоногийн өмнө болсон сүүлчийн сургуули-тын үеэр өвдсөн учир би суугаа-раа найрал дууг удирдаж билээ.

Сургуулилт дуусах үеэр би бүр зогсож чадахгүй байлаа. Миний нөхөр Карлос, аав хоёр надад адис-лал өглөө. Тэгээд Карлос намайг эмнэлэгт аваачиж үзүүлэхэд эмч нар намайг тэр өдөртөө амаржиж ихэр хүүхэд төрүүлэх болно гэв. Намайг айхад Карлос Их Эзэнд итгэлтэй бай гэж хэлсэн.

Удалгүй төрсөн хүүхдийн уйлах дуу өрөөнд хадав. Миний зүрх сэтгэл баяраар бялхан байтал эмч над руу ойртож, “Энэ бол Кира уйлж байна, харин Абрил уйлахгүй байна” гэв.

Тэр үед надад үгээр дүрслэн илэрхийлэхийн аргагүй мэдрэмж төрж билээ. Би удалгүй өөр өрөөнд шилжиж ороход манай нөхөр тэнд намайг хүлээж байв. Бид хоёр тэв-рэлдэж, уйллаа.

“Дафне, Абрилыг Өөртөө авсан Их Эзэний зорилгыг бид мэдэхгүй шүү дээ” гэж Карлос хэллээ. “Тэвч бид тэвчээртэй байж, Түүний хүс-лийг хүлээн авч, итгэлээрээ урагш тэмүүлэх ёстой.”

Дараахан нь, Карлос бяцхан

Кираг гартаа барьж, түүнд энх тунх амьдрахын төлөө адислал өгөв.

Кира охин төрсний дараах дасан зохицолтод хүндрэл гарсны улмаас 10 хоног эмнэлэгт байсан ч энх тунх өсөн бойжсон юм.

Би дараагийн долоо хоногт нь эмнэлгээс гарсан. Би эмнэлэг рүү байнга очиж, Кираг хөхүүлдэг бай-сан болохоор найрал дууны тухай бараг мартчихаад байв. Найрал дууны баярын өмнөх орой аав на-даас найрал дуу удирдах хэвээрээ байгаа юу гэж асуув. “Энэ талаар залбир. Ямар ч шийдвэр гаргалаа гэсэн чиний зөв байх болно” гэж аав хэлж билээ.

Эмнэлэгт байгаа бяцхан Кирагаа би бодлоо. Концертод шаргуу

*Найрал дуучдын дуу хөгжимтэй нийлэн эгшиглэхэд би дээдийн дээд сайхан газар байгаагаа сэтгэл зүрхнийхээ гүнээс мэдэрч билээ.*



бэлтгэж байсан найрал дууны гишүүдээ би бодлоо. Аврагч болон Түүний төрөлт, амьдрал, золиосло-лынх нь талаар би бодлоо. Тэгээд би яах хэрэгтэйгээ мэдсэн.

Маргааш орой нь найрал дууны гишүүдээс манай гэр бүлийн хү-лээн авсан хайр, эв нэгдлийн сүнс нь найрал дуунд оролцсон бүх хүмүүст зүрх сэтгэлийн талархлаа илэрхийлэх хүслийг бидэнд төрүүл-сэн юм.

Манай гадас найрал дууны бая-рыг санаачлан зохион байгуулсан учир бид хамгийн сүүлд дууллаа. Төгөлдөр хуур, хийл хөгжим “The First Noel”-ын оршлыг тоглоход миний хацрыг даган нулимс урсаж байлаа. Дараа нь найрал дуучдын дуу хөгжимтэй нийлэн эгшиглэ-хэд би дээдийн дээд сайхан газар байгаагаа сэтгэл зүрхнийхээ гүнээс мэдэрч билээ.

Концерт дуусахад би эргэж хар-вал үзэгчдийн ихэнх нь нүдэндээ нулимстай байлаа. Сайн мэдээний амар амгалан, хайр энэрлийн захиа-сыг хэзээ ч мэдэрч байгаагүй хү-мүүс Бурханы Хүүгийн төрөлтийн гайхамшиг хийгээд агуу сайхныг бидний дуу хөгжмөөр дамжуулан мэдэрсэн биз ээ.

Хожим нь, бусад найрал дуунуу-дын удирдагчдын нэг нь, “Бид сайн арга техникээр дуулсан бол харин та нар зүрх сэтгэлээсээ дуулсан шүү” хэмээн бидэнд хэлж билээ.

Христийн Мэндэлсний Баяраар нөхөр бид хоёр манай ам бүлд Кираг илгээсний төлөө, хайртай Хүүгээ дэлхийд илгээсний төлөө Бурханд талархал илэрхийлсэн. Хүүгийн цагаатгал болон Ариун сүмд хийлгэсэн бидний лацдал-тын ачаар хэзээ нэгэн цагт Абрил бидэнтэй хамт байна гэдгийг бид мэднэ. ■

Дафне Аналия Ромеро де Тау, Мисионес, Аргентин



# ЭРДЭНЭ ШИШ, АНХДАГЧИД БА АМАР АМГАЛАН

**Б**ид халаагчгүй машинаар явах учир бидний хөлийг дулаацуулахын тулд пийшин дээр хэдэн тоосго тавьж халаагаад хөнжилд ороолоо. Энэ бол 1935 он байсан бөгөөд бид арванхоёрдугаар сарын эхээр өвөө, эмээ хоёр дээрээ айлчилж очихоор Солт Лейк хотоос Ютагийн Песон руу 96 км явах хэрэгтэй байв. Цас зөөлхөн бударч, бидний өмнөх зам дээр цас хуйлран жижигхэн хуй үүсгэнэ. Манай том ах Фред бид хоёр зузаан хүрэм, хөл загатнуулам бүдүүн ноосон оймс өмсөж, ноосон ороолтоор хүзүүтээ ороосон байлаа. Долоон настай балчир хөвгүүн надад энэ аялал эцэс төгсөлгүй урт юм шиг санагдаж билээ.

Бид жил бүр арванхоёрдугаар сард ийм аянд гардаг байв. Манай эмээ өвөө хоёр Таннерын эрдэнэ шишийн бин хийдэг дулаахан гал тогооны өрөөнд орсон үедээ л бид Христийн Мэндэлсний Баярын уур амьсгалыг жинхэнэ ёсоор мэдэрдэг байлаа. Өвөө галаа түлэхэд эмээ төмөр утсан сагсаа эрдэнэ шишээр дүүргэж, гал дээр хэд хүчтэй сэгсрэхэд эрдэнэ шиш хөөсрөн цагаан болно. Эмээ том ширмэн данхан доторх эрдэнэ шишин дээр зөгийн халуун бал, цөцгийн тос дусааж, газрын самартай хольж хутгана. Холимгийг хөргөхөд бид тостой гараар барин ёстой л амаа олохгүй, үмхэлж гарна. Дараа нь гэр бүл, найз нартайгаа хуваалцахаар бөмбөлгүүд хийнэ.

Гэвч энэ удаагийн Христийн Мэндэлсний Баяр өөр байлаа. Фред бид хоёр ихэвчлэн арын суудал дээр суудаг байсан бол энэ жил бид хоёр өмнө талын вандан суудал дээр аав, ээж хоёрын хооронд чихцэлдэн явна. Нэг настай миний эрэгтэй дүү Герольдын минь цогцостой жижигхэн цагаан авсыг авч

явлаа. Улаан бурхан уушигны хатгалгаа болон хүндэрч, нялх дүүгийн минь аминд хүрсэн юм. Бид өглөө эрт цогцос хадгалах газарт очиж жижигхэн модон авс авсан юм.

Хоёр цаг явсны дараа аав биднийг удирдан Христийн Мэндэлсний Баяр дуунууд дууллаа. Аав, ээж хоёрын хоолой нийлэн дуулахад бяцхан хөвгүүнээ алдаад гашуудаж явсан биднийг тэр сайхан дуу тайтгаруулж билээ.

Биднийг өвөөгийн байшинд хүрч ирэхэд, садан төрлийн баахан улс биднийг хүлээж байлаа. Авсыг хойд талын суудлаас авч өвөөгийн сэрүүн лавринд оруулав. Өвөөгийн бишоп товчхон үг хэлсний дараа бид буцаж машиндаа суугаад оршуулгын газар руу явлаа. Бид тэнд очоод хөөрхөн хөвгүүнийг хөлдүү газарт нутаглуулах болсондоо бүгд мэгшин уйлж байлаа.

Христийн Мэндэлсний Баяр болов. Гал түлж, эрдэнэ шишээр бин хайраад өвөөгийн морин чарган дээр эрдэнэ шишээр хийсэн баярын

бөмбөлгүүдийг хүмүүст тарааж өгөв. Тэр өдөр гунигтай байсан ч, итгэл бишрэл ихтэй өвөө, эмээ хоёрын уншсан Христийн төрөлтийн түүхийг сонсоход ер бусын хүчтэй мэдрэмж төрж байж билээ.

Манай өвөө эмээ хоёр бол анхдагч эцэг эхийн хүүхдүүд юм. Анхдагчид олон хүүхдээ хээр талд оршуулсан гэдэг. Манай гэр бүл бяцхан хөвгүүнээ алдсанд гашуудаж байх үеэрээ бидний өвөг дээдэс Бурханы Хүүд хандан Түүний үгийг сонсож байсан газарт очиж үзлээ. Тэр жил бидний сонссон Христийн Мэндэлсний Баярын түүх ердийнхөөс өөр байсныг би санадаг. Учир нь тэжээлийн тэвш өлгий нь байсан бяцхан хөвгүүн амилсан шиг хөлдүү газарт оршуулсан бидний бяцхан хөвгүүн дахин амьдрах болно гэдэгт бид итгэлтэй байлаа.

Тэр өдрөөс хойш олон арван жил өнгөрсөн ч би Христийн Мэндэлсний Баяр болгоноор эрдэнэ шишийн бин дээр зөгийн балтай цөцгийн тос түрхэж, самартай хутган, холимгийг бөмбөлөг хэлбэртэй болгодог хэвээр байгаа мөн ингэдэг байснаа эргэн санадаг. ■

Шерли Хөрст Шийлдс, Юта, АНУ

*Хоёр цаг явсны дараа аав биднийг удирдан Христийн Мэндэлсний Баяр дуунууд дууллаа. Аав, ээж хоёрын хоолой нийлэн дуулахад гашуудаж явсан биднийг тэр сайхан дуу тайтгаруулж билээ.*





**Ахлагч  
Жеффри Р.Холланд**

Арванхоёр Төлөөлөгчийн  
Чуулгын

# ТА НАРЫН ДУНДАХ Христийн Мэндэлсний Баяр

*Итгэлдээ тууштай бай.  
Өөрийнхөө нөхцөл байдлаас  
сайн бүхнийг эрж хай. Хэн  
нэгэнд ямар нэг сайн зүйлийг  
хий. Христийг элдэв эрээн  
мяраан, чамин зүйлсгүйгээр  
эрж хай.*

Гэр орноосоо хол байх үед тэмдэглэсэн анхны Христийн Мэндэлсний Баярыг хүн бүр санадаг гэж би боддог. Бид номлолд буюу цэрэгт явах, оюутан болох буюу ажилд орсноор гэр орноосоо хол амьдрах шаардлагатай болж болно. Ямар ч шалтгаанаар байсан, гэрээсээ хол тэмдэглэсэн анхны Христийн Мэндэлсний Баяр бид бүгдэд гунигтай дурсамж үлдээдэг. Христийн Мэндэлсний Баяраар гэрээсээ хол байгаа эсвэл энэ жил гэрээсээ хол байгаа хүмүүст би өөрийн дурсамжийг зориулж байна.







ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ПОЛ МАНН

Тэгэхэд би номлолд үйлчилж байлаа. Би үүнээс өмнө 19 жил Христийн Мэндэлсний Баярыг гэр бүл, найз нөхөдтэйгөө хөгжилдөн тэмдэглэсэн юм. Би бага залуудаа Христийн Мэндэлсний Баярыг үүнээс өөр байдлаар өнгөрүүлэх юм гэж огт боддоггүй байснаа санадаг.

Гэтэл 1960 оны Христийн Мэндэлсний Баяр ойртож байсан үед би гэр бүл, найз нөхдөөсөө алс хол дэлхийн нөгөө хагаст байлаа. Тэр үед би Англид ирээд гурван сар орчим болж байсан бөгөөд би Канадын Альбертагийн Чемпионоос шинээр ирсэн, өөрийн анхны бага хамтрагч Ахлагч Элдон Смитийг угтаж авахаар номлолын оффист анх удаа арванхоёрдугаар сард дуудагдсан юм. Биднийг урьд өмнө нь Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид хэзээ ч очиж байгаагүй нутаг Сөрри гүнлэг дэх Гильдфорд хэмээх хуучныг баримтлагч хотод номлолын ажлыг эхлүүлэхээр явуулав. Бидний мэдэхээр тэндхийн цорын ганц гишүүн тэр нутагт хаа нэгтээ нуугдаж байгаа ажээ. Бид нас залуу, туршлагагүй, сэтгэл бага зэрэг зовж байсан ч, бидний зориг мохож, зүрх үхээгүй юм.

Бид хоёр цагдаагийн газарт бүртгүүлж, орон байр олж төвхнөөд, юуны өмнө цорын ганц Сүмийн гишүүнээ хайсан ч олж чадсангүй, тэгээд өөрсдийн мэддэг цорын ганц зүйлийг хийж эхлэв. Энэ бол айлуудаар явж хаалга тогших ажил байлаа. Бид хоёр өглөө, өдөр, үдээс хойш, бас орой үдшийн цагаар хаалга тогшин явна. Британий түүхэнд хамгийн их бороотой сар байсан болов уу хэмээн бидний бодсон тэр нэгэн арванхоёрдугаар сард бид хоёр унадаг дугуйгаар хотын гудамжуудаар хэрэн явдаг байлаа. Бид хоёр

өглөө, өдөр, үдээс хойш, орой уулздаг байсан ч хаалга тогшихоо үргэлжлүүлсээр байлаа. Тэгсээр бидний захиасыг сонсох ердөө ганц хоёрхон хүн л олдов.

Ийм байдлаар Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдшийг үзлээ. Британий “колони нутгаас” ирсэн хос номлогчийг хүмүүс сонсох төдийлөн дургүй байсан юм. Тэр үдэш бид хоёр ядарсан ч гэсэн сэтгэл санаа өөдрөг байж, түрээсийн ганц өрөө байрандаа эргэж ирээд Христийн Мэндэлсний Баярын онцгой цугларалт хийлээ. Бид Христийн Мэндэлсний Баярын дуулал дуулж, нээлтийн залбирал хэлээд, судруудаас уншиж, *Христийн Мэндэлсний Баярын үнэн түүхүүд нэртэй магнитофоны бичлэгийг сонсов*. Тэгээд бид Христийн Мэндэлсний Баярын сэдэвтэй өөр нэг дуулал дуулж, хаалтын залбирал хийгээд унтав. Бид Христийн Мэндэлсний Баярын сайхан зүйлсийг мөрөөдөхөд хэтэрхий ядарсан байлаа.

Христийн Мэндэлсний Баярын өглөө бид хоёр судар судлах хуваарьт цагаа мөрдсөний дараа биднийг энд шилжиж ирснээс хойш ирсэн хоёр гурван боодлыг задлав. Тэгээд бид хаалга тогшихоор гарлаа. Бид хоёр өглөө, өдөр, үдээс хойш, бас орой үдшийн цагаар хаалга тогшин явлаа. Тэгээд ганц ч хүн олсонгүй.

Ийм нэгэн онцгой сонин бус атлаа түүнээс өмнө ч, дараа нь ч надад тохиолдоогүй Христийн Мэндэлсний Баярын 1960 оны арванхоёрдугаар сарын тэр өдрүүд миний хувьд хамгийн сайхан Христийн Мэндэлсний Баяруудын нэг болон зүрх сэтгэлд минь хоногшин үлдсэн юм (50 гаруй жилийн дараа тэр шүү дээ!). Энэ бол Христийн Мэндэлсний Баярыг би амьдралдаа



анх удаа зүгээр л хөгжилтэйгөөр тэмдэглэж өнгөрүүлэх биш харин энэ баярын утга учрыг өөрөө ойлгосных байх гэж боддог. Мөн би амьдралдаа анх удаа ийнхүү чухал арга замаар Христийн төрөлт ба амьдралын тухай захиасыг, Түүний сургаал, Түүний үүрэг зорилго болон бусдын төлөө хийсэн Түүний золиослолын утга учрыг ойлгосон гэж боддог.

Би дээрх зүйлсийн уялдаа холбоог бага насандаа ойлгох ёстой байсан юм. Чухамдаа, багаар бодоход ийм ойлголт надад хангалттай хүчтэй төлөвшөөгүй байлаа. Гэвч, бороонд норж, даарсан, санаа нь зовсон 19 настай номлогч миний бие Англид болсон Христийн Мэндэлсний тэр нэгэн Баярыг “ойлгосон юм.” Тэр явдлаас хойш Христийн Мэндэлсний Баяр нь сайн мэдээний бусад олон талын нэгэн адил надад жил бүр чухал үйл явдал болсныг би баттай хэлж чадна. Энэ нь миний номлолоос үүдэлтэй биз ээ.

Христийн Мэндэлсний энэ удаагийн Баяраар би номлогч бүрд, цэргийн алба хааж буй эрэгтэй, эмэгтэй бүрд, мөн магтуу дуунд өгүүлдгээр, “Христийн Мэндэлсний Баяраар гэртээ байхгүй”<sup>1</sup> ажилчин хийгээд аялагч бүрд өөрийн хайрыг илгээж байна. Итгэлдээ тууштай бай. Өөрийнхөө нөхцөл байдлаас сайн зүйлийг эрж хай. Хэн нэгэнд ямар нэг сайн зүйлийг хий. Христийг элдэв эрээн мяраан, чамин зүйлсгүйгээр эрж хай. Та нар гадаад нөхцөл байдлыг эс хайхран, Христийн Мэндэлсний Баяр бол “та нарын дундах” (Лук 17:21) Бурханы хаант улс болохыг олж мэдэх болно. ■

*“A Mission Christmas”-ээс авч нийтлэв, Church News, 2011 оны 12-р сарын 17, 10.*

#### ЭШЛЭЛ

1. James “Kim” Gannon, “I’ll Be Home for Christmas” (1943).





# Христийн Мэндэлсний Баярын чимэглэл ба Христтэй адил найзууд

Би Христийн Мэндэлсний Баярын сүлд модоо чимэглэхээр бэлтгэж байхдаа чимэглэлээр дүүрэн хайрцгийг задалтал сүүлийн хэдэн жил хараагүй эсвээс баярын сүлд модоо чимэхэд ашиглаж байгаагүй олон чимэглэл байлаа. Христийн Мэндэлсний Баярын гэрлэн чимэглэл, цагаан хэрэгслүүдийг онгичиж байгаад, гэрлээгүй бөгөөд сургуульд багшилж байхдаа цуглуулсан баярын хээ угалзтай даашинзыг оллоо. “Христийн Мэндэлсний Баярын Нээлттэй Хаалга—1984” гэсэн үгстэй хэрээс хатгасан нь энгийн хээ байлаа. Би тэр жилийг тодхон саналаа. Тэр үед би гэрлээгүй байсан бөгөөд ганц бие залуу насанд хүрэгчдийн тойргоос гэр бүлийн тойрогт шилжиж ирэхдээ ямар нэгэн базаахгүй юм тохиолдох юм шиг айн сүрдэж байлаа.

Би Христийн Мэндэлсний Баярын үед дуртай байсан ч зарим хүмүүс энэ үеэр их ганцаардаж байх шиг санагддаг байв. Нас 30 гарсан ч, ганц бие, хүүхэдгүй байсан болохоор би заримдаа өөрийгөө шоовдорлогдсон хүн гэж боддог байв. “Би ч өрөвдмөөр хөөрхийлөлтэй амьтан даа” гэж бодохоор өөрийгөө чамлах сэтгэл аяндаа төрнө. Миний хувьд онцгой жил болсон 1984 онд, өөрийгөө шоовдорлогдсон хүн гэж үздэг сэтгэлгээгээ ялж, зөвхөн өөрийнхөө тухай бодох биш, харин

Христийн Мэндэлсний Баяр бусад хүмүүст баяр баяслыг бэлэглэдэг болоход юу хийж чадахаа үзэхээр шийдсэнээ би санадаг.

Тойрогтоо би харьцангуй шинэ хүн байсан болохоор даруухан ганц өрөө байраа Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүдэд нээлттэй болговол баяр тэмдэглэх болон эгч нартайгаа илүү сайн танилцахад надад туслах болно гэж бодлоо.

Би тэрхүү нээлттэй хаалганы тухай бодохоороо Христийн Мэндэлсний Баярын бяцхан сүлд модоо чимсэн хээ угалз, ганц бие найз нартайгаа хамт хийсэн жигнэмгийн сайхан үнэр, ээжийнхээ хийсэн Христийн Мэндэлсний Баярын сайхан амттай ундаагаар зочдоо дайлдаг байснаа санадаг.

Янз бүрийн хээ угалз цуглуулах үед бас сорилт бэрхшээлийн үед намайг хайрлан, халамжилж байсан Христтэй адилхан хөгшин, залуу олон найз нөхдийнхөө тухай бодох үед зүрх сэтгэл минь хайр, талархлын элгэн халуун мэдрэмжээр дүүрдэг байлаа.

Настай нэг эмэгтэй надад зориулж, сүлжмэлийн ганц зүүтээр цасан ширхэг гаргаж хатган, цардуулдсан сүлжмэл торыг гаргаж ирлээ. Өөрийн харьяалагдаж байсан тойргуудын халамжийн эгч нар өөрсдийнхөө тухай мартагдашгүй дурсамжийг надад үлдээсэн тухай би үргэлж боддог

**Мэри Н.Кук**

Залуу Эмэгтэйчүүдийн  
Ерөнхий ерөнхий-  
лөгчийн зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх



байлаа. Би эдгээр сайхан сэтгэлт эгч нараас ганц зүүтээр нэхмэл, хатгамал хийж, оёж сүлжиж сурсан. Тэд өөрсдийнхөө дуртай зүйлд намайг дуртай болгохын тулд цаг заваа зориулж, онцгой тэвчээрийг харуулсан юм.

Би нэгэн жижигхэн зэс бүрээ гаргаж ирээд, намайг өсвөр насны охин байхад хөгжмийн онцгой авьяастай, найрал дууны удирдагч, өглөө эрт сургуулид хөгжмийн тусгай хөтөлбөрт оролцоно уу хэмээн намайг урьсныг саналаа. Түүний урилга сонгодог хөгжимд дуртай болж, амьдралынхаа үлдсэн хугацаанд найрал дуунд оролцоход надад сүнслэгээр нөлөөлсөн юм.

Микки Мауз хээг инээмсэглэн гаргаж ирээд, дөнгөж хөлд орж байсан хүүхдүүдээ яг л өөрийн хүүхдүүд шиг харж хандах боломжийг надад олгосон, гэр бүлийн тэр нэгэн хост баярлан талархах сэтгэл төрлөө. Би тэдний хүүхдүүдийг сүмд авч очин, тэдэнд ном уншиж өгч, хамт тоглон, тэднийг хайрласнаар сэтгэл санаандахь хоосон орон зай, эмзэглэлийг бөглөхийг хичээдэг байлаа.

Матай 10:39-т Аврагч, “Амиа ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа алдсан нь түүнийгээ олох болно” хэмээн бидэнд сургасан билээ.

Тийнхүү 1984 онд “өөрийгөө хаяж” бусдын төлөө санаа тавьж, тэдэнд үйлчлэхээр шийдсэн нь чухамдаа өөрийгөө “олсон” эргэлтийн цэг болсон юм. Би өнгөрсөн үеэ эргэцүүлэн бодоод, миний үйлчлэлийн хариуд олон хүн Аврагчийн үгийг дагаж, миний төлөө амьдралаа зориулж байсныг ойлгосон. *Христийн Мэндэлсний Баярын* чимэглэл надад *Христтэй* адилхан найз нарын минь сануулагч болсон билээ. ■

# Христийн Мэндэлсний Баярын алчуур

Скотт М.Моёо

Сүмийн сэтгүүлүүд

**Б**и бага байхдаа жил бүр гэрийнхэндээ өгөх Христийн Мэндэлсний Баярын бэлгийг бооход ээждээ тусалдаг байлаа. Би тэгэхэд гэрлэсэн 5 ах, эгч, 13 үеэл авга, нагац ах, эгч нартай байсан болохоор бэлэг бооход тусална гэдэг амаргүй ажил байлаа. Олон янзын алаг эрээн юмсын дотор эгчид өгөх бэлгийг алчуурт боох юм байна гэдгийг би ажигладаг байв. Ээж Аннад унтлагын хувцас, ноосон цамц эсвэл гал тогооны ямар нэг хэрэгсэл өгөх байсан ч, түүнд өгөх алчуур үргэлж байдагсан. Алчуур өдөр тутмын хэрэгцээтэй, хямд зүйл гэдгийг би ойлгодог байсан ч, эгч яагаад ийм бэлгийг жил бүр авдаг юм бол гэж гайхдаг байлаа.

Эцэст нь нэг удаа арванхоёрдугаар сард би: “Аннад дахиад л алчуур өгөх юм уу?” Ээж ээ, та түүнд жил болгон алчуур өгөх юм. Одоо түүнд зөндөө олон алчуур байгаа биз дээ? Түүнд хэчнээн алчуур хэрэгтэй юм бэ? Өөр бэлэг өгвөл шуудангаар явуулах боодлын зардал нэмэгдэнэ. Ингэх хэрэггүй гэж би бодох юм” гэлээ.

Ээж хайчаа хажуу тийш нь





тавиад “Чамд нэг түүх ярья. Тэгвэл чи ойлгох болно. Энэ явдал чамайг төрөхөөс өмнө болсон юм.

Намайг энэ оронд хэрхэн ирснийг чи мэднэ шүү дээ” гэв. (Тийм ээ, би мэднэ. Ээжийг дөрвөн хүүхэдтэй бэлэвсэн эртэй гэрлэхэд гэр бүл нь гайхсан ч, түүнийг Голланд орноо орхиж, Нэгдсэн Улс руу цагаачлах болсонд бүр нүд нь орой дээрээ гаран гайхсан гэдэг.) “Гэвч зарим зүйлийг чи мэдэхгүй. Энд хүрч ирэхэд бид юу ч үгүй, гар хоосон байв. Амьдрал хэцүү байлаа. Аав чинь хоёр ажил хийдэг байсан ч цалин нь бага байлаа. Би бусдын юм угааж, индүүднэ. Тэглээ ч гэсэн, бидэнд хангалттай мөнгө байсангүй.

Тэгэхэд Анн 17-той байсан болохоор бид хэдий хэр их өртэйг ойлгодог байсан. Тиймээс тэр бидэнд туслахаар шийдэж, ажил олохоор яваад хотод нэг чихрийн дэлгүүрт ажилд орсон. Анн ажилдаа автобусаар явж, өдөржингөө лангууны ард зогсож ажиллана. Тэр зөвхөн автобусны мөнгө, бага сага идэх юм авах мөнгө (лангууны ард ямар ч идэх юм байлгахыг зөвшөөрдөггүй байсан учир) өөртөө үлдээгээд бараг бүх цалингаа бидэнд өгдөг байсан.

Анн ажилтай болсондоо бас цалин нь бидний амь зуулгад нэмэр боддог байсанд баярлаж явдгаа надад ярьдаг байсан ч, дүү нарынхаа төлөө санаа зовдгоо хэлдэггүй байлаа. Христийн Мэндэлсний Баяр ойртож байв. Тэдний шинэ Америк найзууд Өвлийн өвгөнөөс авчирч өгөөрэй гэж гуйсан олон тоглоомын тухай ярьдаг байж. Гэтэл манай гэрт Христийн Мэндэлсний Баярын ямар ч бэлэг байсангүй!

Христийн Мэндэлсний Баяраас хэдхэн өдрийн өмнө Анн надад мөнгө өглөө. Гэвч тэр өдөр түүний цалин буудаг өдөр биш байв. Энэ мөнгийг хаанаас авсан юм бэ? гэж би түүнээс асуув. Тэр энэ мөнгийг

үдийн хоолоо идэлгүй хэмнэсэн ажээ. Энэ нь их мөнгө биш ч гэсэн тэр хэдэн долоо хоног үдийн хоол идээгүйг би мэдэж байлаа. Анн тэр мөнгөөр дүү нартаа Христийн Мэндэлсний Баярын бэлэг аваарай гэв. Тэр дүү нартаа хэрэгтэй юм худалдаж авна гэж хойд ээж надад итгэсэн хэрэг.

“Би жижиг юмс худалдаж авах хэрэгтэй байсан ч, Христийн Мэндэлсний Баярыг бүх гэр бүлээрээ тэмдэглэхээр шийдэв. Тэгээд би бэрсүүт жүрж, бамбаруушин саван, өнгийн хараандаанууд, тоглоомын машинууд, аавд чинь хэдэн оймс худалдаж авсан. Харин Аннад нэг алчуур авлаа. Тэр алчуур хээгүй байсан ч би шөнө орой болтол сууж, хатгамлаар чимж гоё болгосон юм. Миний шинэ охин бидэнд Христийн Мэндэлсний Баярын бэлэг өгсөнд би их баяртай байлаа. Би ч бас Христийн Мэндэлсний Баяраар охин минь ямар нэг онцгой сонин юмтай байхыг хүссэн.

“Христийн Мэндэлсний Баяр болоо. Манай сүмийн найз нар бидэнд Христийн Мэндэлсний Баярын сүлд мод, хайрцаг дүүрэн бэлэг авчирч өгсөнд бид гайхахын хажуугаар их баярлаж билээ. Бэлэг авчирч өгсөн хүмүүс энэ бол сонинд боосон жижиг зүйлс шүү гэж уучлал гуйсан ч энэ нь үнэхээр гайхалтай сайхан байлаа! Хайрцаганд олон ашигтай зүйлс, сайхан хоол хүнс байлаа. Бас өөр нэг санаандгүй сонин явдал болсон нь: Анн бид хоёрын нууцаар бэлдсэн бүх гэр бүлдээ зориулсан Христийн Мэндэлсний Баярын бэлэг байлаа! Хоёр дүү чинь ёстой л магнай хагартлаа баярласан даа! Удалгүй тэр хоёр жижигхэн өрөөнийхөө шалан дээгүүр машинуудаа сонин дээгүүр бас сонин доогуур давхиулан тоглож гарлаа. Энд тэндгүй л сонин! Анн бэлгээ задалж алчуурыг үзсэнээ уйлж эхлэх нь тэр.

Би ч бас бага зэрэг уйлав.

“Бид бүр Христийн Мэндэлсний Баярын зоог бэлдсэн гээч. Бид удаан хутацаанд ийм сайхан хоол идэж үзээгүй байлаа! Хоолоо идчихээд их цэвэрлэгээ хийв. Анн алчуураа хаа нэгтээ тавьчихаж. Гэтэл алчуур олдсонгүй. Бид газар сайгүй л эрлээ. Өө, аав чинь сонингуудыг гал руу хийгээд байсан. Алчуурыг сонинтой хамт гал руу хийчихсэн юм биш үү? Тэгсэн л байж таарлаа. Бид алчуурыг хаанаас ч олоогүй юм. Харин Анн үглэж гомдоллосонгүй. Болох учиртай юм болсон хэрэг. Дүү нар нь баяртай байсан болохоор би ч бас баяртай байна гэж тэр хэлж билээ.

“Дараачийн Христийн Мэндэлсний Баяраар би Аннад алчуур өглөө. Энэ алчуур алга болохгүй гэдэгт би итгэлтэй байв. Анн гэрлэж, өөр газар шилжихэд би Христийн Мэндэлсний Баярын алчуурыг түүнд шуудангаар явуулдаг болов. Алчуур түүнд хэрэгтэй гэж боддог учраас би түүнд алчуур өгдөг байсан юм биш, харин бид гэр бүлээрээ анхныхаа Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэхэд охин минь юу хийснийг би хэзээ ч мартаггүй гэдгээ түүнд сануулахын тулд түүнд алчуур өгдөг байсан юм.

Хэдэн жилийн дараа миний ээж энэ түүхийг надад ярьсан юм. Бид бүх гэр бүлээрээ Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэж байлаа. Би үймээн шуугиан дунд эгч алчуураа задалж байхыг харав. Тэр ээж рүү хүрч очин гарыг чанга атгах үед нүд нь гэрэлтэн гялаазахыг би хараад учрыг ойлголоо. Энэ бол ердийн нэг алчуур байсангүй. Тэр алчуур хайр, бэлэг, золиослолын онцгой дурсамж байлаа. Христийн Мэндэлсний Баяраар агуу хайр, золиослол шингэсэн бэлэг өгдөг учраас бид энэ баярыг тэмдэглэгийг энгийн тэр нэгэн алчуур надад сануулсан юм. ■

## “Найз нарыгаа Ариун сүмийн тухай асуухад өөрөө ч мэдэхгүй байж би юу гэж хариулах вэ?”

**Ө**өрийн чинь ойлгодоггүй ямар нэг зүйлийн тухай ярилцах нь хэцүү л дээ. Бид ариун сүмд өөрөө явж үзэхээс нааш ойлгох аргагүй зүйл зөндөө олон байдаг. Ариун сүмийн ёслолууд нь ариун нандин зан үйл учраас ариун сүмээс гадуур тэдгээрийн талаар ярилцах ёсгүй. Гэвч бид ариун сүмийн зорилго болон адислалуудын тухай ярилцаж болно. Ариун сүмд гишүүд мөнхийн үнэнүүдийн тухай мэдэж, өөрсдөө ариун нандин ёслолуудыг хүлээн авахаас гадна нас барсан өвөг дээдэс болон бусад хүмүүсийн өмнөөс эдгээр ёслолуудыг хийлгэдэг гэдгийг бид найз нөхдөдөө ярьж болно.

Та ариун сүмийн тухай хэчнээн ихийг мэдэх тусам найз нарынхаа асуултуудад төдий чинээ сайн хариулах бэлтгэлтэй болно. Илүү ихийг мэдэхийн тулд эцэг эхтэйгээ эсвэл Сүмийн удирдагчидтай ярилц. Та бас найз нарынхаа хамт *Лиакхона* сэтгүүлийн ариун сүмүүдийн тухай тусгай дугаарыг (2010 оны Аравдугаар сарын) уншиж, хариултуудыг [Mormon.org](http://Mormon.org)-т орж үзэж болно.

Та бас ариун сүмийн тухай бодол санаагаа хуваалцаж болно. Хэрэв та баптисм хийлгэхээр ариун сүмд орсон буюу ариун сүмийн газар дээр очиж үзсэн бол тэнд байхад төрсөн амар амгалангийн мэдрэмжийнхээ тухай найз нартаа ярьж болно.

Хэрэв найз нар чинь ариун сүм яагаад хүн бүхэнд нээлттэй байдаггүй юм бэ? гэж асуувал ариун сүмд гүйцэтгэдэг ажил ариун нандин учраас, зөвхөн сүнслэг байдлын хувьд бэлтгэлтэй бөгөөд хүчинтэй эрхийн бичигтэй хүмүүс ариун сүмд ордог гэдгийг хэл. Шинэ ариун сүмүүдийг онцгойлон адислахаас өмнөх нээлтийн үйл ажиллагааны үеэр ариун сүмийг үзэж, түүний тухай тодорхой мэдэх боломжийг олон түмэнд олгодог билээ. Ариун сүмийг онцгойлон адислагдсаны дараа хэн ч гэсэн ариун сүмийн газар дээр очиж үзэж болно. Хэрэв боломжтой бол найзыгаа ариун сүмийн нээлттэй хаалганы үеэр эсвэл ариун сүмийн газар дээр өөртэйгөө хамт очиж үзэхийг урь.

### Ариун сүмд орохоор зохистой бай



Ариун сүм бол миний хувьд аз жаргал, хүч чадал, золиослол, мөнхийн гэр бүлүүдийн бэлэгдэл юм гэдгийг би найз нартаа ярина. Бас хэрхэн зохистой байхыг тайлбарлах болно. Хэрэв тэд намайг ариун сүмийг амьдралынхаа хамгийн эрхэм зорилгуудын нэг болгон амьдардгийг харах юм бол, тэд ариун

сүмийн хүч нөлөөг мэдрэх болно. Ариун сүмийн үзэсгэлэнт байдлыг ямар ч хүн гадна талаас нь харж болох ч, хэрэв би зөв зохистой амьдарвал, ариун сүмийн дотор болдог зүйлс итгэл найдвар, аз жаргалыг авчирдгийг би найз нартаа харуулж чадна.

*Эмма Р., нас 18, Юта, АНУ*

### Улам ихийг мэдэхэд найз нараа урь



Өөрийнхөө мэддэг зүйлээс тохиромжтой гэж үзсэн болгоныг найз нартаа ярь. Ариун сүмийн зан үйлүүд ариун нандин учраас бид тэдгээрийн тухай ярьдаггүй гэдгийг тэдэнд хэл. Хэрэв өөрийн чинь мэдэхгүй ямар нэг зүйлийг тэд асуувал мэдэхгүй гэдгээ шударгаар хэл. Хэрэв тэд илүү ихийг мэдэхийг хүсвэл тэднийг сүмд урьж, Бурхан зарлигуудыг нь сахьдаг хүмүүсийг илүү их сүнслэг мэдлэгээр адисалдгийг тэдэнд хэл. Бид сүнслийн зүйлсийг дүрэм дүрмээр, шат шатаар мэдэж болно гэдэгт итгэдэг.

*Кармела Б., нас 18, Филиппин*

### Сүнс хариултыг чинь өгөхийн төлөө залбир



Би найз нарынхаа асуултанд хариулахдаа юу гэж хэлэхээ мэдэхийн тулд эхлээд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг. Юу ярихыг чинь Сүнс өдөөн сануулахыг тэвчээртэй хүлээхэд цаг хугацаа шаардлагатай ч гэсэн ийнхүү хүлээх нь чухал юм. Хоёрдугаарт, илүү их сүнслийн мэдлэгтэй болохын тулд сүмд явж, ариун сүмийн баптисмын санг үз. Нэг найзыгаа ариун сүмийн тухай асуулт асуухад нь би, амьд сэрүүн байхдаа сайн мэдээний тухай сонсох боломж олдолгүйгээр нас барсан



бидний өвөг дээдсийн төлөө тэнд баптисм хийдэг юм. Тэнгэрт уг ёслолыг хүлээн зөвшөөрөх үү, няцаах уу гэдэг нь тэдний сонголт юм гэж хариулсан.

*Лидия П., нас 13, Флорида, АНУ*

### Найз нарыгаа номлогчидтой уулзуулахаар урь.

Найз нар маань надаас ариун сүмийн тухай асуухад энэ бол Их Эзэний өргөө, бид тэнд онцгой ёслолуудыг хүлээн авч, Тэнгэрлэг Эцэгтэйгээ улам ойртон, Түүнд эргэж очих боломж бидэнд нээгддэг газар юм гэж би ярьдаг. Би бас найз нараасаа илүү их зүйлийг мэдэхийн тулд номлогчидтой уулзах уу гэж асуудаг. Хэрэв тэд номлогчидтой уулзахгүй гэвэл би тэдний асуултыг тэмдэглэж аваад, өөрөө номлогчдоос асуудаг. Тэгээд би мэдсэн зүйлээ найз нартаа мэдэгддэг. Би ийм замаар ариун сүмийн талаар илүү их зүйлийг мэддэг болсон.

*Кимми Х., нас 13, Монтана, АНУ*

### Ариун сүмүүдийн зургийг үзүүл



Би дэлхий даяарх ариун сүмүүдийг харуулсан номуудыг унших дуртай. Нэг найзыгаа ариун сүмүүдийн тухай

асуухад нь, миний тайлбар түүнд хангалттай зүйлийг ойлгуулж чадаагүйг би мэдсэн. Тиймээс би ариун сүмүүдийн тухай номнуудаа авчирч, ариун сүм гэж юу болохыг түүнд үзүүлэн, ариун сүмийн зорилго бид тийшээ орохдоо хэчнээн их баяртай байдгийг тайлбарласан. Би түүнийг ням гарагт сүмд урихаар шийдэв. Илүү ихийг мэдэхэд нь түүнд номлогчид болон Ням гарагийн хичээлийн багш нар тусалж чадна.

*Жессика А., нас 18, Индонези*

### Эцэг эхтэйгээ ярилц



Хариултыг эрж хай. Судруудыг уншиж, Ням гарагийн хичээлийн багш нараас асуу. Хариулах боломжгүй асуулт гэж

байдаггүй. Хариулахын тулд шаргуу эрж хай. Хариултынхаа талаар залбир! Ариун сүмийн талаар асуух юм гарахад би аав, ээж хоёроосоо асуудаг. Миний асуултанд хариулах нь аав, ээж хоёрт хэцүү биш. Тэд надад туслахад үргэлж бэлэн байдаг.

*Брайсон Б., нас 18, Юта, АНУ*

### Ариун сүм рүү Яв

Хэрэв бид боломжийнхоо хэрээр ариун сүм рүү аль болох олон удаа явахыг хичээвэл, Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү сайн харилцах боломжтой байх болно. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл бид найз нарынхаа асуултын талаар Түүнд хандан залбирч болно гэсэн үг. Хэрэв бид ариун сүмийн талаар төдийлөн ихийг мэдэхгүй байвал,

энэ талаар илүү ихийг судалж мэдэх хэрэгтэй гэсэн үг. Ариун сүмд явахынхаа өмнө ариун сүм дээр байх үеэрээ юуны тухай бодох ёстой талаараа залбирч, судал. Тэгвэл бид “Ариун сүм дээр байх үед чамд ямар мэдрэмж төрөв?” гэх мэт асуултанд бид хариулж чадна.

*Сара Т., нас 14, Айдахо, АНУ*



### ИХ ЭЗЭНИЙ АРИУН СҮМ

Ариун сүм бол үзэсгэлэн төгөлдөр газар, илчлэлтийн болон амар амгалангийн газар мөн. Энэ бол Их Эзэний өргөө. Энэ өргөө Их Эзэнд ариун билээ. Энэ өргөө бас бидэнд ариун байх ёстой.”

**Ерөнхийлөгч Ховард В.Хантер (1907–95), “The Great Symbol of Our Membership,” *Tambuli*, 1994 оны 11-р сар, 6.**

## ДАРААГИЙН АСУУЛТ

“Би уруу таталтыг яаж эсэргүүцэх вэ?”

Хариултаа 2012 оны 7-р сарын 15-ны дотор [liahona.lds.org](http://liahona.lds.org)-дахь дараах хаягаар э-мэйлээр [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү:

*Liahona*, Questions & Answers 1/10  
50 E. North Temple St., Rm. 2420  
Salt Lake City, UT 84150-3220, USA хаягаар шуудангаар явуулж болно.

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) бүтэн нэр, (2) төрсөн он сар өдөр, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн өөрийн чинь бичгээр гаргасан зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

# ХРИСТЭД ХЭРХЭН БЭЛЭГ ӨГӨХ ВЭ?



**Ерөнхийлөгч  
Хенри Б.Айринг**  
Тэргүүн Зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх

## ЗАЛУУЧУУД ҮҮНИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛДЭГ ВЭ?

“Би нэг найзаа сүмд, Мючелийн үйл ажиллагаанд, тэр ч байтугай хоолонд урьдаг. Бусдад бага зэрэг анхаарал тавих нь тэд бусад хүмүүс өөрийг нь хайрладаг юм байна гэж мэдрэхэд их нөлөө үзүүлж болно.”  
Арманд Ф.

“Би тойргийнхоо номлогчдоод захидал бичихийг хичээдэг.”  
Женни Р.

“Зарим үед бол тусламж хэрэгтэй хүмүүст найз байх нь л чухал юм.”  
Раян Б.

**Х**ристийн Мэндэлсний Баярын сүнс бол бусад хүмүүст **баяр баяслыг бэлэглэх** бидний зүрх сэтгэлийн чин хүсэл юм. Христийн Мэндэлсний Баярыг тэмдэглэх нь **Их Эзэнийг болон бидэнд өгсөн Түүний бэлгүүдийг үргэлж санахаар өгсөн амлалтаа биелүүлэхэд** бидэнд тусалдаг. Ийнхүү санах нь **Түүнд бэлэг өгөх** хүслийг бидэнд төрүүлдэг.

Христэд баяр баяслыг авчрахын тулд бид Түүнд юу өгч чадахыг Тэрбээр бидэнд хэлсэн билээ. Нэгдүгээрт, бид Түүнд итгэх итгэлийнхээ үр жимс болох **харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг өгч чадна**. Бид наманчилж, Түүнтэй ариун гэрээнүүд хийж чадна.

Хоёрдугаарт, **Тэрбээр бусдын төлөө хийхийг биднээс хүсэн хүлээдэг зүйлийг хийснээр бид Түүнд бэлэг барьж чадна**. Ийнхүү бэлэг барих үй олон боломжийн урт жагсаалт Матайн номонд байдаг. Бид энэ амьдралын дараа Түүнтэй учран золгох үедээ сонсох буюу хэлэх болно хэмээн найддаг Гэтэлгэгчийн үгсийг бид энэ номоос уншдаг:

“Зөвт хүмүүс Түүнд “Эзэн, бид хэзээ Таныг **өлсөж байхыг хараад хооллож, цангаж байхыг тань хараад уух юм өгсөн юм бэ?**”

“Хэзээ бид Таныг харь газрынх байхыг тань хараад урьж оруулан, нүцгэн байхыг тань хараад **хувцасласан юм бэ?**”

“Хэзээ бид Таныг өвчтэй байхыг тань хараад эргэж, шоронд байхыг тань хараад **очсон юм бэ?**”

“Тэгэхэд Хаан тэдэнд “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” гэж хэлнэ (Матай 25:37–40). ”

Бид бусдад анхаарал халамж тавьснаар Түүнд ямар бэлгүүд барьж болохыг Их Эзэн эдгээр үгсэд тодорхой өгүүлжээ. Хэн нэгэнд үзүүлсэн **нинжин сэтгэлийн үйлдэл бүр нь Түүнд үзүүлсэнтэй адил юм**. Учир нь Их Эзэн Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдэд хайртай. Энэ нь Түүнд болон Эцэгт аль алинд нь баяр баяслыг авчирдаг. Бид Тэдэнд хэмжээлшгүй ихээр талархах өртэй билээ.

Та нараас олонд нь Христийн Мэндэлсний Баярын үеэр өлсгөлөн хүмүүст хоол унд өгөх боломж бий. Ингэснээрээ та нар Их Эзэнийг баярлуулах болно. **Бүр үүнээс илүү их үнэ цэнэтэй, урт удаан хугацаанд ач холбогдлоо үл алдах бэлэг өгөх арга зам бий хэмээн Тэрбээр бидэнд заасан юм**. “Би бол амийн талх байна: Над уруу ирдэг хүн өлсөхгүй. Надад итгэдэг хүн хэзээ ч цангахгүй” (Иохан 6:35) гэж Тэрбээр хэлсэн билээ. **Бид хайртай хүмүүсээ анхаарч халамжлан, бүхий л нинжин сэтгэлээр Түүнд үйлчлэх нь бидний санал болгож чадах хамгийн агуу үйлчлэл бөгөөд мөнх амьдралд хүрэх цорын ганц эх сурвалж юм.** ■

2010 оны Тэргүүн Зөвлөлийн Христийн Мэндэлсний Баярын Онцгой цугларалт дээр хэлсэн “Аврагчийн бэлэг” нэртэй үгнээс.

## Туршлагаа хуваалцана уу

Эдгээр зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж байгаа өөрийн туршлагыг хуваалцаж, бусад залуучуудын туршлагыг [lds.org/go/gift12](https://lds.org/go/gift12)-оос уншина уу.





# ИРЦГЭЭ, ТҮҮНИЙГ ШҮТЭН БИШИРЦГЭЭ

“Бид бүхнийг өөртөө болон гэрэлд ирэхээр урьсан дэлхийн гэрэл гэгээ  
болох Есүс Христийн төрөлтөд бид баясна”

Далын ахлагч Патрик Киоро, “Ирцгээ, Түүнийг Шүтэн Биширцгээ,”  
Лиахона 2011 оны 12 сар, 42.



# Болзооны талаар

## ЮУ МЭДВЭЛ ЗОХИХ ВЭ?



**Лари М.Гибсон**

Залуу Эрэгтэйчүүдийн Ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

*Бусад хүмүүстэй хамт цагийг өнгөрүүлэх нь жинхэнэ нөхөрсөг харилцааг төлөвшүүлэхэд чухал юм.*

**Д**элхий даяарх Сүмийн залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдтэй ярилцах онцгой боломж тохиосон үед, тэднээс үлэмж олон нь эсрэг хүйсийн залуустай илүү сайн харилцаа тогтоож, хөгжүүлэх сонирхолтой байдгийг би олон удаа сонссон билээ. Ийм харилцааг чухам яаж бий болгох вэ? гэдэг нь та нарын сэтгэл санааг эзэмддэг асуудал.

Өнөө үед бид урьд өмнө нь хэзээ ч байгаагүй амархнаар олон нийтийн мэдээллийн бүх хэрэгслүүдтэй холбогдох боломжтой болжээ. Гэвч технологийн хөгжил нь бас утга учир муутай, үр ашиггүй харилцааг бий болгоход биднийг түлхэж болно. Нүүр нүүрээ харж ярилцалгүйгээр зөвхөн вэб сайт, мессеж, э-мэйлээр харилцаж, хэн нэгэнтэй “найзлах” нь жинхэнэ нөхөрсөг харилцааг бий болгож чадахгүй. Бусад хүмүүстэй нүүр тулан чин сэтгэлээсээ ярилцах нь жинхэнэ нөхөрлөлийг бий болгон хөгжүүлэхэд зайлшгүй чухал юм.

Хайрт залуу найз нар минь ээ, залуу эрэгтэй, эмэгтэйчүүд нийгмийн амьдралд хамтран оролцдог байсан хуучин уламжлалаа сэргээх цаг болжээ. Энэхүү туршлагыг болзоо хэмээн нэрлэдэг байсныг та нар сонссон биз ээ.

### Олон удаа асуудаг асуултуудын хариулт

Та нараас олонд нь болзооны талаар асуултууд байгаа. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд энэ талаар зөвлөгөө өгсөн байдаг. Надаас олонтоо асуудаг зарим асуултуудыг энэхүү гайхалтай сайхан номноос авсан хариулттай нь хамт доор өгөв.

**Би өөрийгөө болзооны талаар сайн зөвлөгөө өгч чадна гэдэгт итгэхгүй байна. Яагаад тэр билээ? Үүнд ямар шалтгаан байж болох билээ?**

Болзоо олон янзын шалтгаантай байдаг. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд болзоо нь “залуу эрэгтэй, залуу эмэгтэй хоёрт бие биеэ илүү сайн таньж мэдэх боломж олгодог. Болзохыг хүлээн зөвшөөрдөг соёл иргэншилд болзоо нь харилцааны соёл суралцан мөн түүнийгээ хэрэгжүүлж, нөхөрлөлийг хөгжүүлж, цагийг зөв сайхан өнгөрөөж мөн яваандаа мөнхийн хамтрагчаа олоход тусалж чадна” хэмээн тайлбарлажээ.<sup>1</sup>

**Залуучууд 16 нас хүрэхээс өмнө буюу хэтэрхий бага насандаа болзоонд явах ёсгүй гэдгийг та нар сонссон байгаа. Яагаад?**

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд дараах зөвлөгөөнүүдийг өгсөн байдаг: “Та нар хамгийн багаар бодоход 16 нас хүрэхээсээ өмнө болзох ёсгүй. Болзож эхлэхдээ өөр нэг хостой эсвэл илүү олон хостой хамт явж бай. Нэг хүнтэй ойр ойрхон болзож уулзахаас зайлсхий. Дэндүү бага залуугаасаа хэн нэгэнтэй харилцаагаа гүнзгийрүүлэх нь та нартай учрах байсан хүмүүсийн тоог хязгаарлаж, ёс суртахуунгүй явдалд хөтөлж болох юм.”<sup>2</sup>

**Нэг залуу надтай болзохыг хүсдэг. Гэвч тэр миний жишгүүдийг сахьдаг гэдэгт би үнэхээр итгэхгүй байна. Би яах ёстой вэ?**

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд заасан нь: “Зөвхөн ёс суртахууны өндөр жишигтэй бөгөөд тэдэнтэй хамт байх үед чи бас өөрийнхөө жишгүүдийг сахих ёстой хүмүүстэй л болзож бай. . . . Та нар болзоонд урих эсвэл болзохыг





## ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимол дахь эдгээр удирдамжуудын зөвлөгөөг хэрэгжүүлсэн ямар нэг туршлага танд байдаг уу?

- Үйлчлэл
- Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал
- Аравны нэг ба бусад өргөл
- Ажил хөдөлмөр ба бие даах чадвар

Та туршлагаа сэдвийн шугаман дээр "For the Strength of Youth" гэж бичин [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар э-мэйлээр ирүүлнэ үү. Өөрийн бүрэн нэр, төрсөн огноо, тойрог ба гадасны нэр, хариулыг чинь хэвлэх эцэг эхийн зөвшөөрлийн хамт (э-мэйлээр) ирүүлнэ үү.

### ЭШЛЭЛ

1. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 4.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 4.
3. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 4–5.
4. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 4.
5. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 4.
6. Томас С. Монсон, "Standards of Strength," *New Era*, 2008 оны 10-р сар, 5.
7. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* 5.

зөвшөөрөх юм уу татгалзахдаа үргэлж эелдэг, хүндэтгэлтэй бай.<sup>3</sup>

**Заримдаа кино үзэхээс өөр зүйлээр болзох ямар ч санаа надад төрдөггүй. Би яах ёстой вэ?**

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд дараах ашиг тустай зарчмууд байдаг: "Аюулгүй, сайн үр нөлөөтэй, зардал багатай, болзож байгаа залуус бие биеэ сайн таньж мэдэхэд туслах болзооны үйл ажиллагаануудыг төлөвлө. Жишгүүдээ хадгалж, Ариун Сүнстэй ойр байж болох газруудад л зөвхөн очиж бай."⁴

Аюулгүй, сайн үр нөлөөтэй, зардал багатай, Ариун Сүнстэй ойр байх гэсэн болзооны дөрвөн энгийн шалгуур нь олон агуу болзоонд чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Эхнэр бид хоёр залуу үеийнхээ болздог байсан туршлагыг эргэж харахад бидний болзоо зардал багатай эсвэл бүр зардалгүй, хамгийн багаар бодоход өөр нэг хостой хамт болзоонд явдаг байсан бөгөөд бид үр ашигтай, чин сэтгэлийн яриа хөөрөө өрнүүлж, бие биеэ улам илүү танин мэддэг байлаа.

**Бие биенийхээ ариун журмыг хамгаал**

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлоос өөр нэг чухал эшлэл татсаны дараа сүүлчийн зөвлөгөөгөө өгч үгээ өндөрлө. Нэгдүгээрт, "Болзож байгаа залуу эмэгтэй, залуу эрэгтэй бие биенийхээ нэр төр, ариун журмыг хамгаалах үүрэгтэй гэдгийг

санаарай."<sup>5</sup> Болзоонд явахдаа хожим нь үүнээсээ ичиж, нүүр улайх юуг ч бүү хий. Ерөнхийлөгч Томас С.Монсон, "Болзоонд явахдаа болзсон хүнээ хүндлэхийн хамт болзсон хүн чинь бас өөрийг чинь хүндэлдэг байхад анхаар" хэмээн зөвлөжээ.<sup>6</sup>

**Болзоо, үерхэх хоёр ямар ялгаатай вэ?**

Эцэст нь, зарим хүмүүс *болзоог* "үерхэх" гэж ойлгодог ч, Сүм дэх болзоо нь, залуус зөвхөн нэг л хүнтэй л "тогтмол" болзохоос биш, өөр хүмүүстэй болзоонд явах ёсгүй гэсэн ойлголт байдаггүй. Сүмийн жишгүүдээр болзоог олон хүнтэй жинхэнэ хүн ёсны нөхөрсөг харилцааг үндэслэн хөгжүүлэх боломж гэж үздэг.

Залуу эрчүүд та нарыг номлолынхоо дараа эрийн цээнд хүрсэн үед тань Их Эзэн та нарт хандан, "Эзэн дотор эр хүнгүйгээр эмэгтэй хүн гэж үгүй бөгөөд эмэгтэй хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм" (1 Коринт 11:11) хэмээн захьдаг билээ. "Болзоо ба гэрлэлтийг энэ тэргүүнд эрхэмлэх зүйл болго" хэмээн *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд онцгойлон тэмдэглэсэн зүйлийг өнөө үед үерхэх гэж ойлгодог болжээ. Ариун сүмд орж тантай энэ амьдралд болон мөнхөд лацдан холбуулах мөнхийн хамтрагчаа эрж хай. Ариун сүмд гэрлэж, мөнхийн гэр бүлээ төвхнүүлэх нь Бурханы аз жаргалын төлөвлөгөөнд амин чухал юм.<sup>7</sup> ■




**Хикари Лофтус**

Сүмийн сэтгүүлүүд

# ГЭР БҮЛИЙНХЭЭ

ачаар

*Та гэр бүлийн  
гишүүн байс-  
наараа адис-  
лагддаг бүх арга  
замын талаар  
бодож үзсэн үү?*



Бурхан гэр бүлийг “энэ амьдрал болон үүрд мөнхийн хамгийн чухал нэгж” болгон томилсон ч, хоёр гэр бүл хоорондоо адилхан байдаггүй.<sup>1</sup> Та хаана амьдардаг болон гэр бүл тань ямар вэ гэдэг нь хамаагүй, гэр бүлдээ агуу аз жаргал авчрахын тулд гэр бүлийн гишүүдийн хооронд бат бөх харилцаа, сүнслэг хүч чадлыг хөгжүүлэхэд тань сайн мэдээ туслах болно. Гэр бүл нь тэдэнд яагаад ийм чухал болох талаар дэлхийн өөр хэсгийн эдгээр өсвөр насны хүүхдүүдийн ярьсан зүйлийг уншигтун.

## Гэр бүл мөнх оршиж чадна

АНУ-ын Хойд Каролины Эрин болон түүний гэр бүл (зүүн талд) мөнхийн гэр бүл болох нэг л зорилгыг байнга санаж явдаг ажээ. Гэвч Эриний аав Сүмийн гишүүн биш гэнэ.

“Ээж, дүү нар маань сайн мэдээний адислалуудыг аав хуваалцаасай гэж хүсдэг нь мэдээж хэрэг. Есүс Христийн сайн мэдээ биднийг аз жаргалтай болгосон юм. Иймээс бид аав маань энэхүү аз жаргалыг хуваалцаасай гэж хүсдэг. Бид бүгд бас гэр бүлээрээ ариун сүмд лацдан холбуулахыг маш их хүсдэг байлаа” гэж Эрин ярилаа.

Мөнхийн гэр бүл болохоор эргэлтгүй шийдсэн Эрин, ээж, дүү нарынхаа хамт зарлигуудыг сахьж, бат бөх итгэлийг хөгжүүлэхийн төлөө чадах бүхнээ хийж, сайн мэдээ аавынх нь зүрх сэтгэлд нөлөөлөхийн төлөө тэд бүгд хамтдаа залбирдаг болжээ.

Эриний аав эцэстээ баптисм хүртэж, гишүүнээр батлагдах хүртэл хэдэн жил өнгөрсөн ажээ. Аав нь баптисм хүртсэнээсээ хойш арав хоногийн дараа Эриний эрэгтэй, эмэгтэй хоёр дүүд баптисм





хүртээсэн гэнэ. Тэднийхэн ариун сүмд лацдан холбуулах зорилгодоо удалгүй хүрчээ.

### Гэр бүл хүч чадал, дэмжлэгийг авчирдаг

Африкийн Камеруны Элизабет, түүний ах Ино хоёр аавыгаа нас барснаас хойш ээждээ найдахаас аргагүй болсон ажээ. “Аавыг нас барсны дараа ээж минь л бидэнд тусалдаг болсон. Бурхан биднийг адисалж, бидний хийдэг бүх зүйлд биднийг хамгаалсан юм” гэж Элизабет ярилаа.

Аавыгаа нас барсны дараа Элизабетын гэр бүл улам ойр дотно болжээ. Тэд 2010 онд Сүмд нэгдсэнийхээ дараа Элизабет, Ино хоёр гэр бүл үүрд мөнх орших боломжийн тухай мэдсэн ажээ.

“Бидний сурсан хамгийн чухал зүйлсийн нэг бол сайн мэдээнээс гэр бүлийн ач холбогдлыг ойлгосон

явдал юм.” гэж Элизабет хэлсэн. “Гэр бүлийнхнийхээ ачаар би өдий зэрэгтэй яваа тул гэр бүл бол миний хувьд маш чухал.”

### Гэр бүлийн өсөлт хөгжилт нь амар амгаланг авчирдаг

Гэр бүлүүд хамтран үйл ажиллагаа зохион байгуулахдаа бие биедээ хэрхэн тусалж болох талаар Швейцарь улсын гишүүн Адина мэдсэн ажээ.<sup>2</sup> Эднийхэн сард нэг удаа зугаалгаар явахаар төлөвлөдөг бөгөөд энэ үеэр бие биенийхээ сонирхдог зүйлсийн талаар илүү ихийг мэддэг ажээ. “Бидний амьдрал, хүсэл тэмүүллийн талаар дүү нартаа гүнзгий ойлголт өгөх боломж бидэнд олдсон юм” хэмээн тэр хэллээ. Нэг удаа аав нь гэрийнхэндээ нохой хэрхэн сургахыг заасан гэнэ (доорх зураг). “Аавынхаа урам зоригийг бас амьдралынхаа чухал хэсэг болон сонирхдог зүйлээ бидэнтэй хуваалцсандаа хэчнээн сайхан байсныг харахад урамтай байлаа” хэмээн Адина дурслаа.

Адина гэр бүлийнхээ үйл ажиллагаануудаар дамжуулан олон ур чадвартай болжээ. Тэрээр амьдралдаа илүү их амар амгаланг мэдэрдэг болсон гэнэ. “Гэр бүл бол өдөр тутмын амьдралын ядаргаанаас амарч, чөлөөтэйгөөр амсхийж, хүч чадлаа сэлбэдэг газар юм. Бас би энэ амьдралд ганцаараа хийж чадахгүй юмаа гэр бүлдээ мэдэж авдаг хэмээн тэр яриу. Өнөөдрийн дэлхий хэтэрхий чимээ шуугиантай хурдан



### АГУУ ИТГЭЛТЭЙ ГЭР БҮЛҮҮД

“Бидний насан туршийн

хамгийн чухал зорилт бол гэр бүлүүд юм. Хэрэв бид энэхүү зорилтыг биелүүлэхийн төлөө өөрийгөө бүрэн дайчилж ажиллах юм бол амьдралынхаа бусад бүх талыг сайжруулж, хувь хүмүүсийн хувьд ч, сүмийн хувьд ч дэлхийн бүх хүмүүст үлгэр жишээ, гэрэлт цамхаг болж чадна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард, “That the Lost May Be Found,” Лиакхона, 2012 оны 5-р сар, 98.

өөрчлөгдөж байгаа ч амар амгалан гэр бүлтэй байгаадаа талархаж байна. Дахин төрж, сэтгэл санааны амралт эдлэх газартай болсондоо би баярлаж явдаг.”

Эдгээр өсвөр насны залуусын нөхцөл байдал, учир үндэслэл өөр өөр ч гэсэн, амар амгалан, хайр энэрэл, дэмжлэг тусалцааг тэд гэр бүлээсээ олж авдгийг мэджээ. ■

### ЭШЛЭЛ

1. Гэр бүлийн удирдамж (товхимол, 2001), 1.
2. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Лиакхона 2010 оны 11-р сар, 129-ийг үзнэ үү.





# БООЖ БОЛДОГГҮЙ БЭЛЭГНҮҮД

## Үйлчлэл

Та нарын өгч болох хамгийн агуу бэлэгнүүдийн нэг нь үйлчлэл юм. Эцэг эх чинь үүнд дуртай байх болно.

- Гэрээ цэвэрлэж бай.
- Хүүхдийг чинь харж өгье гэж бусдад хэл.
- Ширээ засч, хоолны дараа цэвэрлэж бай.
- Гэрийнхэндээ хоол хийж сур.
- Сав суулга, аяга тавгаа угааж, шалаа шүүрдэж бай.
- Дүү нартаа гэрийн даалгавраа хийхэд нь тусалж бай.
- Амьдардаг газарт чинь цас ордог бол замын цасыг арилгаж бай. Танайх хүнсний ногоо тарьдаг бол ногооны газрын зэрлэгийг түү.



## Элиз Александрия Холмз

Бид Христийн Мэндэлсний Баяраар хайртай хүмүүстээ бэлэг өгөхөд их анхаардаг. Гэвч хамгийн агуу зарим бэлгийг боож болдоггүйг сана. Эцэг эхдээ та нарын өгч болох мартагдашгүй зарим бэлгийн тухай дор өгүүлье.







### Гэр бүлээрээ хамт байх цаг

Хэчнээн завгүй байлаа ч, гэр бүлээрээ хамт байх цаг гаргаж бай. Гэрийнхэнтэйгээ хамт байх нь эцэг эхэд чинь туслах бөгөөд тэд чиний хүч чармайлтад баяртай байх болно.

- Гэр бүлийн үдэштээ идэвхтэй оролцож бай (энэ тухай сануулалгүйгээр).
- Дүү нартайгаа тоглож бай.
- Гэр бүлээрээ хооллох цагаас бүү хоцорч бай.
- Гэр бүлийн гишүүдтэйгээ ярилцаж, тэдний үгийг анхааралтай сонсож бай.
- Гэр бүлийн залбирал, гэр бүлээрээ судар уншихад идэвхтэй оролц.
- Зөвхөн найзуудтайгаа биш харин гэрийнхэнтэйгээ цагийг хамт өнгөрүүлдэг бай. Мөн найз нараа гэр бүлийнхээ үйл ажиллагаануудад (эцэг эхээсээ зөвшөөрөл авч) урь.



### Зориг, шийдвэр төгс байдал

Ямар нэг чухал зүйл сэтгэн бодож хийх болбол энэ тухайгаа эцэг эхдээ мэдэгд. Төлөвлөсөн зүйлээ эхэлж, цааш үргэлжлүүлэх нь шийдвэр төгс байдлаа харуулах хамгийн сайн арга зам мөн.

- Залуу эрэгтэйчүүд номлолд үйлчлэхээр бэлтгэ. Боломжтой бол номлолын сангаа одооноос бүрдүүлж эхэл.
- Судруудыг өдөр бүр судал.
- Цалин, орлогынхоо зарим хэсгийг хадгал.
- Хичээлдээ гомдоллохгүй явж, гэрийн даалгавраа цагт нь хийж бай.
- Семинарт яв. Хэрэв чи өглөөний семинарт явдаг бол, өөрөө босч хэвш.
- Ариун сүмд гэрлэхээр бэлтгэ. Ирээдүйн эхнэр буюу нөхөртөө байвал зохих зан төлөвийн шинж чанаруудын жагсаалт гаргаж, эдгээр чанаруудыг өөртөө хөгжүүл.



### Зан төлөв

Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүдтэйгээ харьцах зан төлөвийн сайн чанаруудад чинь тэд талархалтай байх болно.

- Аливаад нааштай хандаж бай.
- Эцэг эх, дүү нараасаа алдаа дутагдал олохыг бүү хичээ.
- Бүр өчүүхэн жижиг зүйлд ч гэсэн талархал илэрхийлж сур.
- Өөрийн чинь төлөө тэдний хийсэн бүх зүйлд эцэг эхдээ талархлын захидал бичиж бай.
- Эцэг эх, ах эгч, дүү нартайгаа санал зөрвөл маргах буюу уурлалгүйгээр асуудлыг шийдэж бай.
- Адислалуудаа нэг бүрчлэн тоол. Эцэг эхийнхээ тусалцаатайгаар хийсэн зүйлсийнхээ жагсаалтыг гаргаж, уг жагсаалтыг тэдэнтэй хуваалц. ■

# 1 Коринт 15:20-22

*Төлөөлөгч Паул эдгээр шүлгүүдэд Христ Амилсан нь бүх хүмүүс үхлээс босон дахин амьдрах боломжтойг тунхагласан юм.*

орхих, эдүгээ хараахан төрөөгүй ч нэгэн өдөр төрж, дараа нь нас барах бүх хүн дээрх мэдэгдлээр аврагдах болно.

Үхлийг ялсан Христийн ялалтын ачаар бид бүхэн амилуулагдах болно. Энэ бол бодгалийн гэтэлгэл мөн.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Тэр энд байхгүй, харин Тэр амилсан,” *Лиакхона*, 2011 оны 4-р сар, 4.



**Христ дотор бүгд амьдруулагдах болно**

“Бүх нийтийн, шууд амилуулалтад итгэх бидний итгэлийг агуу ач холбогдлыг бид

бүрэн дүүрэн ойлгодог эсэхэд би эргэлздэг. Үхэшгүй байдалд итгэх нь бидний итгэлийн үндэс суурь юм. . . .

“Бидний мөнхийн аялалд амилуулалт нь мөнх байдлын төгсгөл, үхэшгүй байдлын эхлэл хоёрыг холбосон чухал холбоос юм. . . . Бас амилуулалтаар бидний сүнс, бие хоёр дахин нэгдэхгүйгээр бид ‘баяр хөөрийн бүрэн байдлыг’ (С ба Г 93:33–34) хүлээн авч чадахгүйг бас орчин үеийн илчлэлтээс мэддэг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “*Resurrection*,” *Лиакхона*, 2000 оны 7-р сар, 17–18.

<sup>20</sup> Харин чухамдаа Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдоос анхны үр жимс мөн. <sup>21</sup> Учир нь үхэл нь нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилалт нь мөн нэг хүнээр иржээ. <sup>22</sup> Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно.

**Нойрсогсдоос анхны үр жимс**

*Анхны үр жимс* бол жимс, хүнсний ногоо, үр тариа хураахад хамгийн түрүүнд боловсорсон ургацын дээж юм.

Мосегийн хуулиар анхны үр жимсийг Их Эзэнд талархал өргөж, бие сэтгэл бүхнээ Түүнд зориулдаг харуулахын тулд ариун өргөл болгон барьдаг байжээ. Анхны үр жимс бол ургац хураахад бэлэн болсны тэмдэг бас арвин ургац хураах болсны дохио учраас Есүс Христ бол үхэгсдээс (“нойрсогсдоос”) амилсан анхны хүн бөгөөд иймээс бүр олон хүмүүс амилуулагдах болно хэмээн Төлөөлөгч Паул хэлжээ.

**Чухамдаа Христ үхэгсдээс амилуулагдсан юм**

“Магдалын Мариа, нөгөө Мариа хоёр Их Эзэнийхээ цогцсыг янзлахаар уйлан хайлж, булш

руу хүрч ирэхэд: “Та нар юунд үхэгсдийн дунд амьд Нэгнийг хайна вэ? Тэр энд байхгүй, харин Тэр амилсан” (Лук 24:5–6) хэмээн тэнгэр элчийн хэлсэн үгсээс илүү чухал үгс миний хувьд Христийн ертөнцөд үгүй билээ.

“Энэ дэлхий дээр нэгэн цагт амьдарч байгаад нас барсан, одоо амьдарч байгаа ч нэгэн өдөр хорвоог



**Адам дотор бүгд үхдэгчлэн**

Адам Ева хоёрын уналтын улмаас бүх хүн төрөлхтөн биеийн үхлийг үзэх болно (2 Нифай 9:6; Мосе 6:48-ыг үзнэ үү).

*Редакторын тэмдэглэл: Энэ хуудас бол сонгосон судрын шүлгийн бүх талыг хамарсан тайлбар биш, зөвхөн өөрийн тань судалгааны эхлэх цэг юм.*





# ӨЛССӨН ХҮМҮҮСИЙГ ХООЛЛОСОН НЬ

*Бид өчүүхэн жижиг арга хэрэгслүүдээр дамжуулан бие махбодын болон сүнсний чухал хэрэгцээгээ хангаж чадна.*

Даллин К.Вилкокс

**2004** оны 12-р сард би Бразилын Сан Паулогийн Линсэд бүрэн цагийн номлогчоор үйлчилж байлаа. Орон нутгийн нэг тойрог, нэг салбар Бразилд жил бүр болдог “Натаал сем Фоме” (Бүхнээр дүүрэн Христийн Мэндэлсний Баяр) хөтөлбөрт оролцохоор шийдсэн байлаа. Бид нэлээд хэдэн бусад байгууллага, түүний дотор Бразилын армийн цэргүүд, шуудан хүргэгчид, бусад сүмүүдийн гишүүдтэй хамтран баг бүрдүүлж, тусламж хэрэгтэй хотын хүмүүст өгөхийн тулд хоол хүнс цуглуулахаар орчныхоо нэлээд хэдэн газраар явлаа. Бид бас үүнийг сүмийнхээ танилцуулах хуудас буюу бидний нэрлэдгээр “нөхөрлөлийн картаа” хүмүүст тараах сайхан боломж болгон ашигласан билээ. 2000 орчим картыг тараасан байлаа.

Олон гишүүд Бразилын халуун наран дор Христийн Мэндэлсний Баярын сүнсийг мэдэрч, энэхүү сүнсийг хуваалцахад төрсөн агуу мэдрэмжийнхээ тухай ярьж байлаа. Цэргүүд өөрсдөө харьяалагддаггүй сүмийн танилцуулах картыг хүмүүст гардуулж байсныг харахад их сонин байлаа.

*Joy to the World* нэртэй Мормоны Табернеклын Найрал дууны тухай Христийн Мэндэлсний Баярын DVD-г үзэх 127 хүсэлтийг бид долоо хоногийн дараа хүлээн авч билээ. Дараагийг долоо хоногт дахиад 22 хүсэлт ирэв. Энэ төслийн үр дүнд хамтрагч бид хоёр эдгээр хүмүүст заадаг боллоо. Бас олон айл өрхүүд бидэнд үүд хаалгаа нээж өгсөн юм.

Бид сайн мэдээг дэлгэрүүлэх болон өлсгөлөн олон айл өрхөд тусалж чадсан тэрхүү онцгой үйлчлэлээс ирсэн баяр баясал хийгээд хайрыг би хэзээ ч мартахгүй. Сүнсний болон бие махбодын өлсгөлөнг аль алиныг нь хөнгөвчилсөн юм.

Өчүүхэн бөгөөд энгийн зүйлсээр (танилцуулах карт гэхчлэнгийн зүйлсээр) дамжин олон агуу, гайхамшигтай зүйлс (хүмүүсийг аврах гэхчлэн) тохиодгийг би мэднэ. Христийн Мэндэлсний Баярын болон бусад үед энэхүү гайхамшигт ажил болон гайхамшигийг тохиолгон авчрах олон боломж бидэнд байдгийг энэ туршлага нотолсон юм. ■

*Joy to the World DVD болон уг DVD-ний танилцуулах хуудас [store.lds.org-m](http://store.lds.org-m) байгаа.*

1.8 м  
(6')

1.4 м  
(4'8")

# ДИКОНУУД ХАМТДАА ӨСЧ ХӨГЖИХҮЙ

Энэ хоёр залуу эрэгтэй их ялгаатай харагдаж байгаа ч, тэдэнд адил нийтлэг зүйл олон бий.

**Т**айлер В. 1.8 метр өндөр, улаан үстэй, 13-мерын гутал өмсдөг. Геррит В. 1.4 метр өндөр, хүрэн бор үстэй 2 ½-мерын гутал өмсдөг. Гэвч тэд бие бялдрын хувьд ялгаатай ч, тэдний гэрийнхэн тэр хоёрыг “ихрүүд” хэмээн нэрлэдэг. Учир нь тэр хоёр үй зайгүй найзууд бөгөөд тэдэнд адил нийтлэг зүйл олон байдаг гэнэ.

Геррит, Тайлер хоёр хоёул 12 настай, хоёул диконы чуулгад явдаг. Тэд бас хоёул спорт тоглоомуудаар тоглодог, чөлөөт цагаа гэрийнхэнтэйгээ хамт өнгөрүүлж, шинэ зүйлс сурдаг. Тэд бас хоёул сайн мэдээний тухай гэрчлэлтэй бөгөөд Аароны санваартаа хүндэтгэлтэй ханддаг. “Бид суралцахын тулд санваартны үүргүүдээ биелүүлдэг байх хэрэгтэй” гэж Геррит хэлжээ.

Энэ хоёр дикон хоёул ариун ёслолыг түгээж, мацгийн өргөлийг цуглуулж, санваартны үүргээ биелүүлэх дуртай ажээ.

Тэд бас тойргийнхоо бусад диконуудыг Христэд ирэхийг урьснаар тэдэнтэй нөхөрлөхөд тусалдаг гэнэ. “Хэрэв хэн нэг нь цуглаанд ирээгүй бол бидний нэг нь сүм дээр сурч мэдсэн бүх зүйлийнхээ талаар түүнд зурвас бичдэг. Тэгээд бид зурвасыг түүнд өгч, ‘Сүмдээ ирээч гэж хэлдэг’ хэмээн Геррит ярилаа.

Геррит, Тайлер хоёр бас Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэг. Тэр хоёр судруудыг хэрхэн илүү их уншихаа төлөвлөдөг. “Энэ нь итгэлд чинь үнэхээр тустай, гэрчлэлийг чинь бэхжүүлж чадна” гэж Тайлер хэлэв.

Энэ хоёр залуу эрэгтэй яг л та нар шиг эсвээс та нарын таньдаг диконуудтай адилхан юм. Тэднийг ялгаатай болгодог бас адил нийтлэг болгодог зүйлс бий. Гэвч хамгийн чухал нь тэд Бурханы хүүхэд бөгөөд Түүнд үйлчлэхийг хүсдэг, санваартны чуулгадаа нэгдсэн явдал юм. ■

## ЧУУЛГА ДОТРОО ЭВ НЭГДЛИЙГ ХЭРХЭН БИЙ БОЛГОХ ВЭ?

Та нар Тайлер, Геррит хоёрын адил диконор томилогдсоноороо санваартны чуулгын хэсэг болдог. Чуулгынхаа дотор эв нэгдлийг бий болгоход тань тусалж болох зарим санааг доор өгөв:

- Чуулгын үйл ажиллагаанд хүн бүрийг оролцуул!
- Хамтдаа үйлчил.
- Бие биедээ урам хайрла.
- Бие биенийхээ зөвлөгөөг сонс.
- Удирдагчдынхаа зааврыг дага.
- Сайн мэдээний жишгүүдээр амьдрахад бие биедээ тусал.





**Ахлагч Д.Тодд  
Кристофферсон**

Арванхоёр Төлөөлөгчийн  
Чуулгын

*Арванхоёр Төлөөлөгчийн  
Чуулгын гишүүд Есүс  
Христийн онцгой  
гэрчүүдээр дуудагддаг.*

# Би хэрхэн Есүс Христийн гэрч байж чадах вэ?

Бид Түүний сургаалуудын дагуу амьдарснаараа Есүс Христийн гэрчүүд байдаг. Бидний үйлддэг, ярьдаг, хардаг болон тэр ч байтугай боддог арга зам нь Түүнийг болон түүний замуудыг тусган харуулдаг.

Бид Түүний талаарх үзэл бодлынхоо тухай бусдад ярьснаараа Есүс Христийн гэрчүүд байдаг.

Бид Түүнд итгэх итгэлээ бусдад харуулж, аз жаргалтай амьдарснаараа Есүс Христийн гэрчүүд байдаг.

Бид Түүний тухай гэрчлэлээ бусадтай хуваалцаж, Түүний тухай мэдэж, Түүнийг дагахад нь тэдэнд тусалснаар Есүс Христийн гэрчүүд байдаг.

**Рахел Линн Бауер**

Бодит түүхээс сэдэвлэв

*“Бурханы бүх хүүхдүүд ээ,  
хайрын бэлгийг үүрд бишрэн  
гайхахаар авчир” (“The  
Shepherd’s Carol,” Children’s  
Songbook, 40).*

**Г**эр бүлийн үдшийн  
цаг боллоо!” гэж аав  
дуудав.

Би зочны өрөө рүү яаран  
ухасхийв. Бид арванхоёр-  
дугаар сарын эхний гэр  
бүлийн үдшээр үргэлж сонин  
зүйлсийг хийдэг байлаа.

Миний эмэгтэй дүү Мишель  
надаас түрүүлж өрөөнд гүйж  
ороод зөөлөн цэнхэр буйдан  
дээр харайн гарлаа.

“Шударга биш байна шүү!”  
гэж би дуу алдлаа. “Чи өнгөрсөн  
долоо хоног энд суусан ш дээ.  
Одоо миний ээлж.”

“Би хамгийн түрүүнд ирсэн  
юм чинь энд суухгүй яах юм”  
гэж тэр мөчөөгөө өгсөнгүй. “Чи  
диван дээр сууж болно ш дээ.”

“Диван дээр суухыг хүсэхгүй  
байна” гэж би намжирдав.

Би Мишель рүү харахгүйн тулд  
эргэдэг сандал дээр буруу харж  
суулаа. Тэр заримдаа намайг бүр  
галзуурахад хүргэдэг юм! Мишель  
юу хүснэ түүнд хүрч чадна гэж  
боддог байлаа. Түүний талаар  
ээжид гомдол мэдүүлэхэд ээж  
намайг битгий амин хувиа хи-  
чээж бай гэнэ.

Манайхан дуулал дуулж, зал-  
бирсны дараа аав, “Христийн  
Мэндэлсний Баяр бол сэтгэл догд-  
лом сайхан цаг. Тиймээс бид энэ  
баярын жинхэнэ утга учрыг санах  
хэрэгтэй. Өнөө орой бид Есүст  
бэлгээ өгөх болно” гэлээ.

Есүст өгсөн бидний бэлэг. Би  
энэ тухай таг мартчихсан байлаа!

Христ төрсөн учраас бид Хрис-  
тийн Мэндэлсний Баярыг тэм-  
дэглэдэг юм шүү дээ. Тэнгэрлэг  
Эцэгтэйгээ хамт үүрд мөнх амьд-  
рах хамгийн агуу бэлгийг хүлээн

авах боломжоор Тэр биднийг хан-  
гасан юм” гэж аав цааш нь ярив.

Тэр үүний хариуд юу хий-  
хийг биднээс хүсдэг вэ?” гэж ээж  
асуулаа.

“Түүнийг дагаж, зарлигуудыг нь  
сахихыг” гэж манай ах хариулав.







Миний бэлэг юу байх ёстойг би тэр даруй ухаарлаа. Бусад хүмүүс биднийг гомдоолоо ч гэсэн тэднийг хайрлаж бай гэж Есүс бидэнд заасан шүү дээ. Есүс надаас дүүгээ хайрлахыг хүсдэгийг би мэдэж байлаа. Тиймээс би, “Би Мишель дээ сайн байх болно” гэж бичлээ.

Бид картаа алтлаг цаасанд боосон хайрцганд хийж, Христийн Мэндэлсний Баярын сүлд модны дор тавилаа. Бид хайрцгийг харах болгондоо Аврагчаас бидэнд өгсөн бэлгийг бас Түүнд өгсөн өөрсдийн бэлгийг санадаг байлаа.

Хэд хоногийн дараа Мишель миний хайртай цамцыг надаас асуулгүйгээр авчихсаныг би харав. Дүүгээ уурлан загнамаар байсан ч, Алтан хайрцгийг хараад би Есүст хэчнээн их хайртайгаа саналаа. Би

дүүдээ сайхан сэтгэл гаргаснаараа Түүнд хайртайгаа харуулж чадна. Тиймээс би, “Мишель чи өнөөдөр үнэхээр гоё харагдаж байна шүү” гэж билээ.

Тэр инээмсэглээд, “Цамцыг чинь асуулгүй авсанд намайг уучлаарай. Намайг хувцаслахад чи байгаагүй. Өнөөдөр Христийн Мэндэлсний Баярын үдэшлэг дээр

би ангийхандаа улам гоё харагдахыг хүссэн юм” гэж Мишель хэллээ.

Миний дотор нэг их сайхан болоод явчихлаа. Би Мишельд уурлахын оронд түүнд эелдэг уриалгахан хандсандаа баяртай байв.

Би арванхоёрдугаар сарын үлдсэн хугацаанд үргэлж сайхан зантай байхыг болон Есүстэй улам адилхан байхыг зорилгоо болгохыг хичээж билээ. Тэвчээртэй байж, бусдыг хайрлах талаараа би ахиц дэвшил гаргаж чадсан юм.

Христийн Мэндэлсний Баярын өмнөх үдэш аав Есүсийн төрөлтийн түүхийг уншиж, өгөхөд гэр бүлийн бусад гишүүд энэ түүхийг жүжигчлэн тоглож билээ. Би Мариагийн дүрд тоглох болсон Мишельтэй маргахгүйн тулд тэнгэр элчийн дүрд тоглохоор шийдсэн.

Жүжигчилсэн тоглолтын дараа бид алтан хайрцгийг нээж, Есүст өгсөн бэлгээ чанга уншиж билээ. Намайг өөрийнхөө бэлгийг уншихад ээж, “Чамайг Мишельд өмнөхөөсөө улам сайн болсныг би харсан. Би охиноороо бахархаж байна!” гэж билээ.

Би ч бас нүүр бардам байлаа. Би ямар ч бэлэг задлаагүй ч гэсэн, ямар нэг онцгой зүйлийг хүлээж авсан билээ. Энэ нь намайг зөвийг хийлээ гэж шивнэсэн Ариун Сүнснээс ирсэн мэдрэмж байлаа. ■

Ээж бидэнд бүгдэд нь карт, үзэг өглөө. Бид Есүсийг хайрладгаа Түүнд хэрхэн харуулах тухай бичих хэрэгтэй байлаа. Есүстэй илүү адилхан болохын тулд юу хийхээ сонгох нь Түүнд өгөх бидний бэлэг байлаа.



“Христийн Мэндэлсний энэ удаагийн Баяр нь Христийн Мэндэлсний Баярын олон янзын уламжлалт арга хэмжээнээс илүүгээр бид юуны түрүүнд Их Эзэн Есүс Христ дээр анхаарал төвлөрүүлснээрээ онцлог боллоо гэдэгт би итгэлтэй байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон, “Christ the Savior Is Born,” *New Era*, 2006 оны 12-р сар, 2.

# Бидний хуудас



## БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

**Ч**илийн Сантьяго дахь Ла Флоридагийн Гуравдугаар тойргийн Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд Хүүхдийн Хэсгийн удирдагчид, бишопын зөвлөлийн гишүүдтэй хамт ариун сүмийн газар дээр очиж үзжээ. Тэд үзэсгэлэнт цэцэрлэг очиж, ариун сүмүүдийн зорилгын тухай ярилцаж, "I Love to See the Temple (Би ариун сүм харах дуртай)" дууг дуулсан ажээ (*Children's Songbook*, 95). Тэд бас Есүс Христийн амьдралын тухай видео үзсэн байна.

## БИ БОШИГЛОГЧ ИОСЕФ СМИТИЙН ТУХАЙ ЗААНА



Ариун ойн цоорхой, Аксел К.



**Б**ид Хүүхдийн Хэсэгт "Иосеф Смитийн анхны залбирал" (Сүмийн дуулал болон хүүхдийн дуу, 14) дууг сурсан. Одоо энэ нь миний дуртай дуулал юм. Би номлогч болохоороо Ариун ойн цоорхойн тухай түүхийг заах хүмүүстэйгээ хуваалцах болно. Би Есүс Христ, Бошиглогч Иосеф Смит хоёрт хоёуланд нь хайртай. Сүм үнэнийг би мэднэ!

Аксел К., нас 5, Перу



## ГЭР БҮЛИЙН ҮДЭШ ТҮҮНД ТААЛАГДДАГ

**К**оста Рикагийн 9 настай Хелена К.-д аав нь баптисм хүртээсэн тэр даруйд тэр Сүмийн гишүүн болчихсон юм шиг санагдсан гэнэ. Есүс Христийн тухай гэр бүлийн үдшийн хичээлүүд түүнд их таалагддаг ажээ. Тэр бас сургуульдаа явж, найз нартайгаа тоглох дуртай.



## АРИУН СҮМ РҮҮ ОЧИЖ ҮЗ

**Б**и ариун сүмээс мэндчилгээ явуулдаг.

Би бусад хүүхдүүдийн хамт Эквадорын Либертад Гадаснаас Эквадорын Гуаяквил Ариун сүмийн газар дээр очиж үзсэн тэр нэгэн өдөр үнэхээр гайхалтай сайхан өдөр байлаа. Хэрэв боломжтой бол дэлхийн бүх хүүхдүүдийг бид ариун сүмд очиж үзэхийг урьж байна. Ариун сүм үнэхээр үзэсгэлэнтэй сайхан газар шүү.

Айда В., нас 10, Эквадор



Христийн Мэндэлсэний Баяр бол Христийн төрсөн өдөр, Олчукву О., нас 9, Нигери



Аароны санваар сэргээгдсэн нь, Фелип Л., нас 12, Бразил



## ЕРӨНХИЙЛӨГЧ МОНСОНГИЙН ЧИГИРИ-И

**Я**поны Шизүокагийн Фужи Гадасны Хүүхдийн Хэсгийн хүүхдүүд Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн дүрсийн өнгийн цаасан наамал буюу чигири-и-г зургаан сарын дотор урлажээ. Энэ нь их цаг хугацаа, хүч хөдөлмөр шаарддаг ч хүн бүр Ерөнхийлөгч Монсонгийн тухай бодож, түүний тухай улам их зүйлийг мэдсэний сацуу бүгдээрээ хамтран хөдөлмөрлөсөн ажээ.



ӨӨДРӨГ САЙХАН САНАА

# “Христэд ирэгтүн.”

Моронай 10:32

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ



# Дэлхийн гэрэл



## Кимберли Рейд

Бодит түүхээс сэдэвлэв

*“Учир нь Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22).*

**Э**рин Солт Лейк хот дахь Ариун сүмийн Талбай дээр зогсоод Есүсийн төрөлтийн үйл явдлыг дүрсэлсэн хүний биеийн хэмжээтэй баримал хөшөөг харж, хөгжим болон түүхийн хүүрнэл эхлэхийг хүлээж байлаа. Христийн Мэндэлсний Баярын гэрлэн чимэглэл эргэн тойронд нь анивчина. Гэвч энэ нь Христийн Мэндэлсний Баярын уур амьсгал биш юм шиг санагдах ажээ.

“Сайхан байна уу?” гэж ээж нь асуулаа.

Эрин толгой дохьсон ч, үнэхээр сайхан байгаагүй ажээ.

Хэдхэн хоногийн өмнө Эриний ангийн нэг хөвгүүн машины ослоор нас барсан байлаа. Оршуулах ёслол дээр олон хүн уйлжээ. Эрин ч бас л уйлсан гэнэ. Эрин тэр хөвгүүнийг сайн таньдаггүй байсан ч харин гэр бүл нь түүнийг яг л өөрийг нь гэрийнхэн нь хэчнээн их хайрладаг шиг тийм их хайрладаг байсныг мэдэж байлаа. Иймэрхүү явдал түүний насны хэн нэгэнд тохиолдож болно гэдгийг мэдсэн дээ тэр айх шиг болов.

Тиймээс Христийн Мэндэлсний Баяр түүний сэтгэлийг догдлуулсангүй. Тэр машинд суухаас, эцэг эхээ орхиж хол явахаас, өөрийг нь хол байхад гэр оронд нь ямар нэг юм тохиолдохоос үргэлж айдаг болжээ. Ариун сүмийн Талбай дээрх Христийн Мэндэлсний Баярын үй олон гэрэл түүний

санаа зоволтыг арилгасангүй. Хэдийд ч аюул учирч мэдэх дэлхийд тэр яаж аз жаргалтай байж чадах билээ?

“Эхлэх гэж байна” гэж аав нь хэлээд Есүсийн төрөлтийг дүрсэлсэн хөшөө рүү заав.

Чанга яригч шажигнан дуугарснаа, ярьж эхлэв. Хөгжим эхэлж, хоньчид, Мэргэн хүмүүс, Мариа, Иосеф нар дээр гэрэл туслаа. Эрин танил түүхийг сонслоо. Есүс хүү төрж, түүнийг тэжээлийн тэвшинд тавилаа. Тэнгэр элчүүд дуулав. Хоньчид мөргөл үйлдэж, шүтэн бишрэв. Мэргэн хүмүүс баярлалдан уухайлав.

Эрин аав, ээж хоёрынхоо нүүрийг болон Есүсийн төрөлтийг дүрсэлсэн хөшөөний дэргэд цугласан олныг харлаа. Тэд бүгд баяртай байх шиг санагдав. Түүний төрөлт муу зүйлсийг бий





“Есүс Христ, Тэнгэр дэх Эцэгийнхээ дэргэд эргэж очихын тулд бидний алхах ёстой замыг үлгэр жишээгээрээ болон сургаалуудаараа бидэнд гэрэлтүүлэн харуулдаг учраас. . . дэлхийн гэрэл юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс, “The Light and Life of the World,” *Ensign*, 1987 оны 11-р сар, 64.

болохоос нь зогсоож чадаагүй атал яагаад хүн бүр Есүс хүүгийн талаар ийм баяртай байдаг юм бол? Эрин толгойд нь эргэлдээд салахгүй байгаа энэ асуултанд дургүй нь хүрчээ. Түүний хамгийн их хүсдэг зүйл бол айхаа болих явдал юм.

Есүсийн төрөлтийн түүх дуусч, бошиглогчийн дуу хоолой чанга яригчаас цуурайтав. Тэрээр гэрчлэлээ хэлж, “Учир нь Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22) гэсэн судрыг Библиэс эш татлаа.

Эриний зүрх түг түг цохилж байлаа. Тэрээр судрын дээрх үгсийг санахыг хичээн, дотроо давтан хэлэв. *‘Учир нь Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно.’*

Энэ сударт хөгшин, залуу

хүн бүр үхэх болно гэжээ. Эрин үүнийг мэднэ л дээ, гэвч энэ тухай өмнө нь төдийлөн боддоггүй байв. Ийм юмсын тухай бодох нь түүний хувьд хэтэрхий эрт байна гэж тэр боддог байжээ. Гэвч Есүс Христийн ачаар *хүн бүр* дахин амьдрах болно гэсэн үнэний тухай гэрчлэлтэй болоход тэр хэтэрхий бага байсангүй. Чухам энэхүү үнэний улмаас хоньчид хийгээд Мэргэн Хүмүүс ихэд баярласан хэрэг. Есүс юу хийхээр дэлхийд ирснийг тэд ойлгожээ.

Эрин малын жижигхэн хашаан дотроос Есүсийн төрөлтийн түүхийг дүрсэлсэн хөшөөний цаадах зочдын төвийг цонхоор харж зогслоо. Барилга дотор шархны сорвитой гараа урагш сунгасан Есүсийн том хөшөөн дээр гэрэл туссан байлаа. Тэжээлийн тэвшин дэх өөдсийн

чинээхэн хүүгийн тухай мөн Тэрээр бүх хүч бүхий хүн болж хэрхэн өссөн тухай Эрин бодож зогслоо. Есүс бүр түүний төлөө амиа золиослохоор сонгосон юм. Түүнийг дахин амьдрахын төлөө Тэр төрсөн юм. Юу ч тохиолдлоо гэсэн Эрин Есүсийн хайраар аюулгүй байх болно гэдгийг мэдэрч байлаа.

Амар амгалан түүнийг бүрэн эзэмдэв. Тэрээр яагаад гэдгийг тайлбарлаж чадаагүй ч, санаа зоволт нь алга болсон байлаа. Тэрээр Христийн Мэндэлсний Баярын анивчих олон гэрлээс илүү хурцаар гэрэлтэх Есүс Христийн хөшөөг харан зогсож байхдаа шөнийн харанхуй тэнгэрийг арайхийн олж харжээ. Зүрх сэтгэлдээ ассан найдварын гэрэл цээжинд нь багтаж ядан байхыг тэр мэдэрлээ. ■

Хүүхдийн Хэсгийн энэ сарын урианы тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

# Есүс Христ бол Бурханы Хүү

**Ц**өл дундуур аялж явна хэмээн төсөөлөн бод. Хол газар удаан аян хийхэд тэмээгээр явах нь зүдэргээтэй, ядахдаа газрын зураг ч байхгүй. Газрын зургийн оронд од даган явахаас өөр аргагүй. Ийм аян чамд ямар санагдах вэ? Чи ийм аянд гарах итгэлтэй байж чадах уу?

Хоёр мянган жилийн тэртээ мэргэн хүмүүс яг ийм аянд гарсан юм. Тэд дорно зүгт гийсэн хурц гэрэлтэй одыг хараад Христ хүүд хүндэтгэл үзүүлэхээр үнэт бэлэг сэлт зэхэн, Бетлехемийг зорин холын аянд гарсан юм. Зөвхөн Мэргэн хүмүүс л тэр одыг харсан юм биш. Их далайн чанадад, Америк тивд нифайчууд тэрхүү одыг харж, Бурханы Хүү Есүс Христ мэндэлснийг мэдсэн юм.

Өнөөдөр тэр одны тухай бодох нь Аврагчийн тухай бидэнд сануулдаг. Сайхь од харанхуйд гялалзан, Есүс бидэнд хэрхэн амьдрахыг заадаг шиг, Мэргэн хүмүүст замыг заасан билээ. Тэрхүү од нь, Аврагч биднийг хайрладаг шиг байнга гэрэлтэн харагддаг билээ. Та нар дараагийн удаа оддыг хараад Есүс Христ бол Бурханы Хүү, Дэлхийн Гэрэл гэдгийг санагтун. ■

## ДУУ БА СУДАР

- "The Nativity Song," *Children's Songbook*, 52–53
- Сургаал ба Гэрээ 11:28

## ЗӨВИЙГ СОНГО ҮЙЛ АЖИЛЛАГАА: АВРАГЧИЙН БЭЛЭГДЛҮҮД

Есүс Христ Өөрийгөө олон юмстай зүйрлүүлсэн байдаг. Бид доорх зүйрлэлүүдийг судалснаар Түүний тухай илүү ихийг мэдэх болно. Доорх судруудыг гэр бүлээрээ уншиж, эдгээр бэлэгдлүүд Аврагчийн тухай юу өгүүлж байгааг ярилц.




Хоньчин (Дуулал 23:1-ийг үзнэ үү)



Хурга (Иохан 1:29-ийг үзнэ үү)



Талх (Иохан 6:51-ийг үзнэ үү)



Ус (Иохан 4:14-ийг үзнэ үү)



Хад (2 Нифай 8:1-ийг үзнэ үү)





### ЗӨВХӨН ЧИ

Христийн Мэндэлсний Баярын чимэглэлийг Аврагч амьдралыг тань хэрхэн адисалсныг санагдуулахаар хий. Оддыг хайчилж аван, хатуу цаасан дээр наа. Чимэглэлийн ар тал дээр өөрийнхөө эсвэл гэр бүлийнхээ зургийг нааж, Дэлхийн Гэрэл болох Есүс Христийг дагахын тулд юу хийхийг хүсдэгээ бич. Дээд тал дахь нүхүүдийг хайчилж, утсыг нүхүүдээр гарган уяж, чимэглэлийг гэрэлтүүл.



# Христийн Мэндэлсний Баярын ЗАЛБИРАЛ хариулагдсан нь



Пегги Шонкен

Бодит түүхээс сэдэвлэв

*“Мөн түүнчлэн Их Эзэн тэдний төлөө түүнд өргөгдсөн зөв шударгыг үйлдэгчдийн залбирлуудыг санах болно.” (Мормон 5:21).*


**П**егги Христийн Мэндэлсний Баярын өглөө эрт сэрэв. Тэр охин гоё шинэ тоглоом бэлгэнд авч, Христийн Мэндэлсний Баярын хоол идэхийг сэтгэл догдлон хүлээж байв. Гэвч эргэн тойрноо ажиглавал, энэ жил нэг л өөр байх шиг санагдав. Аав нь шаргуу ажилладаг ч гэр бүлд нь мөнгө байнга дутагддаг байв.

Христийн Мэндэлсний Баяр ойртож байгаагийн шинж тэмдэг ер харагдахгүй байлаа. Хүнсний ногоон тавиурууд хоосон, хөргөгчид хүнсний зүйл юу ч байсангүй.

Пегги эрэгтэй дүү Малкольмынхаа хамт аав, ээж хоёрынхоо унтлагын өрөөний хаалган дээр очтол, аав ээж хоёр нь орныхоо дэргэд өвдөг сөгдөн залбирч байх нь харагдав. Аав, ээж хоёр нь Тэнгэрлэг Эцэгт хандан хоол хүнстэй болоход нь гэр бүлдээ туслахыг гуйн залбирч байхыг чимээгүйхэн сонслоо.

“Нааш ир. Хоёулаа гадаа гаръя” гэж Пегги Малкольмд хэлэв.

Пегги, Малкольм хоёр гадаа гарч, ногооны газрынхаа ойролцоо ургадаг зэрлэг тагнай өвснөөс





хэсгийг түүв. Энэ жил ямар ч тоглоом байхгүй нь бололтой. Гэвч тэд гэр орондоо Христийн Мэндэлсний Баярын уур амьсгалыг бий болгож чадна шүү дээ.

Тэд гэрээ ногоон тагнай өвсөөр чимсэн нь аятайхан харагдаж байсан ч хоол ундтай болох шинж тэмдэг огт харагдахгүй байлаа.

“Их Эзэн хангана даа. Одоо ширээгээ засацгаая” гэж ээж хэлэв.

Аавыг ширээн дээр тавагнууд өрөхөд ээж халбага сэрээнүүд тавилаа.

Хүүхдүүд учрыг олохгүй гайхан бие бие өөдөө харна. Ширээ бэлэн болсон ч, хоол байхгүй л байлаа. Удсан ч үгүй өглөөний хоолны цаг өнгөрч, үдийн хоолны цаг ойртож байлаа. Пегги өлс-сөнөөс ходоод нь нэг хоёр удаа сүрхий өвдөхийг мэдрэв. Гэр бүл нь яаж хоол ундтай болох юм болдоо гэж тэр гайхаж байлаа.

Цаг 12:00, дараа 12:30, тэгээд 12:45 боллоо. Таг чиг хэвээрээ. Тэгтэл Пегги хаалга тогшихыг сонсов.

Тэр хаалга руу хар хурдаараа гүйж очтол Көркийнхөн тэнд зогсож байхыг хараад мэл гайхав. Тэд гахайн мах, талх, тахианы мах, салат, чихэрлэг амттан зэргийг барьсан байв. Пегги нүдэндээ итгэж ядан байлаа.

“Бид та нарын тухай бодсон үед Христийн Мэндэлсний



Баярын зоогоо идэхээр ширээнд дөнгөж суугаад байлаа. Та нар энэ хоолыг ид л дээ” гэж Көрк ах хэлэв.

Аав нь Көрк ахын гарыг барихад ээж нь хоол хүнсийг гарган, гал тогооны өрөөний ширээн дээр өрж эхэллээ. Пегги мэл гайхсан хэвээрээ байв. Тэр аав, ээж хоёр руугаа нүдээ том болгон хартал тэд үүнийг мэдэж, хүлээж байсан юм шиг харагдав.

Тэр өглөө өөрт нь төрсөн мэдрэмж зөв байсныг Пегги ойлголоо. Энэ удаагийн Христийн Мэндэлсний Баяр онцгой сайхан болов. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, хариулдгийг тэр Христийн Мэндэлсний энэ Баяраар мэдсэн ажээ. Энэ бол түүний хүлээн авсан хамгийн сайхан бэлэг байлаа. ■



“Даруухан бөгөөд итгэлийн залбирал удирдамж чиглэл, амар амгаланг авчирдаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “Using the Supernal Gift of Prayer” Лиахона, 2007 оны 5-р сар, 8.



# Хачиртай талх

Хейди Поелман

Бодит түүхээс сэдэвлэв.

1. Виллям машинд харайн орж, Жеремиагийн дэргэд суугаад суудлын бүсээ хийж чангалав.



2. Жеремиагийн ээж замд гарч машинаа жолоодоход Виллям хайрцагтай бэлэн хоолоо задлав. Тэр самрын тос, цэлцгий түрхсэн хачиртай талх гаргаж ирээд, томоо гэгч нь хазаж авлаа.



3. Жеремиа Виллямын хачиртай талхыг ширтэн харлаа. Хачиртай талх хорхой хүрмээр харагдаж байв. Жеремиа өлссөн байлаа.



4. Ээж, би өлсөөд байна ш дээ.  
Идэх юм байна уу, танд?

Уучлаарай, Жеремиа. Бид  
гарахаасаа өмнө юм идсэн шүү дээ.  
Одоо надад юу ч алга.

За тийм бол  
яахав..

5. Жеремиа гунигтай болов. Тэр бас  
хачиртай талх идмээр байв.

6. Жеремиа уйтгартай байгааг Виллям харав.  
Тэр хачиртай талхнаасаа нэг хэсгийг тасалж  
аваад Жеремиад өгөв.

Май, хө!

7. Баярлалаа,  
Виллям аа. Миний  
найз ийм сайн ш дээ.

Зүгээр ээ. Найзуудад  
ийм юм байх ш дээ!



## НАЙЗ БАЙХ НЬ

**Б**усад хүүхдүүдэд найз байх нэг арга зам бол тэдэнд туслах явдал мөн. Виллям, Жереми хоёр тоглоомын талбай дээр бусад хүүхдүүдэд зориулж сайн зүйлс хийхийг хүсдэг. Тоглоомын талбай дээр тусламж хэрэгтэй байгаа хүүхдүүдийг дугуйлж тэмдэглэ.





## БУДАХ ХУУДАС



**Дөрөвдэх долоо хоног:**  
**Иосеф Смит Есүс Христийг харж, Түүний тухай гэрчилсэн.**  
 Мөн эдүгээ, түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө! Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ-

# Сүмийн мэдээ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай [news.lds.org](http://news.lds.org) -аас үзнэ үү.

## Сүмийн гишүүдийг сэтгүүлийн захиалгаар дамжуулан Сайн мэдээг хуваалцахад урьж байна

Хеадар Витл Ригли

Сүмийн мэдээ ба үйл явдлууд

Тайланд дахь Сүмийн Материал хангамжийн менежер Каног-ван Вонгвирафаб Сүмийн тоног төхөөрөмж, ариун сүмийн хувцас болон ХҮГ гарын авлага, товхимлуудын талаар гишүүдээс ирүүлсэн хүсэлтүүдийг хариуцан зохицуулдаг.

Харин нэг өдөр нэгэн эмэгтэй Сүмийн сэтгүүлийн захиалгаа шинэчлэхээр оффист нь орж ирэхэд тэрээр их гайхсан гэнэ. Дэлхийн энэ хэсэгт, гишүүд сэтгүүлийнхээ захиалгыг ихэвчлэн өөрсдийн нэгж дэх сэтгүүлийн төлөөлөгчөөр дамжуулан шинэчилдэг. Гэвч энэ эмэгтэйн тойрогт сэтгүүлийн төлөөлөгч байдаггүй гэжээ. Тэр Буддийн шашинтан байсан бөгөөд сүмийн гишүүн найз нь түүнд сэтгүүлийн захиалгыг бэлэг болгон өгөхөд Сүмийн сэтгүүлийг мэддэг болсноо хэлжээ.

“Тэр найз маань Сүмийн сэтгүүлүүдийн талаар гайхамшигтай олон зүйлийг мөн тэдгээр нь хүүхдүүдэд нь хэчнээн их үнэ цэнэтэй болохыг надад хэлсэн юм” гэж Вонгвирафаб эгч бичжээ. Хүүхдүүд нь сургуулиасаа ирээд сэтгүүлүүдийг үзэж, сэтгэл нь ихээр хөдлөн тэр даруй уншиж дуусгасан гэнэ.

Тэр эмэгтэй сэтгүүлүүд тэдэнд “агуу үнэт” зүйл болсныг мөн хүүхдүүдэд нь сайн ёс суртахуун, хэл

яриаг заадгийнх нь төлөө магтаж байлаа. Сэтгүүл түүнд их таалагдсан учраас захиалгаа шинэчлэн, хамт ажилладаг хүмүүстээ сэтгүүлийн захиалгыг бэлэг болгон өгснөөр хүүхдүүд нь бас сэтгүүлээс ашиг тусыг олох болно.

“Түүнчлэн, сүмийн гишүүн биш хүмүүс ч [Сүмийн сэтгүүлүүдийн] үнэ цэнийг мэдэрч, харж чаддаг бөгөөд [тэд] үүнийг бусадтай хуваалцахыг хүсдэг юм” хэмээн Вонгвирафаб эгч бичсэн байна.

Сүмийн удирдагчид гишүүдийг Сүмийн сэтгүүлүүдээс уншиж тэдгээрийг бусадтай хуваалцахыг

Орон нутгийн сэтгүүлийн төлөөлөгчтэй холбоо барьснаар мөн [help@store.lds.org](mailto:help@store.lds.org) -т э-мэйл бичих буюу тухайн улсын захиалагчийн үйлчлэлийн төлөөлөгчид утасдан туслалцаа авах боломжтой. Эдгээр төлөөлөгчдийн утасны дугаарын жагсаалт нь улс улсаар [store.lds.org](http://store.lds.org)-т байгаа. Хуудасны доод хэсэг дэх **Customer Support** -ийн доор байгаа **Contact Us** дээр дараад, дараа нь **Contact Us** дор **урцаар** гэснийг дар.

байнга зөвлөж, урамшуулан дэмжсээр ирсэн билээ.


Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перри Сүмийн сэтгүүлүүдийн үнэлж баршгүй ач холбогдлыг онцгойлон тэмдэглэсэн юм. “Эдгээр сэтгүүлүүдийн чанар сайтай нийтлэл нь гэр бүлээ элэгсэг халуун сэтгэл, энэрэл хайр, сайн мэдээний хүч чадлаар дүүргэхэд тань туслах болно” гэж тэрээр хэлжээ (“The Importance of the Family,” *Лиакхона* 2003 оны 5-сар, 42).

Далын Ахлагч Крайг А.Кардон Санваарын Албаны Гүйцэтгэх захирлын туслах бөгөөд Сүмийн сэтгүүлүүдийн эрхлэгчээр үйлчилдэг. Тэрбээр Сүмийн сэтгүүлүүд хувь хүн бүрд хэчнээн үнэ цэнэтэй болохыг мэддэг.

“Сүмийн сэтгүүлүүд нь өнөөгийн дэлхийд хамаатай зүйлүүдээр Тэнгэрлэг Эцэгийн бүх насны хүүхдүүдэд Их Эзэнээс ирдэг бошиглолын зөвлөгөөг агуулдаг Сүмийн эрх мэдэл бүхий удирдагчдын дуу хоолойны чухал хэсэг юм” гэж тэр хэллээ. “Дэлхий даяарх Сүмийн болон Сүмийн биш бүх хүмүүсийн адил нийтлэг нөхцөл байдлыг хөндсөн сонирхолтой бөгөөд амьдрал ахуйд тустай өгүүлүүд сар бүр нийтлэгддэг.” Үнэнийг чин сэтгэлээсээ хайж байгаа бүх хүмүүст эдгээр сэтгүүлүүдэд нийтлэгддэг сүнсээр нөлөөлөгдсөн сургаалууд болон удирдамжууд туйлын чухал юм.

Сүмийн сэтгүүлүүдийг захиалагч бүр сүмийн гишүүн бус найз нөхөд, хамаатан садандаа сэтгүүлийн захиалгыг бэлэг болгон өгвөл 1.7 сая шинэ захиалагчид Сүмтэй сар бүр нөхөрсөг холбоотой байх болно.





**Сүмийн сэтгүүлүүдийг бэлэг болгон захиалснаар бүх насны, бүх шашны мөн бүх үндэстний сүмийн гишүүн бус найз нөхөд болон гэр бүлийнхэнтэйгээ сайн мэдээг хуваалцахад Сүмийн гишүүдийг урамшуулан дэмждэг.**

Сүмийн Online Store—store.lds.org—аар дамжуулан хувь хүмүүс нэг буюу хэд хэдэн сэтгүүлүүдийг түргэн шуурхай, хялбар захиалж болно. Эсвэл гэр бүлийнхээ гишүүн буюу найздаа сэтгүүлүүдийн захиалгыг бэлэг болгон өгч болно. *Найз*, *New Era*, *Ensign* сэтгүүлүүд зөвхөн англи хэл дээр хэвлэгддэг ч, энэ гурван сэтгүүлүүдэд нийтлэгддэг өгүүлүүдийг *Лиакхона* сэтгүүл олон хэлээр нийтэлдэг.

Аризонагийн Пеора Гадасны нэгэн бишоп *Найз* сэтгүүлийн бүтэн жилийн захиалгыг тойргийнхоо хүүхдүүдэд бэлэг болгон өгөх нь тэдэнд амьд бошиглогчид, төлөөлөгчдийн

үтсийг хүргэхэд туслах үр нөлөөтэй арга зам гэдгийг мэдсэн гэнэ.

АНУ-ын Техас мужийн Пенелоп Б.Вудворд *Лиакхона* сэтгүүлийн захиалгыг өөрийн үеэлд мөн өөр улсад амьдардаг найз болон багшдаа бэлэг болгон илгээсэн ажээ.

“Сэтгүүл нь [миний үеэлд] гэрээнууд хийж, тэдгээрийг сахихын чухлыг сурахад нь тусална гэдэгт би найдаж байна” гэж бичжээ. Тэрээр сэтгүүлийн захиалгыг бэлэг болгон өгөх нь “[найзад минь] сэргээгдсэн сайн мэдээг нэг өдөр сонсон, хүлээж авах суурийг нь бэлтгэх зам болно” гэж цааш нь хэллээ.

Сэтгүүлийг бэлэг болгон захиалахын тулд store.lds.org-т

орно уу. Сэтгүүл захиалах мэдээлэл хуудасны зүүн талд байгаа. Онлайнаар захиалах үйл явц нь хувь хүмүүст захиалгаа хэрхэн шинэчлэх, шинээр захиалах болон хэрхэн бэлэг болгон захиалахыг харуулдаг.

Store.lds.org нь хятад, англи, франц, герман, итали, япон, солонгос, португаль, орос, испани хэл дээр байдаг. Эдгээр хэлээр ярьдаггүй эсвэл интернетэд холбогдох боломжгүй хүмүүс олон оронд байдаг Сүмийн Хангамжийн Төвтэй холбоо барих буюу тэдгээрт очиж сэтгүүлүүдийг захиалах юм уу бусдад бэлэг болгон захиалж болно. ■

# Онлайн дахь Language Pages (Хэлний хуудсууд)-т Сүмийн материалуудыг 100 гаруй хэлээр тавьсан байгаа

**Д**элхий даяар өргөн тархсан 10 хэл—хятад, англи, франц, герман, итали, япон, солонгос, португаль, орос, испани хэлний алинаар нь ч ярьдаггүй, дэлхий даяарх гишүүдэд Сүмийн материалуудыг төрөлх хэлээрээ олж унших нь хэцүү байдаг. Харин LDS.org-ийн хэлний хуудсыг мэддэг хүмүүст Сүмийн гол материалуудыг хэрэглэх нь хэдхэн товчлуурыг дарахад л хангалттай.

LDS.org-ийн нүүр хуудасны дээд талын баруун хэсэгт эсвэл доод талын зүүн хэсэгт **дэлхийн зурагтай хэсэг дээр** даран LDS.org дахь хэлний хуудсуудын холбоосуудыг олж болно. 2012 оны эцэс гэхэд LDS.org-ийн баг нь 108 хэлээр хуудастай болно гэдэгт найдаж байна. Үүнд Хрватски (Хорват), Малагаш (Мадагаскарт ярьдаг), мөн Тви (Ганад ярьдаг) хэлүүд багтаж байна.

Энэ жил хэлний хуудсуудад шинэ зүйлсийг нэмэн баяжуулсан. Тухайлбал *Лиакхонагийн* орон нутгийн хуудасны PDF файл нь 40 гаруй хэлээр мөн 2012 оны 4 дүтээр сарын ерөнхий чуулганы PDF файлын энгийн текст 90 гаруй хэлээр гараад байна. Мормоны Номын PDF файл 99 хэлээр байгаа бөгөөд өөр 24 хэлний хуудсыг LDS.org-т өмнө байсан хуудас дээр нэмсэн байна.

Орчуулагдсан төслүүдийг тодорхой хэлүүдээр Сүмийн материалуудыг танилцуулах зорилгоор Сүмээс дэлхий даяар хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хэвлэн түгээдэг.

Сүмийн материалуудыг дэс дараатайгаар хэвлэх энэхүү төлөвлөгөөгөөр, гол чухал зүйлүүд нь жишээлбэл, ариун ёслолын залбирлууд, Итгэлийн Тунхаг, *Gospel Fundamentals* гарын авлага, ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс сонгож авсан үгс, мөн *Testimony of the Prophet Joseph Smith* товхимол зэрэг гарын авлага, номууд тэргүүн зэргийн ач холбогдолтой учраас хамгийн түрүүнд орчуулагдсан байдаг.


Нэмэлт орчуулагдсан материалууд болох судрууд, дуулууд, “Тэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” Тэргүүн Зөвлөлийн болон айлчлагч багшийн захиас бичгүүдийг тухайн хэлээр ярьдаг Сүмийн гишүүдийн тоо нэмэгдсэн үед хэвлэн гаргадаг.

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга баталсны дараа Сүмийн материалуудыг орчуулах боломжтой болдог. Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлүүд нь Сүмийн материалыг аль нэг хэлээр хэвлэн гаргах шаардлагатай гэж үзвэл энэ тухай хүсэлтээ гаргаж болно.

“Эдгээр хуудсууд нь бүх гишүүдийн хувийн болон ням гарагийн цутгаануудын хэрэгцээнд зориулагдсан юм” хэмээн дижитал сувгуудын уран бүтээлийн ахлах менежер Мэтт Робинсон ярилаа. “Орон нутгийн удирдагчид энэхүү эх сурвалжийг хувиараа судлах, дуудлагадаа болон гэр бүлдээ хэрхэн ашиглах талаар гишүүдэд заах зэрэгт ашиглаж болно.”

Арманы Ереван дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлийн 2-р зөвлөх Саргис Аявазан хэлэхдээ гишүүд нь армян хэлний хуудсаас дуудлагаа гүйцэтгэхэд нь тэдэнд туслах материалуудыг хэвлэн гаргахад ашиглаж байгаа гэжээ. Мөн Сүмийн талаар мэдээлэл хүлээн авч, уншихдаа хэрэглэдэг ажээ. Тэд төрөлх хэлээрээ ерөнхий чуулганы материалуудыг олж авахад ч үүнийг ашигладаг. ■

**LDS.org-ийн  
хэлний зуу  
гаруй хуудсууд  
дээр хэвлэж,  
татаж авч  
болох мате-  
риалуудын  
тоо цаашид  
улам нэмэгдэх  
болно.**





# Ерөнхийлөгч Монсонгийн насны ойг хүндэтгэлийн үдэш зохион байгуулж, дуу хөгжмөөр тэмдэглэв

Герри Авант

Сүмийн мэдээний редактор

Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн 85 насны ойг 2012 оны 8-р сарын 17-нд Чуулганы Төвд сүр жавхлантай бөгөөд хүндэтгэлтэйгээр тэмдэглэхэд 20,000 орчим хүн дуу хөгжим, хүүрнэл яриа, “Амьдралын алтан өдрүүд” нэртэй хүндэтгэл үзүүлэх хөтөлбөр зохион байгуулж тэмдэглэв.

Найман сарын 21-нд болсон түүний 85 насны ойг тэмдэглэхэд зориулсан шилдэг цуглуулгад Ерөнхийлөгч Монсонгийн дуртай Бродвей шоуны хөгжмийн хэлээр илэрхийлсэн зарим захиасууд болон сүнслэг нөлөө бүхий бусад дуунууд орсон байлаа.

Ерөнхийлөгч Монсон эхнэр Францис Жонсон Монсон болон гэр бүлийнхний хамт үзэгчдийн дунд эхний эгнээнд сууж байлаа.

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Ерөнхийлөгч Хенри Б.Айринг, “Аризонагийн цөл дэх алслагдсан зам дээр” Ерөнхийлөгч Монсон нэгэн гэр бүлийн хос болон тэдний бяцхан хүүхдүүдтэй нь гар барихаар зогссон ч, түүнд ойртон ирсэн олон олон хүнтэй тэвчээртэйгээр гар барихыг харсан тухайгаа хүндэтгэлтэйгээр гэрчилсэн ажээ.

Ерөнхийлөгч Монсон дэлхий даяар олон газарт, ихэвчлэн хүүхдүүдийн дунд “Их Эзэнийг төлөөлөн очдогийг”

Ерөнхийлөгч Айринг гэрчилсэн юм. “Зөвхөн түүний мэндчилсэн хүмүүст алтан агшин тохиодог төдийгүй, харин үүнийг харсан бидэнд ч бас энэ нь онцгой агшин байдаг” гэж тэр хэлжээ. “Би өөрчлөгдсөн бас энэхүү агшныг мэдэрсэн ямар ч хүн, мөн би ч бас хайрыг мэдэрсний улмаас өөрчлөгдсөн. Өөрөөр хэлбэл бид өөрчлөгдсөн юм.”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф бас “алтан өдрүүдээр дүүрсэн амьдралынх нь төлөө түүнд баяр хүргэжээ. . . . Ерөнхийлөгч Монсон, та бол харанхуйг гэрэлтэй болгодог найз, бидний үе дэх Бурханы бошиглогч. Бид танд хайртай, бид таныг дэмждэг. Бид таны төлөө залбирдаг” гэж хэлжээ.

**“Амьдралын алтан өдрүүд” нь Ерөнхийлөгч Монсонгийн амьдрал, түүний бага нас, гэрлэлт, цэргийн алба хаасан болон Сүмийн үйлчлэлийн тухай өнгөрсөн үеийг дуу хөгжмөөр дамжуулан эргэн дурссан хормууд болж өнгөрлөө.**

Өөр олон Сүмийн, шашны болон иргэний удирдагчид бас насан туршийн анд найз нар нь Ерөнхийлөгч Монсонд урьдчилан бэлтгэсэн видео бичлэгүүдээр хүндэтгэл үзүүлсэн ажээ. Тэрээр мөн Скаутад оролцсон олон жилийнхээ төлөө сайшаал магтаал хүлээсэн юм.

Хүндэтгэл үзүүлэх хөтөлбөрийн төгсгөлөөр Ерөнхийлөгч Монсонд Шотландын зохиолч, яруу найрагч Жеймс Барригийн “Бурхан бидэнд дурсамжуудыг өгсөн, ингэснээр бид амьдралдаа зуны сарнайг өвөл авах болно” гэсэн үгсийг хүмүүс давтан хэлж байлаа (Лоранс Ж.Петрийн эмхтгэсэн, *Peter's Quotations: Ideas for Our Time* (1977), 335-ыг үзнэ үү).

“Би энэ үдэш сэтгэл доглом, үй түмэн дурсамжтай боллоо” гэж Ерөнхийлөгч Монсон хэлжээ.

Чуулганы Төвийн тайзыг таазанд нь тултал түүний амьдралын “алтан” өдрүүдийн бэлгэдэл болсон хэдэн зуун шар сарнайгаар чимсэн байлаа. ■



ГЭРЭЛ ЗҮГТЭЙГ ДЭВЭ ГЭХИС

## Кап Вердэд анхны гадас байгуулагдав

2012 оны 4 сарын 29-ний ням гарагт, тэр үед Европын Бүсийн Ерөнхийлөгч байсан Ахлагч Эрик В.Копишки, нийслэл хот Прайягийн Кап Вердэд (бас Кабо Вердэ гэж нэрлэдэг) 1000 гаруй Гэгээнтнүүдтэй анхны гадсыг зохион байгуулжээ.

Розефелт Тейксера ерөнхийлөгчөөр, Адилсон Монтерио 1-р зөвлөхөөр, Хосе Пирес 2-р зөвлөхөөр дуудагдаж, Шинэ Прайягийн Кап Вердэ гадсыг тэргүүлэн удирдахаар онцгойлон адислагдсан.

## Лондонд цуглааны байр дахин онцгойлон адислагдснаар сайн мэдээг олон түмэнд хүргэх боломжтой болов

Сүмийн түүхэнд нэрээ үлдээсэн Английн Лондон хотын Хайд Парк дахь цуглааны байрыг 2012 оны Олимпын Тоглолтын өмнөхөн зочдын төвийн зориулалтаар шинэчлэн засварлаж, 7-р сарын 1-нд дахин онцгойлон адислав.

Тэр үед Европын Бүсийн Ерөнхийлөгч байсан Далын Ахлагч Эрик В.Копишки байрыг дахин онцгойлон адисалсан юм. “Олон жилийн турш олон зуун мянган хүн энэхүү байранд ирж Есүс Христийн сайн мэдээний тухай сонсож мэдэх болно гэдэгт би итгэлтэй байна” гэж тэр хэлжээ.

## Шинэ Каледониа Сүмийн өсөлтийг тэмдэглэв

2012 оны 5-р сарын 27-нд Номхон Далайн Бүсийн Ерөнхийлөгч, Далын Ахлагч Жеймс Ж.Хамула 800 гишүүний хүсэн хүлээж байсан Шинэ Каледонийн анхны гадсыг зохион байгуулав.

“Есүс Христийн сайн мэдээ заагдан, олон олон хүн түүнийг хүлээн авснаар Хожмын Үеийн Гэгээнтнүүд болон Шинэ Каледониа бүхлээрээ адислагдах болно” гэж Ахлагч Хамула хэлжээ.

Шинэ гадас болох Шинэ Каледонийн Ноюмии гадас нь 2,000 гишүүн, цуглааны найман байртай ажээ.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ АХЛАГЧ ХОСЕ А.ТЕЙКСЕРА



**Прайя Кап Вердэ Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд (зүүнээс баруун тийш): Адилсон Монтерио, 1-р зөвлөх; Розефелт Тейксера, ерөнхийлөгч; Хосе Пирес, 2-р зөвлөх.**

“Шинэ Каледоний хүмүүст сайн мэдээ болон үүний бүх зарчмуудыг заах нь бидний хамгийн чухал үүрэг байх болно. Эдгээр нь тэдэнд, тэдний гэр бүлүүдэд мөн тэдний ажлын орчин нөхцөлд болон нийгэмд аз жаргалыг авчрах болно” гэж гадасны анхны ерөнхийлөгчөөр

дуудагдсан Жорж Гюиди хэлжээ. Марк Моселлин, Тиерри Городи нар түүний зөвлөхүүдээр дуудагдав.

## Этиоп дахь Сүмийн анхны цуглааны байр

Этиопийн гишүүд улс орондоо анхных нь болох цуглааны байраас ирж байгаа адислалуудыг аль хэдийн харсан ажээ. Аддис Абаба болон Адама хотуудын хоорондох өргөн дардан зам дээр орших энэхүү байр нь гурван давхар бөгөөд газар доорх гаражтай юм.

Гэвч цуглааны байрын техникийн үзүүлэлтүүдээс илүү чухал зүйл бол энэ нь шинэ байрнаас холгүй орших орон сууцанд цуглаж байсан салбарын гишүүдийн итгэлийн бэлгэдэл болон тэдэнд үйлчилж байгаа явдал юм.

Дебре Зейт Салбарын ерөнхийлөгч Ифрим Аемеро Миконен, “Би шинэ байрны хажуугаар өнгөрөх бүрд гэрээнүүдээ санадаг. Ахмад Моронай эрх чөлөөний тугийг өргөсөн үеийнх шиг би тийм байдлаар хүчирхэгжсэн” гэжээ.

## Шинэчил

Тэргүүн Зөвлөл Төв Америкийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийг өөрчлөхийг зарлаж, Ахлагч Роберт С.Гейеийг Сүмийн удирдах төвд өөр албан тушаалд томилж, түүний оронд Ахлагч Кевин Р.Данканыг Хоёрдугаар зөвлөхөөр дууджээ. Наймдугаар сарын *Ensign*, *Лиакхона* сэтгүүлд нийтлэгдсэн Бүсийн үүрэг даалгаврын хүснэгтэнд эдгээр үүрэг даалгаврууд өөрчлөгдсөнийг тэмдэглэсэн байна.



## Лиахона-д таны асуултын хариулт гардаг

Би Сүмд төрсөн гишүүн. Заримдаа би амьдралдаа ирсэн сайн мэдээний олон адислалыг үнэлэн үздэггүй. Тэгээд би эдгээр зүйлсийн талаар бодоод үзэхэд, өөрт буй бүхий л зүйлүүдийн төлөө Тэнгэрлэг Эцэгтээ хэзээ ч хангалттайгаар талархаж байгаагүйгээ мэддэг. Эдгээр адислалуудын нэг нь сүнслэг нөлөө бүхий Лиахона сэтгүүл юм. Би сэтгүүлийг унших болгондоо өөрт хэрэгтэй хариулуудыг хүлээн авдаг нь ямар гайхамшигтай гээч. Эдгээр захиасуудад тань их баярладаг шүү.

Людмила Л., нас 13, Аргентин

## Бидний гэрчлэл өсч хөгждөг

Лиахона миний амьдралыг бас манай гэр бүлийн амьдралыг өөрчилсөн. Энэ бол агуу сэтгүүл, учир нь хүн үүнээс суралцаж, мэдлэгийг олж авч чадна. Энэ сэтгүүлийн ачаар бид хүчирхэгжиж, Сүмийн талаарх бидний гэрчлэл өсөн нэмэгддэг.

Ана Марсела Экиникю Хоёос, Колумб

## Гэр бүлийн үдшийн санаануудын талаарх уриалга

Лиахона сэтгүүл гэр бүлийн үдшийн санаа болон туршлагаа ирүүлэхийг танай гэр бүлээс хүсч байна. Санаанууд нь богинохон бөгөөд амжилттай, үр өгөөжтэй болсон гэр бүлийн үдшийн тухай эсвэл та гэр бүлийн үдшээ гэр бүлийнхээ өвөрмөц хэрэгцээнд хэрхэн тохируулдаг тухай товчхон өгүүлсэн байж болно.

Өөрийн санаа болон туршлагаа (ямар ч хэл дээр) [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар явуулна уу. Та бүтэн нэр, э-мэйлийн хаяг мөн тойрог, салбар болон гадас, дүүргийнхээ нэрийг бичнэ үү.

Энэ дугаарт гэр бүлийн үдэнд ашиглаж болох өгүүлмүүд болон үйл ажиллагаанууд байгаа. Зарим жишээг доор өгөв:



**“Гэрэл ба гэрчлэлийн уламжлал,”** 10-р хуудсанд: Өгүүллийг товчлон барилгын шат барих ажлыг харуулах үзүүлэн бий болгоход гэр бүлээ урьж болно. Сүм танай гэр бүлд гэр бүлээ болон амьдралынхаа бусад талыг илүү өндөр түвшинд хүргэх “шатыг” хэрхэн өгдөг талаар ярилц.

**“Бошиглогчид Христийн Мэндэлсний Баяраар,”** 20-р хуудас: Бошиглогчдын амьдралын талаар хэдэн түүхийг уншсаны дараа, өнгөрсөн Христийн Мэндэлсний Баярын үеэр өөрийн чинь болон бусад хүмүүсийн амьдрал аль нэг онцгой туршлагаар хэрхэн нөлөөлөгдсөн тухай туршлагаасаа хуваалцахыг бодолцоно уу. Энэ баярын үеэр бошиглогчдын үлгэр жишээг дагах арга замуудын талаар ярилцахыг хүсэж болно.

**“Зарлигуудыг сахиснаас ирдэг аюулгүй байдал ба амар амгалан,”** 32-р хуудас: Бага насны хүүхдүүдтэй хүмүүс ариун сүм рүү хөтлөх замын дагуу зөв шударга зүйлүүдийг хийж байгаа зургийг тэднээр зуруул. Бусад гэр бүлүүд энэхүү өгүүллэгийг бүгдийг нь уншиж,

ярилцан, “аз жаргалд хүрэх зам нь. . . зарлигуудад дуулгавартай байснаар эхэлдэг” гэснийг онцлон тэмдэглэж болно.

**“Христэд хэрхэн бэлэг өгөх вэ,”** 48-р хуудас: Ерөнхийлөгч Хенри Б. Айрингийн өгүүллэгийг хамтдаа унш. Христийн Мэндэлсний Баяраар Аврагчид юу өгөхийг хүсэж байгааг нь хүүхдүүдээрээ бичүүлж, бичсэн зүйлийг нь Христийн Мэндэлсний Баярын бэлэг болгон боолгож болно. Материаллаг болон сүнслэг хэрэгцээнд нь тусламж хэрэгтэй ямар хүмүүс байгааг мэдэхийн тулд ярилцаж болно.

**“Христийн Мэндэлсний Баярын залбирал хариулагдсан нь,”** 68-р хуудас: Пегги Шонкений тухай түүхийг гэр бүлтэйгээ хамт унш. Та залбирлынхаа хариуг хүлээн авсан үеийнхээ талаар хуваалцахыг хүсэж болно мөн хүүхдүүдээ энэ үеийнхээ тухай хуваалцахад урамшуулан дэмж. Христийн Мэндэлсний Баярын үеэр гэр бүлийнхээ хүлээн авсан залбирлын бүх хариуг тэмдэглэх талаар бодолцоно уу.

## Үггүй гэрчлэл

Миний хүү Дерек хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй учраас ярих нь түүнд маш хэцүү байдаг. Дерек гэр бүлийн үдэнд дуртай бөгөөд олон сарыг гэр бүлтэйгээ хуваалцах хичээлд бэлтгэхэд зориулдаг юм.

Бидний сэтгэлд хоногшин үлдсэн түүний хичээлүүдийн нэг нь “Лихайн зүүд” нэртэй хичээл байв. Тэр гэрт бас гадаа хаа сайгүй олс өлгөсөн байж билээ. “Би Христэд итгэдэг” дууллын СД-ийг бид сонсож мөн ширээн дээр тавьсан Лихайн зүүдний зургийг харснаар хичээл эхлэв. Дараа нь Дерек биднийг нэг нэгээр нь олсны үзүүрээс бариулав.

Бид түүнийг дагаж явахад, нэг талд Христийн зурагнууд, нөгөө талд нь радио, зурагт, тоглоом гэх мэтийн анхаарал сарниулах зүйлс байлаа. Дерекийн дуртай дуу болох “Гэтэлгэгч минь амьдыг би мэднэ” дууны хөгжмийг сонсоход бид хичээл дуусах нь гэдгийг ойлгосон.

Хүн бүр явж өнгөрсний дараа, Дерек Гэрээнүүд хэмээх DVD -г тавин Есүс Христ Америк тивийн хүмүүс дээр хэрхэн хүрч ирснийг бидэнд үзүүлэв. Хүү маань Аврагчийн талаарх гэрчлэлээ ямар ч үг хэрэглэхгүйгээр хуваалцахад Сүнс маш их хүчтэй мэдрэгдсэн билээ.

Венди Томпсон, АНУ

# НАРНЫ ЦАЦРАГ БҮЛГИЙНХЭН (САНБИМЧҮҮД), ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ БА САЙН МЭДЭЭНИЙ БАЯР БАЯСГАЛАН

**Х**эдэн жилийн өмнө Ахлагч М.Рассел Баллард бид хоёр Сүмийн Олон Нийт-тэй Харилцах Албаны зөвлөгч Ерөнхий эрх мэдэлтэн байх үедээ, бид хэвлэл мэдээл-лийн хэрэгслээр дамжуулан Сүмийн тухай мэдэхэд нь туслахын тулд Сүмийн гишүүн бус хүмүүстэй олонтоо хэлхээ холбоо тогтоодгийг мэдсэн юм. Ахлагч Баллард бид хоёр энэ ажилд өөрчлөлт гаргахыг хүсэн, Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор, гол сэтгүүлүүдийн редакцийн зөвлөлтэй уулзаж, Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид улс төрийн хувьд төвийг сахих ёстой гэдэг үзэл баримтлалыг хуваалцдаг байлаа. Нэр дэвшигчид болон улс төрийн намуудын байр суурийг бид дэмжих ёсгүй. Гэвч бид итгэл биш-рэлээ хамгаалдаг хүмүүс байхыг хүсдэг. “Хэрэв та нар бид юунд итгэдэг тухай ярилцахыг хүсдэг бол ирээд бидэнтэй ярилц л даа. Бид үүнийг л хүсдэг” гэж тэдэнд хэлдэг байлаа.

Бидний уулзалтуудыг сайн үр дүнгээ өгч бидний хүсэлтийг хүмүүс сайшаан хүлээн авс-ныг бид мэдсэн. Харин бид одоо хэвлэл мэдээ-лэлүүд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн талаар илүү сайн ойлголттой болсоныг харж байна. Зарим хэвшин тогтсон санаа бодол үгүй болж, бусад хүмүүс биднийг амьдралд боловсрол болоод нийгмийн үзэл бодлын хувьд мэдээлэл-тэйгээр хандахыг хичээдэг хүмүүс хэмээн хү-лээн зөвшөөрдгийг бид харсан билээ. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бүгдээрээ яг адилхан биш, манай хүмүүс бие биеэсээ олон сонирхолтой зүйлсээр өөр гэдгийг Сүмийн гишүүн бус хү-мүүс хүлээн зөвшөөрдгийг бид бас ажигласан.

Ийнхүү байнга өөрчлөгдөж байгаа нөх-цөл байдалд Сүмийн гишүүн байна гэдэг, гишүүдээ төлөөлөн үгээ хэлнэ гэдэг, бидний итгэл бишрэлийн тухай найз нөхөд, хөршүү-дийнхээ асуултанд хариулна гэдэг гайхам-шигтай аз завшаан юм. Бид ингэснээрээ, Есүс Христийн сайн мэдээнээс баяр баяслыг олж мэдрэхээс илүү чухал зүйл гэж юу байх би-лээ. Сайн мэдээг бусадтай хуваалцсаны эц-сийн үр дүн нь бид Есүс Христ хэн болохыг мэддэг бөгөөд Тэнгэр дэх хайраар дүүрэн Эцэг маань биднийг адислах хосгүй онцгой

*Нарны цац-  
раг бүлгийн-  
хэн олон  
нийттэй  
харилцах  
ажилд юу  
хийх ёстой  
вэ? Тэд сайн  
мэдээний  
баяр баяс-  
галанг ху-  
ваалцахад  
олон зүйлийг  
хийж чадна.*

**Ахлагч  
Квинтин Л.Кук**

Арванхоёр  
Төлөөлөгчийн Чуулгын



боломж бидэнд байдаг явдал мөн.

Сайн мэдээг хуваалцах боломж бүрийг ашигладаг, манай шилдэг гишүүн номлогчид ихэнхдээ баяр баясгалангаар нүүр нь гэрэлтсэн хүмүүс байдаг нь сонирхолтой юм. Би Номлолын Албаны Гүйцэтгэх захирал байхдаа Францад болсон хэдэн баптисмыг санаандгүй байтал ажигласан юм. Бид сэтгэл ихэд догдолж, үүнд хэд хэдэн шалтгаан байсныг мэдсэн юм. Бидний сэтгэл үлэмж догдолсон гол шалтгаануудын нэг нь даваа гарагийн өглөө ажиллахаар явж, нарны цацраг бүлгийнхний тухай ярьсан нэг эгч байсан юм. Тэр эгч Хүндэтгэлийн өдрийн дараа, урьд өдөр нь бага насны хүүхдүүдэд заасан туршлагынхаа тухай хамт ажиллагсдаа ихэд сэтгэл догдлон ярьсан ажээ. Удалгүй түүнтэй хэлхээ холбоотой байдаг хүмүүс нарны цацраг бүлгийнхний тухай ярихыг нь тэсч ядан хүлээх болсон гэнэ. Гэтэл юу болсон гэвч? Манай дэлхий болон түүний ирээдүйн тухай бидний бодол санаатай яг адил үзэл бодолтой бүлэг хүмүүс байдаг нь мэдэгдсэн аж. Санаанд оромгүй нэг зүйл харагдсан нь нэг хүн зүгээр нэг баяртай байсан төдийгүй ирээдүйн төлөөлөгчид болсон хүүхдүүдэд бүр ч их баяртай байжээ. Энэ эгч Аврагчийг ихэд хайрладаг бөгөөд тэрхүү хайр нь нүүрэнд нь гэрэлтэх мэт харагдана. Хамт ажиллагсад нь илүү их зүйлийг мэдэхийг хүсдэг байлаа.

Хэрэв бид байгаа бүхэндээ сэтгэл ханга-луун, баяртай байж, баяр баясгаланг мэдрэн, үүнийгээ илэрхийлдэг байвал бид улам аз жаргалтай байх болно. Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг зүйлийг бид хийдэг. Бид бусадтай сайн харилцаатай байснаар улам сайн хүмүүс болж чадна. Бидний үр хүүхэд, найз нөхөд хөршүүд илүү аз жаргалтай болно. Баяр баясгалан бол хамгийн чухал зүйл. Бид сайн мэдээний баяр баясгаланг бусадтай хуваалц-санаар Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг зүй-лийг хийж байгаа хэрэг юм. ■

*Mormon Channel телевизийн ярилцлагаас хялбаршуулан авав. Ярилцлагыг англи хэлээр бүрнээр нь сонсохыг хүс-вэл [mormonchannel.org/conversations/27-д\\_орж\\_үз](http://mormonchannel.org/conversations/27-д_орж_үз).*



Мормоны Ном бол Тэнгэрлэг Эцэгийн бэлэг



Иосеф Смит—Түүх 1:29–35, 42–54, 59–60



Иосеф Смит



Тэнгэр элч Моронай



Энэ жил *Лиахонагийн* олон дугаарт Мормоны Номон дахь судрын баатруудыг нийтлэх болно. Судрын баатруудын дүрсийг бат бөх бөгөөд ашиглахад хялбар болгохын тулд хайчилж аван, хатуу цаас, жижигхэн цаасан уут юм уу гар хийцийн савхан дээр наа. Судрын баатруудыг дугуй эсвэл уутанд хийж, тэдний тухай өгүүлдэг судрын түүх хаана байдгийг заасан шошго нааж хадгал.



*Христийн Мэндэлсний Баярын  
үеэр ариун сүмүүдийн газрыг чим-  
сэн чимэглэлийн гэрэл нь тэндэх  
баяр баясгалангийн амар амгаланг  
эдлэхийг урих лугаа адил Есүс  
Христ Дэлхийн гэрэл болон гялал-  
засж, сайн мэдээний ёслолууд, ялангуяа Түүний ариун өр-  
гөөнд хүлээн авдаг ёслолуудаар дамжуулан Түүний санал  
болгодог амар амгаланг хүлээн авахад бүх хүмүүсийг урьж  
байна. Хэн бүхний мэдэрч чадах хамгийн агуу баяр баяслын  
дотор ариун сүмийн лацдан холбох ёслолуудаар дамжуулан  
гэрлэлт нь үхлээс цааш үргэлжилж, гэр бүлүүд үүрд мөнх  
оршиж чадна гэдэг туршлагыг мэддэг байх явдал мөн.  
24-р хуудсан дээрх “Ариун өөрчлөлт,” 28-р хуудсан дээрх  
“Мөнхийн гэр бүл дээр анхаарал төвлөрүүлэхүй,” 64-р  
хуудсан дээрх “Дэлхийн гэрэл” өгүүллүүдийг үзнэ үү.*



ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ





128 mm  
front flap

5mm  
trim  
bleed

# Залуучуудад зориулсан шинэ сурах материалуудыг ХҮЛЭЭН АВАХАД БЭЛТГЭХ

Ирэх нэгдүгээр сараас эхлэн Аароны Санваарын Чуулгууд, Залуу Эмэгтэйчүүдийн ангиуд, залуучуудын Ням Гарагийн хичээлүүдэд заах болон сурах арга барил өөрчлөгдөх болно.



Залуучуудад зориулсан шинэ сурах материалуудыг хэрэглэж байгаа хүмүүсээс ирсэн санал сэтгэгдэл

үнгүрсүн жилийн туршид дэлхий даяарх гадаснууд Ням гарагийн суралцах шинэ маягийг туршсан юм. үүнийг туршиж үзсэн хүмүүс нь их үүрчлүлт гаргалаа гэж хэлж байна. Тэд юу гэж хэлсэн бэ:

128 mm  
back flap

5mm  
trim  
bleed

### Залуучуудаас

“Сурах үйл явц нь— зүвхүн Ням гарагийн хичээлээр дуусдаггүй нь надад хамгийн их таалагдсан. Та долоо хоногийн туршид үргэлжлүүлэн суралцах боломжтой. Багш та нарт даалгавар үгдүүд дараагийн Ням гарагт бэлтгэлтэй ирэх хэрэгтэй болдог.”

“Чуулгын бусад гишүүд үүрсдүү хичээлийг зааж байгаа болохоор нэг л зүв чиглэлд хандуулж чадах юм бол энэ хичээлүүдэд хүмүүсийг оролцуулахад амархан байсан.”

“Хичээл бүрийн эцэст... хичээл заасан хүн нь... бидэнд уриалга үгдүүг... Тийм болохоор долоо хоногийн туршид бид илүү сайн болох уриалгатай байдаг.”

### Удирдагчид болон багш нараас

“үнгүрсүн долоо хоногт үгсүн даалгаврынхаа талаар бид ярилцдаг. үнгүрсүн долоо хоногийн туршид уг сургаалыг сурч мүн дагахыг хичээж байх зуур олж авсан туршлагаа хуваалцах нь... Сүнслэг байдлыг ангид авчирдаг.”

“Бид залуу эрэгтэйчүүдэд үүнийг хийх боломжийг үгсүн бүгүүд тэд амжилттай хийсэн. Тэд сайн мэдээний талаарх ярилцлагыг санаачлагчид байж чадсан.”

“[Залуучууд] ярьснаар тэдний гэрчлэл нэмэгдэж, уг сургаалын талаарх ойлголт нь тэдний амьдралын нэг хэсэг болдог.”

**Асуултууд байна уу? Энэхүү онцгой хавтасны арын хуудасны дотор талыг болон [lds.org/youth/learn](https://lds.org/youth/learn) үзээрэй.**





## Залуучуудад зориулсан шинэ сурах материалууд

### АСУУЛТ, ХАРИУЛТ

#### Яагаад өөрчлөгдөж байгаа вэ?

Энэхүү шинэ маягаар сурах нь залуучуудыг найз нартайгаа сайн мэдээний талаар ярихад илүү бэлтгэлтэй болгож, одоо болон ирээдүйд номлогчийн болон гэр бүлийн үйлчлэл хийхэд бэлтгэх сайн мэдээний талаарх тэдний гэрчлэлийг гүнзгийрүүлэхэд туслах юм. Энэ нь тэд судруудаас эрэлхийлж, бодлоо хуваалцахад мүн сурч байгаа зүйлсээ ангиас гадуур хэрэгжүүлэх урилгыг хүлээн авахад идэвхтэй оролцсоноор тохиох болно. Ангидаа тэд амьд бошиглогчдын одоогийн зааж байгаа зүйлсээс суралцах болно.

#### Аль ангиуд энэ шинэ хичээлүүдийг ашиглах вэ?

Аароны Санваарын чуулгууд, Залуу Эмэгтэйчүүдийн болон залуучуудын Ням Гарагийн <sup>12-18</sup> насны ангиуд Ням Гарагийн Заавар дахь хичээлүүдийг хэрэглэх болно. Чуулгууд, Залуу Эмэгтэйчүүдийн болон Ням Гарагийн ангиуд сар бүр Бурхан Тэргүүтэн гэх мэт адилхан сургаалаас суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэн зааснаар нэг нэгнийгээ хүчирхэгжүүлэхэд анхаарлаа түвлүрүүлж чадна.

#### Ням Гарагийн хичээлүүд ямар байх вэ?

Сар тутам хичээлүүд нь залуучуудад байж болох сайн мэдээний асуултууд дээр үндэслэсэн тодорхой сэдэв дээр түвлүрэх болно. — Нийт <sup>12</sup> сэдвийн — тус бүр нь багш нарын сонгож болох хэд хэдэн тоймоос бүрддэг. Хэрэв шаардлагатай бол нэг тойм дээр нэг долоо хоног илүү хугацааг зарцуулж болно. Сайн мэдээний сар тутмын сэдвийн талаар залуучууд нь туршлага болон бодлоо хуваалцсанаар сайн мэдээг заах нь ямар болохыг сурч, дадлагажих юм.

#### Сурах тоймуудад юу багтсан бэ?

Уг тоймуудад юуг мүн яаж заахыг хэлж үгүхгүй. Харин тэдгээр нь багш нарыг үүрсдүү сайн мэдээг эхэлж сурахад мүн залуучуудад сурах боломжийг бий болгож үгүхүд нь тусалдаг. Багш нар суралцагсдынхаа хэрэгцээ шаардлагад тохируулан зааж болно. Тойм бүрт Сүмийн удирдагчдын сүүлийн үед заасан зүйлсийг тогтмолоор шинэчлэн тавьж байх эшлэлүүд болон интернет холбоосуудыг багтаана.

#### Залуучуудын шинэ хичээлүүдийг хаанаас олж болох вэ?

Сурах тоймууд нь 'Аароны Санваар' Залуу Эмэгтэйчүүд болон Ням Гарагийн Хичээл бүгдээрээ тус тусдаа' [lds.org/youth/learn](https://lds.org/youth/learn) хаягаас олдоно. Интернетийн холболт байхгүй тэдэнд зориулан хэвлэж авсан хуулбарууд байх болно.

#### Ням гарагийн энэ шинэ заавар нь Мючелд нөлөөлөх үү?

Анги болон чуулгын ерүнхийлүгчийн зүвлүлийнхүн Мючелийн үйл ажиллагааг түлүвлүхдүү сар тутмын сэдвийг бодолцож үзэхийг урамшуулж байна. Сурах тойм дээрх үйл ажиллагааны санаанууд нь уг түлүвлүгүүний эхлэх шат нь байж болно. [lds.org/youth/learn](https://lds.org/youth/learn) хаяг руу орж тоймуудыг үзээрэй.

#### Эдгээр хичээлийг ямар хэл дээр үзэх боломжтой вэ?

Эдгээр хичээлийг Хятад (Кантон, Мандарин аялга), Дани, Нидерланд, Англи, Фижи, Финлянд, Франц, Герман, Унгар, Индонези, Итали, Япон, Солонгос, Монгол, Норвеги, Португали, Орос, Самоа, Испани, Швед, Тайланд, Тонга болон Украин хэлүүд дээр үзэх боломжтой байх болно. Эдгээр хэлээр ярьдаггүй сүмийн нэгжүүд нь үмнү нь хэрэглэж байсан сурах материалуудаасаа үргэлжлүүлэн үзэх болно.



Нэгдүгээр сард эхэлнэ –Ирээд, Намайг дага:  
Залуучуудад зориулсан сурах материал

## БИД ИХ ЭЗЭНИЙ ЗАМААР ХЭРХЭН ХАМТДАА СУРАЛЦДАГ ВЭ?

### Залуучууд

Их Эзэний замаар сурах гэдэгт судруудаас болон бошиглогч нарын үгсийг эрэлхийлж сайн мэдээний үнэнийг бусдад тайлбарлаж үгч мүн үүний дагуу амьдрах нь амьдралд чинь хэрхэн нүлүүлж байгаа талаар хуваалцан хичээлдээ сурах бэлтгэлтэй ирэх нь багтдаг.

### Багш нар

Амьдралд нь анхаарал тавьснаар та нар суралцагсдынхаа хэрэгцээг ойлгож тэдэнтэй харьцаа холбоо тогтоож тэднийг хувийн хүрвүүлэлтэнд хүргэх сурах туршлагуудыг бий болгож чадна. Уг шинэ хүтүлбүр нь сургаалыг ойлгоход та нарт туслах бүгүүд залуучуудыг сурах үйл явцад оролцуулах саанаануудыг үгүх болно. Энэ арга барилаар заах нь лекц уншихыг хэлж байгаа биш харин Сүнсээр удирдагдан ярилцлага үрнүүлэхийг хэлж байгаа юм.

### Эцэг эхчүүд

Хүүхдүүдийнхээ сурч байгаа зүйлсэд анхаарал хандуулах нь хүүхдүүддээ бие даан суралцахад нь туслах болно. Хүүхдүүд чинь гэр бүлийнхэндээ сурч байгаа зүйлсийнхээ талаар заахаар уригдаж болно. Тэдэнд ийм боломжийг үгснүүр гэрчлэл болон сайн мэдээг хуваалцах тэдний чадвар нэмэгдэнэ.



### Залуучуудын насанд хүрсэн удирдагчид

Энэхүү хүтүлбүр нь тойрог болон салбарт чинь хэрхэн хэрэгжиж байгаагийн хариуцлагыг та нар хүлээнэ. Байнгын сургалтыг явуулж мүн Их Эзэний арга барилаар заах жишээг үзүүлснээр багш нар энэхүү заах арга барилыг хэрэгжүүлж эхлэх болно. Залуучуудын хэрэгцээнд анхаарлаа түвлүрүүлж мүн залуучууд эцэг эхчүүд удирдагч багш нарт эдгээр хэрэгцээний талаар ярилцахад туслах арга замыг олж үгүүрэй. Энэхүү шинэ хүтүлбүр нь тойрог болон салбар дахь залуучуудын хүрвүүлэлтийг илүү амархан болоход туслах болно.

**Илүү мэдээллийг авахын тулд, Их Эзэний Арга барилаар Сайн мэдээг заах нь мөн [lds.org/youth/learn](https://www.lds.org/youth/learn) үзээрэй.**

ЕСҮС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

